

АМЬДРАХ УХААНД СУУРИЛСАН БИЧИГ ҮСГИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Нэг. УДИРТГАЛ

Бичиг үсгийн боловсрол бол хамгийн анхан шатны суурь боловсрол бөгөөд үүнээс эхлэн боловсролын цаашдын түвшингүүд болох бага, суурь гэхчлэн бусад боловсролын түвшингээр суралцах боломжтой билээ.

Дэлхий нийтийн томоохон зорилтууд болох Мянганы Хөгжлийн зорилт, Дакарын үйл ажиллагааны бүтэцчилсэн хүрээ-Бүх нийтийн боловсролын зорилт, “Бичигтэн” болох НҮБ-ын 10 жил болон НҮБ-ын Тогтвортой хөгжлийн боловсролын 10 жилийн хүрээнд бүх улс орны өмнө тулгарч буй нэгдмэл нэг зорилт бол хүн амынхаа бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэх замаар амьдрах, аж төрөх ухаанд сургах, амьдралын чанарыг дээшлүүлэн ядуурлыг бууруулах, байгаль орчинд ээлтэй амьдралын зөв зан үйл төлөвшүүлэх явдал юм. Тухайлбал, Дакарын үйл ажиллагааны бүтэцчилсэн хүрээ-Бүх нийтийн боловсролын 6 зорилтод тусгасан “нийт хүн амын бичиг үсгийн боловсролын түвшинг 50 хувиар дээшлүүлэх”, “залуус, насанд хүрэгчдийн амьдрах ухааны чадварыг дээшлүүлэх”, Мянганы хөгжлийн зорилтын “бүх нийтээр бага боловсрол эзэмших” зэрэг зорилтуудын хүрээнд улс орон болгон өөр өөрсдийн онцлогт тохирсон хэтийн болон дунд хугацааны төлөвлөгөө гарган мөрдөж байна. Манай улс Боловсролын салбарын мастер төлөвлөгөөндөө хүн амын бичиг үсгийн болон амьдрах ухааны боловсролын үйлчилгээг дээшлүүлэх, хүртээмж чанарыг сайжруулах талаар тодорхой зорилтуудыг (“Албан бус болон насанд хүрэгчдийн боловсрол” бүлэгт заасан) дэвшүүлсэн нь дээрх зорилтуудыг хэрэгжүүлэх хөшүүрэг болж байна.

Өнөөдөр дэлхийн хэмжээгээр 700 гаруй сая насанд хүрэгч бичиг үсэг мэдэхгүй байгаагийн дотор 60 гаруй хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Түүнчлэн сургуулийн гадна 300-аад сая хүүхэд байгаа нь бичиг үсэг үл мэдэгч насанд хүрэгчдийн тоо дорвитой буурахгүй байх хандлагыг илэрхийлж байгаа нь сэтгэл зовоосон асуудал болж байна. Манай орны хувьд ч бичиг үсгийн боловсролын түвшин харьцангуй өндөр боловч анхаарвал зохих асуудал байсаар байна. Тухайлбал, 2000 оны хүн ам, орон сууцны тооллогоор 15 ба түүнээс дээш насны бичиг үсэг үл мэдэгч 34 гаруй мянга байгаа хэмээсэн боловч энэ нь зөвхөн аман асуулганд үндэслэсэн тул учир дутагдалтай юм. Нөгөө талаар олон улсын болон зарим төрийн бус байгууллагуудын хийсэн судалгаагаар насанд хүрэгчдийн дотор бичиг үсэг үл мэдэх явдал тийм ч санаа зовохооргүй бус хэмжээнд байгааг илтгэж байна. Ганц жишээ дурдахад Албан бус боловсрол, зайны сургалтын үндэсний төвөөс 2005 онд боловсролгүй болон сургууль завсардсан гэх 1000 орчим хүний бичиг үсгийн боловсролын түвшинг тусгайлсан тестээр судалж үзэхэд 45 орчим хувь нь бичиг үсэгт огт тайлагдаагүй гэсэн дүн гарч байсан билээ. Энэ нь хэдийгээр цөөн хүнийг хамарсан боловч боловсролын түвшин доогуур гэгдэх иргэдийн бичиг үсгийн түвшинг олон улсын жишигт тохирсон тестээр шалгаж үзвэл ямар ч дүн гарч болзошгүйг харуулсан юм.

НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага-ЮНЕСКО-гоос боловсролын талаар баримталж буй тэргүүлэх чиглэлийн нэг нь “тэгш хамрах боловсрол” (inclusive education) буюу боловсролын тэгш байдал юм. Энэ нь нийгмийн гишүүн бүр, хүн бүр, нас, хүйс, оршин суух байдал, шашин шүтлэг, үндэстэн ястан, хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран боловсролын үйлчилгээг хүртэх эрхтэй бөгөөд үүнд сургалтын бүх шатны байгууллагын үүрэг нэн их билээ. Ялангуяа сургуулийн гадна буй хүүхэд, тухайн насандаа зохих шатны боловсрол эзэмшиж чадаагүй насанд хүрэгчид болон бичиг үсэг үл мэдэгчид, үндэсний цөөнхөд боловсролын үйлчилгээг тэгш үзүүлэхэд албан бус боловсролын байгууллагуудын гүйцэтгэх үүрэг их юм.

Сүүлийн жилүүдэд манайд сургуулийн гадна буй хүүхэд залууст боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэхэд нэлээд тодорхой ахиц гарч, сургуульд хамрагдалт нэмэгдэн, бичиг үсэг үл мэдэгч насанд хүрэгчдийн тоо буурч байгаа ч казах, тува иргэдийн дотор байдал төдийлэн сайжрахгүй байна. Энэ байдлыг өөрчилж, алслагдсан нутгийн хүн ам, түүний дотор үндэстний цөөнхийн боловсролыг дэмжих, боловсролын үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх талаар төрөөс анхаарч буйн нэг илрэл нь Монгол улсын засгийн газраас НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж буй “Монголын хөдөөгийн хүн амын амьдралын баталгааг нийгмийн иж бүрэн үйлчилгээгээр хангах нь” төсөл юм. Энэхүү төслийн нэг үндсэн зорилт болох “Хөдөөгийн хүн амд зориулсан албан бус боловсрол болон мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн иргэдийн сургалтын төв байгуулан улмаар бичиг үсэг тайлагдалтын хувийг нэмэгдүүлэх” (зорилт 2.1) зорилтын хүрээнд “Амьдрах ухаанд суурилсан бичиг үсгийн сургалтын хөтөлбөр”-ийг боловсруулан гаргаж байна.

Хөтөлбөрийн зорилго нь насанд хүрэгчдийн бичиг үсгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, улмаар амьдрах, аж төрөх ухаанд сурган амьдралын чанарыг дээшлүүлж, нийгмийн баталгааг хангах явдал юм.

Хөтөлбөрийн зорилт нь дараах хэд хэдэн хэсгээс бүрдэж байна. Үүнд:

- Бичиг үсэг үл мэдэгч насанд хүрэгчдийг бичиг үсэгт тайлах, ялангуяа үндэстний цөөнхийн бичиг үсэгт тайлагдалтын түвшинг нэмэгдүүлэхэд туслах
- Бичиг үсэг бага мэдэгч насанд хүрэгчдийн унших, бичих, тооцоолох мэдлэг чадварыг дээшлүүлэх замаар мэдлэг чадварын түвшинг ахиулах
- Бичиг үсгийн дараах сургалтаар дамжуулан амьдрах ба аж төрөх ухаанд суралцуулах, ингэснээр өрхийн орлогоо нэмэгдүүлж, амьдралын чанараа дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх
- Насанд хүрэгчдийн, ялангуяа алслагдсан нутгийн болон үндэстний цөөнхийн бичиг үсгийн боловсролыг дээшлүүлснээр бүх хүн амыг функциональ бичигтэн болгох

“Амьдрах ухаанд суурилсан бичиг үсгийн сургалтын хөтөлбөр”-ийг хэрэглэгч үндсэн **зорилтот бүлэг** нь бичиг үсэгт эхлэн суралцагч болон бичиг үсгийн дараах чадвараа дээшлүүлэхийг хүссэн насанд хүрэгчид, түүний дотор алслагдсан нутгийн хүн ам болон үндэстний цөөнх байх болно. Түүнчлэн албан бус боловсролын бичиг үсгийн сургалтын багш нар, бие даан суралцагч, бичиг үсгийн дараах сургалтаар дамжуулан амьдрах, аж төрөх ухаанд суралцагч хэн ч ашиглах боломжтой.

Сургалтын хөтөлбөрийг БСШУЯ-наас боловсруулан мөрдөж буй “Тухайн боловсролын үндэсний сургалтын хөтөлбөрийн бүтэц” (БСШУ-ны сайдын 2009 оны 202 тоот тушаалаар батлагдсан)-ийг үндэс болгон **а) “агуулгын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг”, б) хүлээгдэж буй үр дүн, в) “агуулга”** (мэдлэг, чадвар, хэрэглээ, үнэлгээ), **г) “арга зүй, д) “хэрэглэгдэхүүн”** гэсэн 5 хэсэгтэйгээр авч үзэв. Энэхүү бүтцийг тогтоосон зарчим ба хөтөлбөрт тодорхойлсон байдлыг тус бүрд нь авч үзье.

А. Агуулгын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг: Ази-Номхон далайн орнуудын туршлага, үндэстний цөөнхийн бичиг үсгийн боловсролын талаар ЮНЕСКО-гоос гаргасан судалгаа, зөвлөмжийг гол болгохоос гадна өөрийн оронд тулгамдаж буй асуудлууд, орон нутгийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон судалгааны дүн зэргийг үндэс болгон сургалтын хөтөлбөрийн агуулгын тогтолцоог дараах 6 бүрэлдэхүүн хэсэгтэйгээр авч үзэж байна. Үүнд:

1. Бичиг үсэг

Энэхүү хөтөлбөрийн “Бичиг үсэг” хэмээх бүлэг нь суралцагчдад эх хэлний хэм хэмжээний дагуу ярих, унших, бичих, тооны 4 үйлдэл хийх анхан шатны мэдлэг, чадвар эзэмшүүлэхэд чиглэх бөгөөд унших, ярих, бичих, тооцоолон бодох дадлага гэсэн гурван дэд сэдвээс бүрдэнэ. Унших дадлагын хэсэгт авиа зүйд суурилсан зөв бичих дүрмийг эзэмшүүлэхэд хялбар дөхөм байх үүднээс эгшиг, эгшигт гийгүүлэгч, заримдаг гийгүүлэгч, онцгой дөрвөн

гийгүүлэгч, туслах эгшгийг багцлан нүдлэх, зөв дуудаж сурах явцад үе, үг, өгүүлбэр, эх унших, том үсэг, цэг, тэмдгийн утгыг зөв ойлгож унших, эхийн утга санааг зөв ойлгох мэдлэг, чадвар эзэмшүүлнэ. Суралцах явцад ардын уламжлалт зан заншил, хүүхдийн хүмүүжил, өрхийн орлогын талаар уншиж, амьдрал ахуйдаа хэрэглэх дадлага хийх бөгөөд цаашид суралцагч өөртөө хэрэгтэй бүх мэдээллийг уншиж ойлгох, бусдад ярих дамжуулах чадвартай болох үүд хаалгыг нээх зорилготой юм. Бичих дадлагын хэсэгт үсэг, үе, үг, өгүүлбэр, цифр, тэмдгийг зөв технологиор бичих өөрийн болон гэр бүлийнхний овог нэрийг бичих, анкет бөглөх, өрхийн орлого, зарлага, малын тоо зэргийг бичиж тэмдэглэх дасгал хийх явцад зөв бичих анхан шатны мэдлэг, чадвар эзэмшүүлнэ. Тооцоолон бодох дадлагын хэсэгт арифметикийн 4 үйлдэл, цаг, урт, хүндийн хэмжүүрийн нэгжийн тухай анхан шатны мэдлэг, чадвар эзэмшүүлж, амьдрал ахуйд хэрэглэх дасгал хийнэ.

2. Эрүүл мэнд

Бид бичиг үсэгт сургаж, тоо бодохыг маш сайн заадаг хэрнээ аж амьдралаа төлөвлөх ур чадвар олгох, амьдралын эрүүл хэв маягийг төлөвшүүлэх, эрүүл мэндийн талаар хэрэгцээтэй мэдлэг, боловсролыг нь шаардлагын хэмжээнд хүртэл олгож чадахгүй байна. Гэтэл асар хурдтай өөрчлөгдөж буй өнөөгийн нийгмийн орчин насанд хүрэгчдэд төдийгүй хүүхэд, өсвөр насныхныг ч тойролгүй тэдэнд амьдралын томоохон сорилт, дарамт шахалт үүсгэж байгаа билээ. Иймд тус хөтөлбөрийн “Эрүүл мэнд” бүлгийг “Эрүүл мэндийн боловсролын стандарт”, “Бага, дунд боловсрол – эрүүл мэндийн боловсрол” зэрэг баримт бичигт тулгуурлан бусад бүлгийн агуулгатай давхардуулалгүй “Эрүүл бие”, “Гэр ахуйн эрүүл орчин” гэсэн 2 дэд сэдвийг судлуулах хэлбэрээр боловсруулсан болно. “Эрүүл бие” дэд сэдэвт хувийн эрүүл ахуй, хооллолт, хөдөлгөөн хэмээх хувь хүн бүрийн мэдвэл зохих, хүн болгоны өдөр тутмын амьдралд хэрэглэгдэх мэдлэг, чадварыг олгох агуулгыг багтаан өгсөн. “Гэр ахуйн эрүүл орчин” дэд сэдвийг судалснаар суралцагч амьдарч, ажиллаж буй орчныхоо эрүүл мэндийн асуудлыг шийдвэрлэх мэдлэг, чадвартай болох юм. Тус бүлгийн мэдээллийг багш заавал эрүүл мэндийн хичээлийн тусгай цаг гарган заах албагүй. Эрүүл мэндийн мэдээлэл өгч буй сэдвийг уншиж, бичиж, тоолж сурах явцад нь давхар өгөх боломжтой юм. Ингэснээр суралцагч бичиг үсэгт суралцах, бичиг үсгийн боловсролын түвшингээ дээшлүүлэх явцдаа өөрийн болон бусдын эрүүл мэнд, орчны эрүүл ахуйг сахин хамгаалж, эрүүл харилцааны ёс зүй, хэм хэмжээг баримталж сурна.

3. Амьдрах, аж төрөх ухаан

Амьдрах ухаан, амьжиргааны ухаан, аж төрөх ухаан гэж олонтаа сонсогдож, яригдаж байгаа өнөөгийн нийгэмд насанд хүрэгчдэд энэ талын боловсролыг бичиг үсгийн сургалттай хослуулан эзэмшүүлэхэд энэ бүрэлдэхүүн хэсгийн гол агуулга оршиж байна. Дээрх олон ухаантай хүнийг манай ахмад, хуучцуул “амьдралын хар ухаантай” гэж ярьдагчлан тэдгээрийг нэгтгэн “амьдрах, аж төрөх ухаан” гэж агуулгын тогтолцооны энэхүү бүрэлдэхүүн хэсгийг нэрлэсэн бөгөөд дунд шатны сургалтад хувь хүн талаас өөрийн зан байдлын төлөвшил болоод бусадтай харилцах харилцааны эерэг хандлагыг бий болгох, гүнзгий шатанд өрхийн орлого, амьжиргаагаа дээшлүүлэх агуулгуудыг багтаахыг хичээлээ.

Шат бүрийн агуулгын бүрэлдэхүүн хэсгүүд дотроо дэд сэдвүүдээс тогтох ба сургалтын арга зүйд дурдсанчлан суралцагчийн хэрэгцээ, сонирхлын дагуу сонгон судална. Түүнчлэн үнэлгээ, арга зүйд байгаа зөвлөмж, хүснэгт г.м зүйлийг үлгэрчилсэн загвар байдлаар гаргасан тул бусад агуулгын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэгт нийцүүлэн ашиглах боломжтой.

4. Иргэний ухамсар

Хүн амын бичиг үсгийн чадварыг дээшлүүлэх замаар өөрийн болон гэр бүл, нийгмийн өмнө хүлээх үүрэг, хариуцлагаа ухамсарладаг хувь хүнийг төлөвшүүлэхэд энэхүү хэсэг чиглэгдэнэ. Агуулгын тогтолцооны энэхүү бүрэлдэхүүн хэсэг нь 1) *Хувь хүний ухамсар*, 2) *Гэр бүлийн ухамсар*, 3) *Нийгмийн ухамсар* гэсэн гурван дэд хэсэгтэйгээр бичиг үсгийн дунд болон гүнзгий шатны сургалтанд хэрэглэгдэнэ.

5. Мал, малын бүтээгдэхүүн

Мал бол монгол хүний гол амь зуулга, Монгол улсын эдийн засгийн эх үндэс, эрхлэх үндсэн аж ахуй нь билээ. Үүнээс гадна монгол үндэстэн угсаатны язгуур соёл цөм малтайгаа холбогддог. Монгол хүний ахуй амьдрал, ажил хөдөлмөр, зан заншил, ёс суртахуун, сурган хүмүүжүүлэх ухаан, гүн ухаан, шашин шүтлэг, хууль цааз, дайн байлдаан, үүх түүх, урлаг соёл, аман ба бичгийн уран зохиол, зугаа цэнгэл, наадам тоглоом гээд оюуны бүх л хүрээнд түүнчлэн оромж сууц, хувцас хунар, хоол унд гээд эд өлгийн бүхий л төрөлд малын тухай соёл нэвт шингэн хадгалагдсан байдаг.

“Мал, малын бүтээгдэхүүн” хэмээх энэхүү бүрэлдэхүүн хэсэг нь сургуулийн гадна буй насанд хүрэгчдэд мал маллах арга ухаанд суурилан тэдний бичиг үсгийн чадварыг дээшлүүлэх албан бус сургалтыг ерөнхий удирдамжаар хангана. Агуулгын тогтолцооны энэхүү бүрэлдэхүүн хэсэг нь 1) *Мал маллах арга ухаан*, 2) *Малын хишиг буян* гэсэн хоёр дэд хэсэгтэйгээр бичиг үсгийн дунд болон гүнзгий шатны сургалтанд хэрэглэгдэнэ.

6. *Байгаль орчин*

Хүн төрөлхтний амьдарч буй энэ зуунд дэлхий дахинд нэн тулгамдсан асуудлын нэг нь байгаль орчны асуудал юм. Хүн өдөр тутам хүрээлэн буй орчинд нь хэрхэн өөрчлөлт орж буйг мэдэрдэггүй боловч хүн ба байгаль орчны харилцаа хэвийн хэмжээнээс хэтэрч, бүр аюулын гэмээр байдалд орж байгааг олон улс оронд хүлээн зөвшөөрч байна. Өөрөөр хэлбэл экологийн аюул нүүрлээд байгаа энэ эрин үед түүнийг бүрмөсөн таслан зогсоож чадахгүй ч багасгах, сааруулах, өнөөгийн байдлыг нь хадгалан үлдээх хамгийн гол арга зам бол бүх нийтээр боловсрол, мэдлэгээ дээшлүүлэх явдал юм.

Экологийн аюулд манай орон ч өртөх нь гарцаагүй тул одоохондоо унаган төрх нь алдагдаагүй байгаа байгаль орчноо хамгаалах, хадгалах, нийгмийн орчинд ая тухтай аж төрөхөд нэмэр болох үүднээс энэ сэдвийг сонгон оруулсан болно.

Бүх насны хүн амын экологийн боловсролыг дээшлүүлэх, цэвэр орчинд ая тухтай аж төрөхөд туслах, байгаль орчноо хадгалан хамгаалах үзэл бодол, мэдлэг төлөвшүүлэхэд сургалтын зорилго оршино.

Энэ агуулгын тогтолцооны бүрэлдэхүүн хэсгийг дараах чиглэлээр ашиглаж болно. Үүнд:

- хүүхэд, насанд хүрэгчдэд зориулсан сургалт явуулах
- орон нутгийн иргэдэд яриа таниулга хийх
- сургуулийн сурагчдад хичээлээс гадуур дугуйлан, нэмэлт сургалт зохион байгуулах
- хаягдал зүйлсийг ашиглан ахуйн хэрэгцээт зүйлс хийх зэрэг.

Б. Хүлээгдэж буй үр дүн: Агуулгын тогтолцооны тухайн бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд мэдлэг чадвар эзэмшиж, түүнийгээ амьдралд хэрэглэн, суралцах үйл ажиллагаанаас хүлээгдэж буй үр дүнг 4-5 төрлөөр тус бүрд нь тодорхойлов. Эдгээр үр дүн нь бичиг үсгийн сургалтын түвшин болон агуулгын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг бүрийн агуулгаас хамаарч өөр өөр онцлогтой. Жишээ нь, *“Бичиг үсэг”-ийн анхан шатны сургалтанд хүлээгдэж буй үр дүнд:*

- Орчин цагийн монгол хэлний дуудлагын хэм хэмжээний дагуу зөв ярих
- Өөртөө болон бусдад унших (минутанд 50-аас доошгүй үг), ойлгох
- Бичмэл эх сурвалжаас мэдээлэл авах, ашиглах, хэрэгцээтэй зүйлээ бичиж тэмдэглэх
- Намтар, захидал, зурвас бичих, тэмдэглэл хөтлөх
- Ахуйн тооцоо хийх, өрхийн орлогоо нэмэгдүүлэх
- Эцэг эхийн үүрэг, хүүхдийн хүмүүжлийн талаар мэдээлэл авах, ашиглах
- Цаашид бичиг үсгийн чадвараа сайжруулах, бие даан сурах эрмэлзэлтэй болох

“Иргэний ухамсар”-ын дунд шатны сургалтын үр дүнд:

- Өөрийгөө болон бусдыг хүндэтгэх ухамсар, соёл, ёс зүйн талаар мэдлэгтэй болно
- Хувь хүний зүгээс гэр бүл, нийгмийн амьдралд оролцох оролцоо, холбогдох хууль хийгээд ёс зүйн дүрмүүдийг хэрэгжүүлэх чадвартай болно
- Өөрийгөө хөгжүүлэх, гэр бүл, өвгөд хөгшдөө энэрэн хамгаалах, амьдралаа авч явах чадвартай болно

- Гэр бүл, хамт олон, нийгэмдээ үлгэр жишээ үзүүлдэг, нутаг орны хөгжилд хувь нэмэр оруулахаар бусадтай хамтран ажилладаг иргэн болон төлөвшинө г.м

В. Агуулга: Агуулгын мэдлэг, чадвар, хэрэглээ гэсэн гурван хэсгийг дараах байдлаар хүснэгтээр үзүүлэв. Тухайлбал, “Эрүүл мэнд” хэсгийн хүрээн дэх “мэдлэг, чадвар, хэрэглээ”-ний зарим жишээг авч үзье:

Мэдлэг	Чадвар	Хэрэглээ
• Амны хөндийн эрүүл ахуй • Арьс, үс, хумс, гар хөлний арчилгаа • Хувийн ариун цэврийн хэрэгслүүд	• Арьс, үснийхээ онцлогт тохирсон гоо сайхны бүтээгдэхүүнийг зөв сонгож, хэрэглэх • Сүү, өндөг, хүнсний ногоо зэргийг гэрийн нөхцөлд ашиглан арьс, үсээ арчлах • Хувийн ариун цэврийн хэрэглээ зөв сонгож, арчилж, ашиглах • Биеийн болон улирлын онцлогт тохируулан хувцаслах • Эмийн заавар, хүнсний барааны шошго унших, зөв хэрэглэх	• Шүдээ тогтмол зөв угаах, арчилах • Гоо сайхны бүтээгдэхүүний зөв сонгож, хэрэглэдэг байх • Биеэ арчилж, ариун цэврийг тогтмол сахих • Хувийн ариун цэврийн хэрэгслээ бусадтай сольж хэрэглэхгүй байх • Биеийн онцлог, тодорхой нөхцөл байдалд тохируулан хувцаслах
• Уламжлалт хоол хүнс – сүү, махан бүтээгдэхүүн • Хоол хүнс гэрийн нөхцөлд бэлтгэх арга /айраг, ааруул, мойлтой тос, эззгий, цөцгий, арвайн гурил, борц, каз, бесбармак г.м./	• Үндэстэн, ястны цөөнх хүн амын хэрэглэж ирсэн уламжлалт хоол, хүнсийг боловсруулах, бэлтгэх • Хүнсээ зөв хадгалах • Өрхийн 7 хоногийн хоолны цэс гаргах, хоолны нэр төрлийг олшруулах	• Хүнсний бүтээгдэхүүн сонгохдоо хугацааг харж занших • Зөв зохистой хооллох дэглэм баримтлах • Эрүүл мэндээ хамгаалах зорилгоор зарим хоолноос татгалзах

Эдгээрийг тус бүрд нь тайлбарлая.

- **“Мэдлэг”** баганад агуулгын тогтолцооны тухайн бүрэлдэхүүн хэсгийн хүрээн дэх хүлээгдэж буй үр дүнд хамаарах үндсэн мэдлэгүүдийг тодорхойлов. Эдгээр нь тухайн хэсгийн агуулгаасаа хамаараад баримтын, ухагдахууны болон арга үйлдлийн (процедур) мэдлэгийн төрлүүдээс бүрдэж байна. Жишээ нь: “Бичиг үсэг” гэсэн анхан шатны суралцагчдын судлах хэсгийн хүрээнд бол “унших ярих дадлага”, “бичих дадлага”, “тооцоолж бодох” гэх зэрэг баримтын мэдлэг голлож байна. Харин бичиг үсгийн сургалтын дунд шатанд бол ухагдахууны мэдлэг нэлээд түлхүү орсон болно. Жишээ нь: “Эрүүл мэнд” хэсэг дээр буй “эм хэрэглээ”, “архи тамхины хор уршиг” гэх мэт, “Байгаль орчин” хэсгийн хүрээн дэх “байгалийн гамшигт үзэгдэл”, “хог хаягдлын төрлүүд” гэх мэтээр тодорхойлсон нь ухагдахууны мэдлэг юм.

Арга-үйлдлийн мэдлэгийн төрөл нь голчлон бичиг үсгийн сургалтын гүнзгийрүүлсэн шатанд хэрэглэгдэх бөгөөд энэ нь тухайн хэсгийг судалснаар амьдрал, аж төрөлд хэрэгтэй ямар зүйлсийг хийж, гүйцэтгэх сурахад хэрэгтэй арга, технологи зэргийг илэрхийлж байна. Жишээ нь: “Эрүүл мэнд” хэсэг дээр буй “Сүү, хүнсний ногоогоор бүрхэвч, түрхлэг хийх арга” гэх мэт, “Иргэний ухамсар” хэсэг дээрх “олон нийтийн газар биеэ зөв авч явах соёл” гэх мэт, “Амьдрах аж төрөх ухаан” хэсгийн хүрээнд буй “хоол хүнс гэрийн нөхцөлд бэлтгэх арга” зэрэг нь арга-үйлдлийн мэдлэг болно.

- **“Чадвар”** баганад агуулгын тогтолцооны тухайн бүрэлдэхүүн хэсгийн үндсэн асуудлыг шийдэх арга ба үйлийг тодорхойлсон бөгөөд энэ нь харилцааны, тооцоолол

мэдээллийн, хувийн зохион байгуулалт болон өрсөлдөхүйн, нийгэмшихүйн чадварын төрлүүдийг хамарч байна. Жишээ нь: Бичиг үсгийн анхан шатны суралцагчид “гийгүүлэгчийг зөв таних, дуудах, үзсэн үсгээр үе, үг бүтээх”, “том үсэг, цэг, тэмдгийн утгыг зөв ойлгож унших”, “өөрийгөө болон гэр бүлийнхнээ танилцуулах (амаар)”, “хүсэл сонирхол, боломж, бэрхшээлийнхээ талаар ойлгомжтой ярих” гэх мэт, агуулгын тогтолцооны “Мал, малын бүтээгдэхүүн” хэсгийн хүрээнд бол “малын тоног төхөөрөмж, хэрэгсэл хийх”, “малын өвчнийг гэрийн нөхцөлд эмчлэх”, “Байгаль орчин” хэсгийн хүрээнд “хог хаягдлыг ялгах, ангилан хаях”, “дахин ашигладаг ба ашиглагддаггүй хог хаягдлыг ялгах тэмдэглэгээг уншиж, ашиглах” гэх мэт

Түүнчлэн чадварыг тодорхойлохдоо аль болох суралцагчийн бичиг үсгийн чадварын хөгжил, амьдралын хэрэгцээ болон орон нутгийн онцлог, үндэстэн ястны уламжлал зан заншилтай нь холбохыг зорилоо. Тэр бүр “нутгийн уламжлал, зан заншил”-ыг тодруулаагүй ч угтаа тухайн чадварыг бичиг үсгийн багш болон суралцагч өөрсдийн туршлага, боломжид түшиглэх нь зүйтэй юм. Жишээ нь: “цагаан идээг амтлаг болгоход жимс жимсгэнэ, байгалийн гаралтай бүтээгдэхүүн хэрэглэх” гэсэн чадварын хүрээнд тухайн нутгийн онцлог ба нутгийн зан заншилд тохирсон ямар аргыг сонгон авах нь бичиг үсгийн багш болон суралцагчдад нээлттэй байх болно.

- **“Хэрэглээ”** баганад агуулгын тогтолцооны тухайн бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн хүрээнд эзэмшсэн мэдлэг, чадвар үйлийн баримжааг ашиглан амьдрал, аж төрөлдөө хэрхэн хэрэглэх, тулгарсан асуудлыг хэрхэн шийдвэрлэхийг тодорхойлов. Өөрөөр хэлбэл “дотоод ба гадаад хэрэглээ”-ний аль алиныг нь тусгасан болно. Ялангуяа өдөр тутмын амьдралын байдлыг (контекст) ойлгох, бичиг үсгийн анхан болон дунд, гүнзгий шатны түвшин бүрээр суралцагч амьдралд тохиолдсон асуудлаа шийдвэрлэх, бусдад тайлбарлан таниулж дамжуулах, үр хүүхэд, айл саахалтындаа туслах, өөрсдийн нийгэм дэх байр сууриа нэмэгдүүлж, амьдрах чадвараа дээшлүүлэх, харилцаанд суралцах, хэрэглэх талаар түлхүү тодорхойлон орууллаа. Ингэснээр бичиг үсгийн суралцагч мэдлэг чадвараа дээшлүүлэх, аливаа асуудлыг эргэцүүлэн бодох, амьдралд хэрэгтэй шийдвэр гаргахдаа өмнөх туршлага, сургалтын явцад эзэмшсэн шинэ мэдлэг, чадвараа нэгтгэн хэрэглэх боломжийг олгож байна.

“Хэрэглээ”-г тодорхойлохдоо бодит амьдралын жишээ, орон нутгийн болон үндэстэн зан заншлын нөхцөл байдал дээр жишээлэн илэрхийлэх чиглэлийг гол болгов. Жишээ нь: “Эмийн заавар унших, ашиглах” “хаяг, зарлал, реклам унших”, “телевизийн хөтөлбөр унших” (“Бичиг үсэг” хэсэг дээр), “хүнсний бүтээгдэхүүн худалдан авахдаа үйлдвэрлэсэн хугацааг харж занших”, “биеийн үндсэн үзүүлэлтийг ашиглаж, биеийн жингээ хэвийн байлгахад анхаарах” (“эрүүл мэнд” хэсэг) гэх мэт.

- **Үнэлгээ:** Энэ хэсэг нь агуулгын нэг бүрэлдэхүүн боловч хүснэгтийн багана болгон үзүүлэхэд тохиромжгүй тул дээр дурдсан “мэдлэг, чадвар, хэрэглээ” тус бүрийн дараа оруулав. Үнэлгээ хэсэгт тухайн сэдвийг судалснаар хүлээгдэж буй ямар үр дүнд хүрэхийг илрүүлэх шалгууруудыг эхэнд нь жагсаан бичиж, зарим жишиг даалгавар, түүнийг хэрхэн үнэлэх зааврыг оруулсан болно. Өөрөөр хэлбэл, эдгээр шалгуур үзүүлэлт тус бүрээр үнэлгээ хийснээр тодорхой сэдвийн хүрээнд бичиг үсгийн боловсрол эзэмших үйл явцын үр дүнг сайжруулах, анхан шатны болон дараах шатны түвшинд суралцагчдын мэдлэг, чадвар, хандлага хэрхэн хөгжин дэвшиж байгааг тодруулахад зориулагдах болно.

Албан боловсролын сургалтаас ялгаатай нь насанд хүрэгчдийн бичиг үсгийн сургалтын явцад багш суралцагчийг байнга дагаж, анхаарч, туслан үнэлэх боломжгүй тул зарим тохиолдолд суралцагч өөрөө өөрийгөө үнэлэх даалгаврыг түлхүү оруулав. Энэ нь насанд хүрсэн суралцагч тул бие даан суралцах, мэдлэг боловсролоо дээшлүүлэх хандлага төлөвшихөд ч тустай хэмээн үзэж байна.

Г. Арга зүй: Энэхүү сургалтын хөтөлбөрийн арга зүй нь үндсэндээ БСШУЯ-наас гарган баримталж буй Бага, дунд боловсролын стандартын арга зүйн хөгжлийн зарчимд

үндэслэсэн бөгөөд агуулгын тогтолцооны хэсэг тус бүрийн агуулга, бичиг үсгийн боловсролын түвшин, насанд хүрсэн суралцагчдын амьдралын туршлага, сэтгэхүйн түвшин, хандлага зэрэг онцлогийг тусгасан тул хэсэг тус бүрд тусад нь тодорхойлж зарим нэгийг нь жишээгээр дэлгэрүүлэв. Энэ нь бичиг үсгийн сургалтын багшийн ачаалал, суралцагчийн бие даан судлах боломж зэргийг харгалзан мэдлэг чадвараа дээшлүүлэх хэрэгцээг бий болгох, бичиг үсгийн сургалтын явцад сонсох, унших, бичих, тооцоолох, ярилцах ба шийдвэр гаргах зэрэг үйлийн харилцааг илэрхийлэх боломжийг олгож байна. Ялангуяа бичиг үсгийн анхан шатны сургалтын түвшинд унших, бичих болон арифметикийн үйлийн дадлага хийх арга зүй нь насанд хүрсэн суралцагч багшаар заалгахаасаа илүүтэйгээр үсэг тоогоо бичиж, нүдэлж, үг холбож, анхан шатны үйлдлүүдийг хийж сурсны дараагаас цаашид бие даан суралцахад чиглэгдсэн болно.

Д. Хэрэглэгдэхүүн: Агуулгын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг тус бүр дээр хэрэглэгдэх ном, сурах бичиг, гарын авлага нэмэлт материалыг дурдсан бөгөөд эдгээр нь бичиг үсгийн анхан шатны болон дунд, гүнзгий шатны сурах бичгүүд, бичиг үсгийн дараах сургалтын материалууд болон амьдрах ухаан, эрүүл мэнд, аж төрөх ухаан, байгаль орчны болон тогтвортой хөгжлийн боловсролд зориулсан материалуудыг ч багтааж байна.

Ийнхүү сургалтын хөтөлбөрийн дээрх бүтэц агуулгын тогтолцооны 6 бүрэлдэхүүн хэсэг тус бүрдээ дараах байдалтайгаар давтагдаж байна:

Агуулгын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг: Нэр			
Хүлээгдэж буй үр дүн:			
Агуулга:			
	мэдлэг	чадвар	хэрэглээ
Үнэлгээ			
Аргазүй			
Хэрэглэгдэхүүн			

Сүүлийн жилүүдэд АББЗСҮТ-өөс насанд хүрэгчдэд зориулсан бичиг үсгийн анхан болон дунд, гүнзгий шатны сурах бичиг, бичиг үсгийн дараах сургалтын нэлээд материал бэлтгэн гаргасныг аймаг орон нутаг дахь Гэгээрлийн төвүүдээр дамжуулан хэрэглэж байна. Гэвч сургалтын материал хүссэн хүн бүрт хүрэлцээгүй, орон нутгийн онцлог, суралцагчдын хэрэгцээнд нийцэхгүй байх тохиолдол ч зарим үед гарч байна. Алслагдсан нутгийн хүн ам, ялангуяа казах, тува зэрэг үндэстний цөөнхийн хэрэгцээ шаардлагад тохирсон бичиг үсгийн болон амьдрах ухааны сургалтын материал дутагдалтай хэвээр байна.

Түүнчлэн бичиг үсгийн сургалтад зориулан ашиглах бусад хэрэглэгдэхүүн, бичиг үсгийн мэдлэг чадвараа дээшлүүлэх замаар амьдрах ухааны чадвар эзэмшихэд зориулсан бусад хэрэглэгдэхүүнийг бичиг үсгийн багш болон суралцагч өөрсдөө хэрхэн бэлдэж хэрэглэх талаар дурдсан болно. Жишээ нь: эмийн заавар, эрүүл мэндийн зөвлөгөө, ашигтай зөвлөгөө зэрэг сонины хайчилбар, цуглуулга хийж ашиглах, архи тамхины хор хөнөөлийн талаарх олон нийтэд зориулсан мэдээлэл, зурагт хуудас, танилцуулга, өргөдөл болон зээлийн гэрээ үйлдэх маягт, тэдгээрийг бөглөх гэхчлэн сургалтанд хэрэглэж болох бусад боломжийг эрж хайх, ашиглах замаар бичиг үсгийн сургалтын хэрэглэгдэхүүнийг баяжуулах боломжтой юм.

Хоёр. ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Олон улсын практикт бичиг үсгийн боловсролын түвшинг зөвхөн уншиж, тоо тоолж чадаж байгаа эсэхээр төдий бус уншиж, бичиж, тоолох чадвараа амьдралдаа хэрхэн хэрэглэж, шийдвэр гаргахад ашиглаж байгаагаар нь авч үздэг. Энэ үүднээс ч “бичиг үсгийн анхан шатны” (буюу бичиг үсэгт тайлагдах-basic literacy) ба “бичиг үсгийн дараах (post literacy) шатны” сургалтын түвшинг ялган аль ч түвшингийн хувьд агуулга нь суралцагчдын амьдралын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байхаас гадна бичиг үсгийн сургалтаар дамжуулан амьдрах ухаанд суралцах үйлийг гол болгодог билээ.

Бичиг үсгийн сургалтын хөтөлбөр боловсруулахад энэхүү чиг баримжааг гол болгон авч үзсэн бөгөөд ялангуяа хөтөлбөрийн агуулга нь бичиг үсэгт тайлагдсаны дараа суралцагчид бодит амьдралдаа хэрэг болохуйц сэдвийг уншиж судлах явцдаа анхан шатны мэдлэг чадвараа улам сайжруулан бататгаж, улмаар бичиг үсгийн функциональ түвшинд хүрэх боломжийг олгоход чиглэгдсэн болно. Тухайлбал, эмийн заавар, хүнсний шошго, цаг агаарын мэдээ уншиж ашиглах, тэдгээрийг тэмдэглэсэн таних тэмдгийг ялгах, үр хүүхэддээ тайлбарлах зэрэг нь улмаар функциональ түвшинд хүрэхэд суралцагчдад тустай юм.

Бичиг үсгийн сургалтын хөтөлбөрийг боловсруулахад дараах материалыг тулгуур болгов. Үүнд:

- *Бага, дунд боловсролын куррикулум болон стандартыг шинэчлэн хөгжүүлэх үзэл баримтлалт тулгуурласан тухайн боловсролын үндэсний сургалтын хөтөлбөрийн бүтэц (БСШУ-ны сайдын 2002 оны 202 дугаар тушаалын хавсралт)*
- *ЮНЕСКО-гийн тэргүүлэх чиглэлүүд, тэдгээрийн үзэл санаа*
- *Ази-Номхон далайн орнуудын бичиг үсгийн сургалтын талаар гарсан материалууд*
- *Боловсролын салбарын мастер төлөвлөгөө*
- *Бичиг үсгийн боловсролын сургалтын хөтөлбөр (АББЗСҮТ., 2003)*
- *Үндэсний цөөнхийн хэрэгцээний судалгаа (АББЗСҮТ., 2010)*

Сургалтын хөтөлбөрийг боловсруулахаас өмнө бичиг үсгийн хэрэгцээний судалгаа авсан бөгөөд энэхүү судалгаанаас гарсан үр дүнд тулгуурлан агуулгын тогтолцооны бүрэлдэхүүн хэсгүүдийг сонгон авснаас гадна хөтөлбөрийн сургалтын түвшинг 1) *анхан*, 2) *дунд*, 3) *гүнзгий* хэмээн гурав ангилав. Гэвч агуулга, аргазүйг боловсруулах явцад агуулгын тогтолцооны бүрэлдэхүүн хэсгүүдийг өөр өөрөөр хуваарилах шаардлага гарсан болно. Тухайлбал, анхан шатанд бичиг үсэгт эхлэн тайлагдахад зориулсан агуулгаас гадна өдөр тутмын амьдралд тохиолдох үйлүүдтэй холбож өгөв. Энэ нь амьдралын хамгийн наад захын шаардлага болох биеийн байцаалт бөглөх, намтар бичих, гэр бүлийн гишүүдийн нэр усыг бичих уншихаас эхлээд гэр бүлийн орлого зарлагаа тооцоолох, ажилд орох өргөдөл бичих зэрэг өргөн агуулгыг хамрах тул дунд түвшинд ч мөн давтагдаж байна. Харин гурав дахь түвшинд бол агуулгын тогтолцооны бусад бүрэлдэхүүн хэсгүүдийг гүнзгийрүүлэн судлахаар бодож орууллаа. Энэхүү хуваарилалтаас үүдэн бүрэлдэхүүн хэсэг тус бүрийг судлах цагийн хувьд ч ялгавартай байхаар тооцож, сургалтын төлөвлөгөөнд тусгалаа. *(Сургалтын төлөвлөгөөг харна уу.)*

Гурав. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ЕРӨНХИЙ ҮР ДҮН

Бичиг үсгийн сургалтын хөтөлбөрийн хүлээгдэж буй үр дүнг дараах байдлаар томъёолж байна. Үүнд:

1. Тодорхой сэдвийн хүрээнд сонсох, ярих, унших, тооцоолох, бие даан суралцах чадвартай болох
2. Бичиг үсгийн мэдлэг, чадвараа ашиглан амьдрал ахуйд хэрэгцээт мэдээллээ олж унших, зөв шийдвэр гаргах
3. Бичиг үсгийн анхан шатны мэдлэгт тулгуурлан өөрийгээ дайчилж, бие даан суралцах чадвараа хөгжүүлэх, суралцах, өрхийн орлогоо нэмэгдүүлэх, амьдрал ахуйгаа дээшлүүлэх хүсэл эрмэлзэлтэй болох
4. Эрүүл мэндийн бичиг үсгийн боловсрол эзэмшиж, амьдралд хэрэгцээт мэдээллээ уншиж ашиглах, зөв хооллох, эрүүл аж төрөх, эрүүл мэндийнхээ төлөө өөртөө болон бусдад анхаардаг дадал хэвшилтэй болох
5. Иргэний эрх үүргээ ухамсарлан биелүүлэх, аж амьдралд холбоотой хууль дүрмийг сахих, иргэний эрх зөрчигдсөн үед хандах газраа зөв сонгон, санаа бодлоо бичгээр болон амаар илэрхийлэх мэдлэг чадвар эзэмших
6. Хүрээлэн буй орчноо сайн мэддэг, хайрлан хамгаалах ухамсартай, байгаль орчноо ажиглах, жиших, харьцуулах, шийдвэр, дүгнэлт гаргах чадвартай иргэн хүн төлөвших

Дөрөв. БИЧИГ ҮСГИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА

Бүлэг 1. АНХАН ШАТ

1.1. Бичиг үсэг

Бүлэг 2. ДУНД ШАТ

- 2.1. ЭРҮҮЛ МЭНД
- 2.2. АМЬДРАХ, АЖ ТӨРӨХ УХААН
- 2.3. ИРГЭНИЙ УХАМСАР
- 2.4. БАЙГАЛЬ ОРЧИН
- 2.5. МАЛ, МАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН

Бүлэг 3. ГҮНЗГИЙ ШАТ

- 3.1. ЭРҮҮЛ МЭНД
- 3.2. АМЬДРАХ, АЖ ТӨРӨХ УХААН
- 3.3. ИРГЭНИЙ УХАМСАР
- 3.4. БАЙГАЛЬ ОРЧИН
- 3.5. МАЛ, МАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН

Агуулгын тогтолцооны бүрэлдэхүүн хэсгүүд

1.1. БИЧИГ ҮСЭГ

Хүлээгдэж буй үр дүн

- Орчин цагийн монгол хэлний дуудлагын хэм хэмжээний дагуу зөв ярих
- Өөртөө болон бусдад унших (минутанд 50-аас доошгүй үг),ойлгох
- Бичмэл эх сурвалжаас мэдээлэл авах, ашиглах, хэрэгцээтэй зүйлээ бичиж тэмдэглэх
- Намтар, захидал, зурвас бичих, тэмдэглэл хөтлөх
- Ахуйн тооцоо хийх, өрхийн орлогоо нэмэгдүүлэх

- Эцэг эхийн үүрэг, хүүхдийн хүмүүжлийн талаар мэдээлэл авах, ашиглах
- Цаашид бичиг үсгийн чадвараа сайжруулах, бие даан сурах эрмэлзлэлтэй болох

Дэд сэдэв	Агуулга		
	Мэдлэг	Чадвар	Хэрэглээ
1.1. Унших, ярих дэдлага	Богино (а, э, и, о, у, ө, ү), урт(аа, ээ, ий, оо, уу, өө, үү), хос (ай, эй, ой, уй, үй) эгшиг, эр (а, о, у), эм (э, ө, ү), саармаг(и) эгшиг, асуух, анхааруулах тэмдэг (? , !)	- Урт, богино, хос, эгшгийг, таних, зөв дуудах, - Үзсэн үсгээс бүтсэн үг, өгүүлбэр унших	Загвар: - А,О,У 3 уу? - А,О,У 3 - Э,И,Ө,Ү 4 үү? - Э,И,Ө,Ү 4
	- Эгшигт гийгүүлэгч(м, н, г, л, б, в, р), том үсэг, цэг тэмдэг, - Заримдаг гийгүүлэгч (д, т, ц, ч, з, ж, ш, с, х) - Үе, үг, холбоо үг, өгүүлбэр	- Гийгүүлэгчийг зөв таних, дуудах, үзсэн үсгээр үе, үг бүтээх, - Том үсэг, цэг, тэмдгийн утгыг зөв ойлгож унших - Өөрийнхөө болон гэр бүлийнхнээ танилцуулах (амаар) - Хүсэл сонирхол, боломж, бэрхшээлийнхээ талаар ойлгомжтой ярих	- Зүйр цэцэн үг, ардын аман зохиолоос унших, цээжлэх (Бардам үгээр цэцэн болохгүй Балмад үйлээр баатар болохгүй г.м.) харилцаандаа хэрэглэх - Өөрийгөө илэрхийлэх, бусадтай хамтран ажиллах, дэмжлэг тусламж авах
	Онцгой 4 гийгүүлэгч (к, п, ф, щ,)	- Онцгой 4 гийгүүлэгчийг дуудах, - Онцгой 4 гийгүүлэгчтэй үе, үг, өгүүлбэр унших,	- Эмийн заавар унших, ашиглах - Хаяг, зарлал, реклам унших - Телевизийн хөтөлбөр унших
	Туслах эгшиг (я, е, ё, ю, ы, й,) тэмдэг (ъ, ь) үсэг,	Туслах эгшигтэй өгүүлбэр, эхийг зөв унших, утгыг ойлгох	Сонин, зурагт хуудас, бичиг үсгийн болон бичиг үсгийн дараах боловсролын ном ашиглах
	Унших хурд, ойлгох чадварыг сайжруулах дасгалын сэдэв: - Эсгий эдлэл, монгол дээл, нэхмэл, хатгамал, зүймэл эдлэл, малын тоног төхөөрөмж хийх технологи, материал, тоног төхөөрөмж (сонголтоор) - Өрхийн уламжлал, зан заншил - Аав, ээжийн ачийг дээдлэх ёс - Эцэг эхээс хүүхдийнхээ төлөө хүлээх үүрэг, хариуцлага - Хүүхдийн хүмүүжил-монгол уламжлал	- Гэртээ үйлдвэрлэж болох бүтээгдэхүүний технологийг уншиж ойлгох, - Гол санааг олж тэмдэглэх, хуулан бичих - Найз нөхдөддөө ярьж тайлбарлах хамтран ажиллах - Хүүхдийн хүмүүжил, ээж аавын ач, ариун нандин ёс журмын тухай дуу, шүлэг, үлгэр оньсого, уран зохиол унших - Хүүхдийнхээ өмнө хүлээсэн үүргээ ухамсарлах, биелүүлэх, бусдад шаардлага тавих	- Сургуулийн өмнөх насны хүүхдэд үлгэр уншиж өгөх, зүйр цэцэн үг, оньсого, таавар, шүлэг цээжлүүлэх, - Уран зохиол, кино, жүжгийн баатраас сайн үлгэр дуурайл авах - Үлгэр,тууль, зүйр цэцэн үг, сургаал үгсийг харилцаандаа ашиглах - Ашиг олох мэдлэг, туршлагын талаар мэдээлэл цуглуулах, уншиж, тэмдэглэх - Өрхийн үйлдвэрлэлийн технологи (Эсгий эдлэл, монгол дээл, нэхмэл, хатгамал, зүймэл эдлэл, малын тоног төхөөрөмж)-ийн дагуу хийж турших

Дэд сэдэв	Агуулга		
	Мэдлэг	Чадвар	Хэрэглээ
		- Аав ээжийнхээ сайн чанарыг өвлөх, хадгалах - Өтгөс, нялхаст энэрэнгүй хандах, санаа тавих, туслах - Өөртөө болон бусдад сайхан үг хэлэх, сэтгэл санаагаар дэмжих, сурсан зүйр, цэцэн үг, сургаал үг, уран яруу хэллэгийг ашиглах	- Өөрийн хэрэгцээний болон зарж борлуулах бүтээгдэхүүн үйлдвэрлэх - Орон нутгийн сайн дурын холбоо, нэгдэлд оролцох, хамтарч ажиллах боломжийн талаар унших, мэдээлэл авах - Малын гаралтай бүтээгдэхүүн боловсруулах, байгалийн баялаг ашиглаж ашиг олох арга технологийн талаар унших, тэмдэглэх
1.2. Бичих дадлага	- Зурлага, холбоос хийх, үсэг, цифр зөв бичих технологи - Том үсэг, цэг, тэмдэг - Үеэр таслах дүрэм - Эгшиг зохицох ёс - Эгшигт болон заримдаг гийгүүлэгчийг зөв бичих дүрэм - Онцгой гийгүүлэгчийг зөв бичих дүрэм - Хос болон туслах эгшгийг зөв бичих дүрэм - Ъ болон Ъ-ийг зөв бичих дүрэм	- Үсэг, үе, үг, өгүүлбэр, цифр, тэмдгийг зөв технологиор бичих - Анкет бөглөх - Өөрийнхөө болон гэр бүлийнхний овог нэрийг бичих, - Өрхийн орлого, зарлага, малын тоо зэргийг бичиж тэмдэглэх - Санаж явах сайхан үг, дуртай дуу, шүлгийг хуулан бичих - Намтраа бичих - Нүдлэх цээж бичиг бичих 20-оос дээш үгтэй цээж бичиг бичих	- Сургуулийн өмнөх насны хүүхдээр зураг будуулах, зурлага зуруулах - Үсэг цифр зөв бичүүлж сургах - Төрсний гэрчилгээ болон иргэний үнэмлэхний дугаарыг тусгайлан бичиж хадгалах, хувийн баримт бичгийн хадгалалт хамгаалалтад хариуцлагатай хандах - шаардлагатай утас, хаягийг тэмдэглэх - Гэрийн эзэн, эзэгтэй, хүүхэд бүгд гэр бүлийн аж амьдралд хувь нэмрээ оруулах хуваарь гаргах (бичих)
1.3. Тооцоолж бодох дадлага	1-20 хүртэлх тооны бүтэц, нэмэх, хасах үйлдэл - Тэмдэг (+, -, x, :, <, >, =) 100 хүртэлх тооны бүтэц, нэмэх хасах үйлдэл, нэмэх, хасахын хүрд 1 ба 2 оронтой тоог 1 ба 2 оронтой тоогоор үржүүлэх, хуваах үйлдэл, үржүүлэхийн хүрд, түргэн үржүүлэх хялбар аргууд урт (мм, см, дм, м, км, алхам, алд дэлэм, тохой), хүнд (гр, кг, ц, тн, атга, чимх, аяга, халбага), цаг хугацаа (секунд, минут, цаг, хоног, сар, улирал жил)-ийн хэмжүүрийн нэгж - Тэгш өнцөгт, квадрат, гурвалжин, дугуй	- Тоог бүтцээр нь задлах - тооны жишилт ($3 > 1$, $2 < 5$, $10 = 10$ г.м.) хийх, - аравт хэтрүүлэхгүй буюу хэтрүүлж нэмэх хасах, үржих хуваах, хувь олох, - Нэмэх, хасахын хүрд ашиглах 1 ба 2 оронтой тоог 1 ба 2 оронтой тоогоор үржүүлэх, хуваах - Үржүүлэхийн хүрд ашиглах 1000, 10000, 100000, 1000000 хүртэлх тоог зөв унших, бичих, бүтцээр нь задлах, нэмэх хасах - тооны машин ашиглаж тооцоо хийх - тэгш өнцөгт, квадрат амьдрал ахуйд өргөн хэрэглэдэг дүрсүүд,	- Өрхийн хэрэгцээнд худалдаж авах зүйлийн жагсаалт гаргах, зардлын тооцоо хийх - Гэрийн нөхцөлд хийх хоолны жор, тооцоо - Уртын хэмжүүрийг ашиглан туулах зам, хугацаа, зардлыг тооцох - хүндийн хэмжүүрийг ашиглан малын мах, ноос, ноолуур, сүү цагаан идээнээс олох ашиг, зөв зарцуулах тооцоо хийх - Өрхийн үйлдвэрлэлд зарцуулах түүхий эд, материал, тоног төхөөрөмжийн жагсаалт гаргах - Зардлын тооцоо хийх - Гэр бүлийн сар, жилийн орлого(малын тоо, мах, сүү, цагаан идээ, ноос ноолуур, арьс шир, төмс хүнсний ногоо, ан агнуур, жимс жимсгэнэ, мод түлш, өрхийн үйлдвэрлэл-эсгий, эсгий эдлэл, гар урлал,

Дэд сэдэв	Агуулга		
	Мэдлэг	Чадвар	Хэрэглээ
	1000,10000, 100000, 1000000 хүртэлх тоо), тэдгээрийн бүтэц - Олон оронтой тоог үржүүлэх, хуваах үйлдэл, 2, 3 оронтой тоог 11-ээр, 2 оронтой тоог 111-ээр, 5-аар төгссөн тоог 5-аар төгссөн тоогоор түргэн үржүүлэх хялбар аргууд	тэдгээрийн талбай, тал, эргэн тойрны хэмжээг олох - Урт, хүнд, цаг хугацааны хэмжүүрийн нэгжийг мэдэх, ашиглах - Тооны машин ашиглах, - Олон оронтой тооны үйлдлийн хялбар аргаас ашиглан цээжээр бодох - Өрхийн хэрэглээ-зардал (өдөр тутмын амьдралын өртөг, хувцас, хоол хүнс сургалтын төлбөр, татвар, зээлийн хүү бусад)-ыг тооцох	малын тэжээл, тоног төхөөрөмж, оёдол эсгүүр, дархан мужаан бусад төрлөөс олдог орлого)-ын тооцоо хийх

Үнэлгээ

Сэдвийн явц болон төгсгөлд суралцагчдын өөрийн үнэлгээ, багшийн баталгаажуулах үнэлгээг сорилго, жишиг даалгавар, бүтээлээр үнэлэх аргаар хийнэ. Тус бүлгийг үзэж дуусаад өөрийн үнэлгээ хийх сорилгын жишээ:

Асуулга	Сайн (2 оноо)	Дунд зэрэг (1 оноо)	Тааруу (0 оноо)
1. Би бүх үсэг, тоог загварын дагуу бичиж чадна			
2. Загвар ашиглан бичих аргыг бусдад зааж зөвлөж чадна			
3. Би өдөр бүр хурдан сайхан бичих дасгал хийсэн			
4. Зөв бичихэд эргэлзэж буй үгс, санаж явахад сайхан үгсийг бичиж авсан			
5. Би уншиж чадна			
6. Би хүүхдэд үлгэр уншиж өгч чадна			
7. Би уншсан зүйлээ бусдад ярьж өгч чадна			
8. Би уншсан жороороо хоол хийж сурсан			
9. Би эрүүл мэндийн болон гоо сайхны зөвөлгөөг уншиж ашигладаг болсон			
10. Би тоог нэмж хасаж чадна			
11. Би тоог үржүүлж хувааж чадна			
12. Би тооны машин ашиглаж чадна			
13. Би өрхийн орлого, зардлыг тооцож чадна			
14. Би бичиг сурах явцдаа багаар ажилласан			
15. Би амжилтандаа сэтгэл хангалуун байна			

20-30 оноо – зорилгоо сайн биелүүлсэн, багшаараа баталгаажуулах үнэлгээ хийлгэхэд бэлэн

15-20 оноо – зорилгоо дунд зэрэг биелүүлсэн, зарим зүйлийг дахин үзэх хэрэгтэй

15- аас доош оноо- дахин ажиллах шаардлагатай

Багш суралцагчийн өөрийн үнэлгээтэй танилцаад, баталгаажуулах үнэлгээ хийнэ. Жишиг даалгаврын жишээ

1.Унших, ярих чадвар. Эхийг уншаад асуултад хариулаарай

Анаргулийн аав Савхаан манай эцэг хоёр идэр залуу наснаасаа айл саахалт явж, Зургаагийн газар гэдэг нутагт тарвас, хөх тариа, буудай тарьж, аминаасаа илүү гарсныг Ховд хотын зээл дээр борлуулж хэдэн цаас болгодог байсан юм гэнэ билээ.

Савхаан ах манай өвөлжөөнд тарианы сүрэл, шар шавартай хольж, явраар бэхжүүлсэн түүхий тоосгоор сууц барьж өгсөн юм...(Ц.Мухар, “Анаргуль” өгүүллэгээс)

- Эхэд юуны тухай өгүүлж байна вэ?
- Танай нутагт айл хөрш амьдардаг казак, монгол айлууд бий юу?
- Байдаг бол дэлгэрүүлж яриарай
- Одоо тарвас тарьж зардаг казак айл байдаг уу?
- Тарвасыг яаж тарьдаг вэ?

2.Бичих, тооцоолох чадвар

а. Казакийн уламжлалт түүхий тоосгон сууц барихад юу юу ордог вэ гүйцээж бичээрэй.


- Тоосго
-
-
-
-

б.Нэг түүхий тоосго 200 төгрөгийн үнэтэй 5000 тоосго ямар үнэтэй байх вэ? гэх мэт

Арга зүй

Унших,ярих, бичих, бодох дадлага

1. Унших, бичих болон арифметикийн үйлдлийн дадлага бүлгийг заахдаа эхлээд унших, бичих, харьцуулж жиших, нөхөж бичих зэрэг үйлийг төлөөлсөн тэмдэглээг сайтар тайлбарлаж өгнө. Ингэснээр уншиж чадахгүй суралцагчидтай ажиллахад хялбар байх болно. Жишээ нь:



2. Төрөлх хэлний цагаан толгойн үсгүүдийг эгшиг гийгүүлэгчээр нь, үг бүтээх боломжоор нь багцлан нүдлүүлж, 21 хоногийн дотор 1-3 үетэй үгсээс бүтсэн хялбар эх унших, уншиж байгаа зүйлээ хуулан бичих, нүдлэх цээж бичиг бичих хэмжээнд хүрэхээр аль болох эрчимтэй сургана. **“Бичиг үсэг сурагч болбоос нүдийг бичиг үсгээс бүү холдуул, гарыг үзэг, харандаанаас бүү салга”** хэмээх сургаалыг баримтлан сайн нүдлүүлж, их бичүүлнэ. Үсэг, тоо бичүүлж сургахдаа сум бүхий загварыг сайтар ажиглуулан суралцагч өөрөө зөв технологиор бичиж сурах алхмыг сайн зааж өгөөрэй. Эхний хэдэн үсгийг бичиж сурах явцдаа загварыг ашиглаад сурчихвал цаашдаа багш Таны туслалцааг бага шаардах болно. Гэхдээ шинэ үсэг бичиж сурах бүрт суралцагч бүрийг сайтар хянаж, алдаа дутагдлыг нь засаж зөвлөж байх нь чухал.




Үсэг, үе, үг, өгүүлбэрийг сайтар нүдлээд харалгүй бичих, бичсэнээ эхтэй тааруулж өөрийгөө шалгах, 3,6,9 цаг, 3 хоногийн дараа дахин бичиж бататгах зэрэг бие даан сурах аргыг сургалтын эхнээс эзэмшүүлж хэвшүүлээрэй.

3. Үсэг, үе нүдлүүлэх дасгалыг мэддэг дууны аяар аялгуулан уншиж тогтоох, үсэг бичгийн тухай шүлэг дөрвөн мөрт цээжлүүлэх, ардын аман зохиол, сургаал үгс, залуус, насанд хүрэгчдийн цээжлэх, дуулах дуртай дуу, шүлэгнээс сонгож, уншиж өгөх, амьдралд ойр жишээ авах зэргээр сургалтыг сонирхолтой, энгийн хялбар аргаар явуулах боломж бүрдүүлэхэд онцгой анхаарна.
4. Үзсэн үсэг, тэмдэг бүрийг ашиглан унших бүтээх дасгал их хийлгэж суралцагчид урам өгч, би бичиг сурч чадах юм байна гэсэн итгэл үнэмшил төрүүлж байх нь чухал. Учир нь насанд хүрэгчдийн сургалт тэдний хэрэгцээ, итгэл үнэмшилд тулгуурлан явагддаг. Жишээ нь, зөвхөн үндсэн 7 эгшиг, 1-20 хүртэлх тоо, тэмдгүүдийг үзээд дараах маягийн унших дасгал хийж болох юм.




а) **АВ- ААВ, ЦАС-ЦААС, ХОЛ-ХООЛ, УЛ-УУЛ, ХИЛ-ХИЙЛ, ШҮР-ШҮҮР, ДЭЛ-ДЭЭЛ, ӨР-ӨӨР** гэх мэт үгсийг уншиж өгөөд богино урт эгшгийг ялгуулах

б) Харааны, сонсголын, хүртэхүйн эрхтэнүүдийг жигд оролцуулах дасгал хийлгэх нь үсэг нүдлэх тогтооход ри тустай. Жишээ нь, эхлээд үсгүүдийг хайчлаад ижлээр нь ялгуулна.

À	Î	È	ÈÉ	Ó	—	—
Ó	ÀÀ	ÝÝ	à	Ý	îî	aa
È	À	Î	à	Ó	—	ÓÓ
Î	Ý	È	À	îî	È	—



Дараа нь “өд” гэхэд ордог “ө”, “өөдөс” гэхэд ордог “өө”, “үр” гэхэд ордог “ү”, “үүр” гэхэд ордог “үү” хэмээн асуухад суралцагчид ялгаж бэлтгэсэн картаас олж өргөн харуулна. Зөв буюу буруу олсон үсгийг тус тусад нь ялган тавина. Төгсгөлд нь хэдэн үсгийг зөв хэдэн үсгийн буруу олсныг тоолно.



в) Үзсэн үсэг, тоо, тэмдгийг оролцуулан зурагт өгүүлбэр уншуулна. Энэ нь суралцагчид уншиж сурч буй сэтгэгдэл төрүүлж урамшуулах, үзсэн үсэг бүрийг хэрэглээнд оруулах ач холбогдолтой. Жишээ нь, эгшиг үсэг, 10 хүртэлх тоо, асуултын болон анхаарлын тэмдгийг үзээд дараах өгүүлбэрийг уншиж болно.




2 уу?



3 уу?



4 үү?



Эгшиг үсэг, эгшигт гийгүүлэгчийг үзсэний дараа дараах маягийн өгүүлбэрүүдийг уншиж эхэлнэ.

Эм  . Эр  .

Аав 5 эр  , 5 эм  авав.

Амар  унав. Аав  авав. Амар, аав 2


 унав. Амар, аав 2 ирэв.  оров.

Өвөө, эмээ  уу. Эмээ  уув.

Дараа нь дан эгшигт гийгүүлэгч, эгшгээс бүтсэн эх уншуулна.

Мал

Манай мал олон. Ам бүлээрээ мал маллана. Аав уурга барив. Би малаа өвлөнө. Малаа олон болгоно. Ноолуурын үнэ нэмлээ.



Эмээл

Энэ бол аавын эмээл. Аавын эмээлийн баавар ганган. Миний эмээлийн бүүрэг нам. Ганаа бор морины эмээлийг авав. Өнөрөө, алаг морио эмээллээрэй.

5. Насанд хүрэгчдийн амьдралын туршлага, үгийн нөөцийг аль болох сайн ашиглаж, өдөр тутмын амьдрал, зан үйлтэй нь холбох арга хэрэглэнэ. Жишээ нь:

а) “А” үсгийг үзэж байхад (АЗ, АД, АМ, АТ, АТАА, АЧ, ААШ, АХ, АЛХАА, АР, ААРУУЛ, АЯГА, АЯНГА, АВДАР, АДУУ, АДУУЧИН, АН, АНЧИН, АМЬ, АМЬДРАЛ, АМЖИРГАА, АВХААЛЖ, АВЬЯАС, АЖИЛ, АЖИЛЧИН, АШИГ, АМЖИЛТ, АЧАА, АЧААЛАЛ, АНХААРАЛ, АЛИМАА, АНАР, АРИУНАА) зэрэг үгсийг эхлээд нэг нэгээр нь уншиж өгөөд -“Аз” гэдэг үгэнд “А” үсэг байна уу?

-“А” богино дуудагдаж байна уу, урт дуудагдаж байна уу гэж асууж ярилцаад дараа нь бичмэлээр тараан өгч богино “А”-г нэг зураасаар, урт “А”-г хоёр зураасаар ялгуулан зуруулж болох юм.

б) Дараа нь “А” үсэг аль болох олон орсон өгүүлбэр(Анар манай ач. Анар арван настай.) өгч “А” үсгийг олуулан том “А”, жижиг “А”, урт “А”, богино “А” гэх мэт ярилцана. Өгүүлбэрийг уншихад суралцагчдын үзсэн үсгийн нөөц хүрэхгүй байгаа тохиолдолд багш өөрөө уншиж өгнө.

в) Тоглоом тоглоно.

- Суралцагчдыг 2 багт хуваана. Нэг баг нь Юу? гэсэн асуултад, нөгөө нь Хэн? гэсэн асуултад хариулагдах “А” үсгээр эхэлсэн үг аль болох олныг хэлнэ. Багш самбар дээр бичнэ. Жишээ нь:

Юу?	Хэн?
арц, аарц	аав авга

- Суралцагчдын хэлсэн бүх үгийг самбар дээр бичиж дуусаад болзолд тохирохгүй үгсийг дарна. Жишээ нь:

Юу?	Хэн?
арц, аарц ачих	аав авга адуу

- Үлдсэн үгсийн тоог бичнэ

Юу?	Хэн?
13 үг	12 үг

- Тойрог дотор аль тэмдгийг (<?, >? =?) тавибал зөв бэ? гэх мэт асуулт тавьж, үзсэн цифр, тэмдгүүдийг хэрэглүүлэх боломж бүрийг ашиглахыг хичээгээрэй.

13



12

- Аль баг түрүүлэх вэ? (дүгнэнэ)

- Эцэст нь суралцагчид ховор хэрэглэгддэг, зөв бичихэд эргэлзэж буй үгсийг дэвтэртээ бичиж авна. Энэ ажлыг гүйцэтгэхдээ дэвтрийн хуудсыг Цагаан толгойн үсгээр дугаарлан өдөр бүр нэмж бичсээр сургалтын эцэст хүн бүр өөртөө зориулсан зөв бичгийн толь, зүйр цэцэн үгийн цуглуулгатай болно гэдгийг анхааруулаарай. Жишээ нь:

А	
Адсага Араншин адис ... г.м.	

- Энэ тоглоомыг бараг бүх үсгийг бататгах, хэрэглэх явцад хэрэглэж болох ба хичээлд хүн бүрийг идэвхитэй оролцуулж нүүр хагаран биеэ барихыг нь багасгах, бусадтай хамтран ажиллаж сурах, хурдан сэтгэх, үгийн баялагийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

г) Шинээр үзэж буй буюу бататгаж буй үсгээр эхэлсэн ба уг үсэг олон орсон, гэр бүл, ахуй соёл, зан заншилтай холбоотой онч мэргэн үгс цээжлэх, хуулан бичих дасгал хийлгэнэ. Тэдгээрийг хоёр хуваасан хуудасны хоёр дахь хэсэгт бичүүлэх ба суралцагчид үзээгүй, бичиж чадахгүй үсэг байгаа тохиолдолд эхний удаад цээжилж байгаад дараа нь бичнэ. Жишээ нь:

А	
Адсага Араншин адис ... г.м.	Аавын үг алт, ээжийн үг эрдэнэ Аав ээж гэсээр хэлээ сурдаг, А,Б гэсээр эрдэм сурдаг Аав нь хэлж, хүү нь дагадаг Аагтай цай алжаал тайлна, аятай үг сэтгэл засна Ам гэж алт, ажил гэж гууль Ам бардам, гуя шалдан Амнаас үг гарна, ажлаас ухаан гарна Адууныхаа хэрээр исгэрч, амныхаа хэрээр бур

6. Цифр таниулах, үйлдэл хийх, тоо жиших, хувь олох, тооны машинаар тооцоо хийх зэргийг насанд хүрэгчдийн мэдлэг, туршлагад тулгуурлан эрчимтэй хөгжүүлнэ.
7. Эдгээр өгүүлбэрүүдэд хэдэн том үсэг, хэдэн цэг байна, яагаад? Эдгээр үгст орсон үсгүүдийг тоолон жишиж, тохирох тэмдгийг тавь. Та 1 минутад 30 үсэг бичиж байна, 3 минутад хэдийг бичих вэ? Төрөлх хэлний “Цагаан толгой”-н үсгийн хэд нь эгшиг, хэд нь гийгүүлэгч вэ? г.м. тоог хасах, нэмэх, үржүүлэх, хуваах үйлдэл хийлгэх явцад эх хэлний мэдлэгийг байнга хэрэглэж давтана.
8. Уг сэдвийг заахдаа загвар, алгоритмийн дагуу ажиллах, бүтээлчээр өөрчлөх, баяжуулах, бие даан гүйцэтгэх аргыг шат дараалан хэрэглүүлсээр суралцагчид сурах арга эзэмшүүлэхэд их анхаарна. Жишээ нь:

- а. Анаргуулийн намтрыг анхааралтай уншаарай
- б. Намтраа бичээрэй



Намтар

Намайг Анаргуйль гэдэг. Би 26 настай. Баян-Өлгий аймгийн Цэнгэл суманд төрсөн, луу жилтэй. Нөхөр хоёр хүүхэдтэйгээ амьдардаг. Дуртай хоол каз, дуртай өнгө цагаан, саарал, сонирхдог зүйл казак үндэсний уран хатгамал. Хэлэх дуртай үг- “Аавын сургаал алт, ээжийн сургаал эрдэнэ” Миний хүү Сайлау ирэх жил сургуульд орно. Хүүгээ сургуульд орохоос өмнө би бичиг сайн сурахаар шийдсэн.

- в. Султан Мурат анкетаа хэрхэн бөглөснийг анхааралтай хараарай
- г. Анкетаа бөглөөрэй г.м.


Анкет

	Овог, нэр:	Султан Мурат
--	------------	--------------

	Төрсөн он, сар, өдөр	1985.10.25
	Жил	Үхэр
	Төрсөн газар	Баян-Өлгий аймгийн Цэнгэл сум
	Иргэний үнэмлэхийн дугаар	БӨ0056475
	Бүртгэлийн дугаар	ЧП 85102521
	Ам бүл хэд, хэн хэн хаана юу хийдэг	Ам бүл -4, эхнэр Анаргуль малчин,хүү Сайлау 5 настай гэртээ байдаг, охин Харлыгаш 2 настай мөн гэртээ байдаг
	Эрхэлдэг ажил	Малчин
	Дуртай хоол, унд	бесбармак, сүүтэй цай
	Дуртай өнгө	Хар
	Сонирхдог зүйл	Мал маллах, ан агнах
	Хэлэх дуртай үг	Шүд нь ургамагц, махыг бүү зажилж өг

Дээрх маягийн даалгаврыг нэлээд хийлгэсний дараа мэдлэг туршлагаа ашиглан, өмнөхөөс илүүг эрж хайх, баяжуулах даалгавар гүйцэтгэнэ. Тухайлбал, суралцагч өөрийнхөө гурван үеийн авга, нагацын талынхны нэрийг мэддэг байж болно. Харин цааш нь эрж сураглах шаардлагатай болно гэж үзвэл бэлэн, гүйцэд загвар биш гүйцээх, үргэлжүүлэх загвар өгнө. Жишээ нь:

Угийн бичиг



Хэрэглэгдэхүүн

- Гүндэгмаа Д., Баттогтох Д., Чулуунцэцэг О., Билгийн нүд-1,УБ., 2003 (монгол, казак хэл дээр)
- Гүндэгмаа Д., Наранцэцэг Ц., Монгол хэл УБ., 2005 (бага боловсролын дүйцсэн сургалтын сурах бичиг)

2.1. ЭРҮҮЛ МЭНД

Хүлээгдэж буй үр дүн

- Өөрийн болон бусдын эрүүл мэндийн талаар тодорхой мэдээлэл авах
- Сурч мэдсэн зүйлээ өдөр тутмын амьдралдаа хэвшил болгох
- Амьдарч буй орчныхоо эрүүл мэндийн асуудлыг шийдвэрлэх мэдлэгтэй болох
- Сурч мэдсэн зүйлээ өдөр тутмын амдралдаа хэвшил болгох

Дэд сэдэв	Агуулга		
	Мэдлэг	Чадвар	Хэрэглээ
Эрүүл бие	<i>Хувийн эрүүл ахуй:</i>		
	- Амны хөндийн эрүүл ахуй - Арьс, үс, хумс, гар хөлний арчилгаа - Хувийн ариун цэврийн хэрэгслүүд - Гоо сайхны болон ариун цэврийн хэрэгслийн сонголт - Сүү, хүнсний ногоогоор бүрхэвч, түрхлэг хийх арга - Хувцас сонголт, хэрэглээ - Эмийн зөв хэрэглээ - Архи, тамхины хор - Дам тамхидалт, түүний үр дагавар	- Шүдээ арчлан хамгаалах - Арьс, үснийхээ онцлогт тохирсон гоо сайхны бүтээгдэхүүнийг зөв сонгож, хэрэглэх - Сүү, өндөг, хүнсний ногоо зэргийг гэрийн нөхцөлд ашиглан арьс, үсээ арчилж сурах - Хувийн ариун цэврийн хэрэслээ зөв сонгож, арчилж, ашиглах - Биеийн болон улирлын онцлогт тохируулан хувцаслах - Эмийн заавар, хүнсний барааны шошго унших, зөв хэрэглэх - Архи, тамхинд зарцуулах үр ашиггүй зардлыг тооцох, эрүүл мэндэд үзүүлэх хор уршгийг ойлгох, тайлбарлах, бусдыг хордуулахгүй байх	- Шүдээ тогтмол зөв угаах, арчилах - Гоо сайхны бүтээгдэхүүнийг зөв сонгож, хэрэглэдэг байх - Биеэ арчилж, ариун цэврийг тогтмол сахих - Хувийн ариун цэврийн хэрэгслээ бусадтай сольж хэрэглэхгүй байх - Биеийн онцлог, тодорхой нөхцөл байдалд тохируулан хувцаслах - Хорт зуршлаас татгалздаг байх - Хорт зуршлын талаар өөртөө болон бусдад шүүмжлэлтэй ханддаг байх - Бусдыг архи, тамхинаас гарахыг уриалдаг, биеэрээ үлгэрлэдэг байх
	<i>Хооллолт:</i>		
	- Уламжлалт хоол хүнс – сүү, махан бүтээгдэхүүн - Хоол хүнс гэрийн нөхцөлд бэлтгэх арга (айраг, ааруул, мойлтой тос, эззгий, цөцгий, арвайн гурил, борц, каз, бесбармак г.м.) - Хоол хүнсний зохилдлого, бие махбодид хэрэгцээтэй эрдэс бодис - Хоол хүнсний найрлага, тэжээллэг чанар - Хүнсний бүтээгдэхүүний сонголт, аюулгүй байдал ба хадгалалт - Зөв зохистой хооллолт - Хооллолттой холбоотой эмгэгүүд	- Үндэстэн, ястны хэрэглэж ирсэн уламжлалт хоол, хүнсийг боловсруулах, бэлтгэх - Хүнсээ зөв хадгалах - Өрхийн 7 хоногийн хоолны цэс гаргах, нэр төрлийг олшруулах - Боломжоо ашиглан амт, чанартай хоол хүнс бэлтгэх - Хүнсний зүйл худалдан авах жагсаалт гаргах, мөнгөө урьдчилан төлөвлөж, тооцох - Өрхийн хоол хүнснээс хэмнэж болох зардлыг тооцох - Хүнсний бүтээгдэхүүнийг зөв сонгох, хадгалах - Буруу хооллолтоос үүсэх сөрөг үр дагаврыг	- Үндэсний хоол хүнсийг дээдлэх, бэлтгэн боловсруулах уламжлалыг хадгалах, хөгжүүлэх - Хүнсний бүтээгдэхүүн сонгохдоо хугацааг харж занших - Зөв зохистой хооллох дэглэм баримтлах - Эрүүл мэндээ хамгаалах зорилгоор зарим хоолноос татгалзах

	(хоолны хордлого, хоолны дуршил буурах, хэт идэх г.м.)	тайлбарлах, урьдчилан сэргийлэх	
	<i>Хөдөлгөөн:</i>		
	- Хөдөлгөөний ач холбогдол - Эрүүл мэндэд чиглэсэн дасгал хөдөлгөөн - Нар, ус, агаараар биеэ чийрэгжүүлэх арга зам	- Эрүүл, чийрэг байх, гоо сайхнаа хадгалахад чиглэсэн дасгал хөдөлгөөнийг сонгож, хэрэглэх - Дасгал хөдөлгөөний ач холбогдлыг бусдад тайлбарлах, сурталчлах - Биеэ чийрэгжүүлэх аргуудыг эзэмших	- Өөрт тохирсон дасгал хөдөлгөөнийг сонгох, зөв гүйцэтгэх талаар зөвлөгөө авдаг байх - Дасгал хөдөлгөөнийг хийж хэвшсэн байх - Бие бялдрын үндсэн үзүүлэлтээ хянаж, хэвийн байлгахад анхаардаг байх - Дасгал хөдөлгөөний ач холбогдлыг бусдад сурталчилдаг байх
Гэр ахуйн эрүүл орчин	- Гэр орны болон ажлын байрны ариун цэвэр - Агааржуулалт - Гэрэлтүүлэг - Тоосжилтоос үүсэх өвчин - Бохиоос үүсэх халдварт болон халдварт бус өвчин - Ахуйн осол гэмтэл - Ариун цэврийн бодис, хэрэгслүүд	- Гэртээ буюу амьдарч буй газраа цэвэр, эрүүл орчинг бүрдүүлэх аргад суралцах - Гэр орноо агааржуулж байх - Гэрэлтүүлгийг зөв хэрэглэх - Тоосноос үүсдэг өвчнөөс урьдчилан сэргийлэх аргыг эзэмших - Бохиоос үүсэх халдварт, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх аргыг эзэмших - Ахуйн осол, гэмтлээс сэргийлэх арга замыг эзэмших, анхны тусламж үзүүлэх арга барилд суралцсан байх - Ариун цэврийн бодисыг сонгож, зааврын дагуу аюулгүй хэрэглэх	- Амьдарч, ажиллаж буй газартаа цэвэр, эрүүл орчин бүрдүүлэх - Өдөр болгон цэвэр агаар оруулах - Байгалийн гэрэл, гэрэл чийдэнг зөв ашиглах - Өдөр болгон амьдарч буй гэрийхээ тоосыг арчих - Ариун цэврийн бодисуудыг зөв сонгож, бохир орчинд цэвэрлэгээг тогтмол хийх - Ариун цэврийн бодисын зааврыг чандлан сахих - Ахуйн ослоос өөрийгөө болон гэрийхнийгээ сэргийлэх - Ахуйн ослын үед анхны тусламж үзүүлэхэд шаардлагатай эм, багаж хэрэгслийг тогтмол байлгаж, шаардлагатай үед хэрэглэх

Үнэлгээ

- Өөрийн эрүүл мэндийг хамгаалахын ач холбогдолыг мэдэж, ойлгосноор бусдад цэгцтэй ярьж тайлбарлах, урьдчилан сэргийлэх аргыг хэлэх. Энэ талаар гарсан гарын авлага, ном, хэвлэмэл материалыг унших
- Ариун цэврийн хэрэглэл, оо энгэсэгний зааврыг уншиж хэрэглэх
- Хувцсан дээрх тэмдэгтийг уншиж зааврын дагуу арчлах
- Эмийн заавар унших
- Хоол хийх жор унших, түүний дагуу хийх
- Хүнсний барааны шошго унших, хүчинтэй хугацааг харах
- Хоолны дуршил буурах, хэт их идэх, хоолны хордлогын эмгэгүүдийг нэрлэх, сэргийлэх аргыг хэлэх. Энэ талаар гарсан хэвлэмэл материал унших
- Хоолонд орох материалын орц бодох
- Хөдөлгөөн, дасгалын талаар бичигдсэн заавар, зөвлөгөөг унших
- Бусдад хөдөлгөөний ач холбогдол, нар, ус, агаараар биеэ чийрэгжүүлэх аргыг хэлэх

- Өөрт тохирсон биеэ чийрэгжүүлэх хөтөлбөр бичих
- Гэр орон, ажлын байрны ариун цэвэр, агааржуулалт, гэрэлтүүлэг хүний эрүүл мэндэд ямар ач холбогдолтойг ярих
- Харшил өвчин юунаас үүсдэг, хэрхэн урьдчилан сэргийлэх, туссан үед авах арга хэмжээний талаар ярих
- Бохиоос үүсэх халдварт болон халдварт бус өвчнүүдийг нэрлэх, илрэх шинж тэмдгүүдийг, авах арга хэмжээг хэлэх
- Ахуйн осол гэмтлийн үед анхны тусламж үзүүлэх аргуудаас хэлэх
- Гэр орны нөхцөлд хортон шавьж устгах энгийн аргаас нэрлэх
- Ахуйн хэрэгсэл, бодисыг зөв хэрэглэх заавар, тэмдэглэгээг унших

Арга зүй

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд танхимын бус хэлбэр зонхилох тул танхимын буюу зайны сургалтын төрөл бүрийн хэлбэрүүдийг ашиглаж болохоос гадна суралцагчид бие даан судлах, гэр орны гишүүд, ойр дотныхонтойгоо хамтран ажиллах бүтээлч аргуудыг сонгож хэрэглэх нь зүйтэй. Сургалт эхлэхийн өмнө багш суралцагчийн эрүүл мэндийн талаарх мэдлэгийн түвшинг тогтоож, мэдээлэл авах хэрэгцээний судалгааг гаргасан байна. Эрүүл мэндийн сургалтыг бичиг үсгийн боловсрол олгох анхан, дунд, гүнзгийрүүлсэн шатны үед янз бүрийн хэлбэрээр давхар явуулж болно. Тухайлбал, уншиж сурч буй хүн тус бүрт шаардлагатай мэдээллийг нь текст хэлбэрээр уншуулах. Түүнийг хуулж бичүүлэх, тухайн сэдвээр ярилцлага зохион байгуулж хэл яриаг хөгжүүлэх, тооцоолон бодох боломжтой сэдвүүд дээр тоо бодуулах. Жишээлбэл, өгөгдсөн эрүүл мэндийн сэдэвтэй текстийг зааврын дагуу унших, хурдан унших, утгат хэсгээр унших, гол түлхүүр үгийн доогуур зурах, хосоор унших г.м. аргуудыг хэрэглэж болох юм. Сургалтын явцад уншихаас гадна эхтэй ажиллах арга барилыг хөгжүүлэх нь маш чухал. Жишээлбэл, эхийг уншаад ахуйн нөхцөлд бохиоос үүсэх халдварт болон халдварт бус өвчний талаар тэмдэглэл хийж бичээрэй, халдварт өвчний үед илрэх шинж тэмдгүүдийг жагсаан бичээрэй. Тухайн өвчний шинж тэмдэг илэрсэн үед та хэнд хандах вэ? г.м. цааш нь ажиллаж болно. Иймээс сургалт зохион байгуулахдаа сургалтын төрөл бүрийн идэвхтэй аргуудыг өргөн хэрэглэж суралцагчдын оролцоонд тулгуурлан явуулбал илүү үр дүнтэй болно. Жишээ, тохиолдлыг суралцагчдаар гаргуулан хамтран ярилцаж, гарц хайж, үр дүнд хүрсэн байдлаар зохион байгуулна. Эрүүл мэндийн сургалтыг бичиг үсгийн боловсрол олгох явцад зохион байгуулахдаа анги доторх нөхцөл байдлыг зөв тооцоолж, багш хэлэх үг, өгүүлбэр ээ бодож, бодлогогүй авсан жишээ хэн нэгэн суралцагчийг эвгүй байдалд оруулахгүй байх талаар нарийн тооцох нь зүйтэй. Эрүүл мэндийн сургалт явуулахад суралцагчдын дунд бие биенээ хүндэтгэх, итгэх дулаан уур амьсгалыг бүрдүүлэх нь чухал байдаг.

2.2. АМЬДРАХ, АЖ ТӨРӨХ УХААН

Хүлээгдэж буй үр дүн

- Өөртөө итгэлтэй ба итгэлгүй зангийн онцлогт үндэслэн өөртөө дүгнэлт хийн, өөртөө итгэх итгэлээ сайжруулах
- Сэтгэлийн хөдөлгөөнөө мэдрэх, хянах, зохицуулах чадвартай болж стрессгүй амьдралын хэв маягийг эрхэмлэх
- Аливаа асуудлыг тодорхойлж, зөв шийдвэр гаргах
- Ном, сонин, мэдээллийн хэрэгслээс харилцааны талаарх мэдээ, мэдээллийг уншин, ойлгож, амьдралдаа хэрэглэх
- Төлөвлөлт хийж, зорилгодоо хүрэх хэрэгсэл болгон ашиглах

Дэд сэдэв	Агуулга		
	Мэдлэг	Чадвар	Хэрэглээ
Өөртөө итгэх итгэл	• Өөртөө итгэх итгэл	• Өөртөө итгэлтэй болон итгэлгүй хүний жишээг унших, эргэцүүлэх, санаа бодлоо илэрхийлэн ярих	• Өөртөө итгэлтэй эсэхээ тодорхойлох

	• Өөртөө итгэлтэй болон итгэлгүй зангийн онцлог • Итгэлтэй харилцааны арга барил	• Өөртөө итгэлтэй ба итгэлгүй зангийн онцлогийг харьцуулан давуу ба сул талыг ялгах • Онцлог, давуу талаа илэрхийлэх • Итгэлтэй харилцааны арга барилд суралцах, турших • Сэдэвтэй холбоотой зүйр цэцэн үг олж утгыг тайлбарлах, цээжлэх	• Өөрийн онцлог, давуу талаа мэдрэх, өөрөөрөө бахархах • Итгэлтэй харилцааны алхмуудыг мөрдөхийг эрмэлзэх • Боловсролын хэрэгцээг ухаарах, боловсролоо дээшлүүлэх чадвартай гэдэгтэй итгэлтэй байх • Санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх • Өөртөө болон бусдад итгэл, урам өгөх үгийг хэлэх, зөвлөх, сурсан зүйр цэцэн үг, сургаал үг ашиглах
Сэтгэлийн хөдөлгөөн	• Сэтгэлийн хөдөлгөөний хэлбэрүүд • Стресс, түүнийг үүсгэгч хүчин зүйл • Стрессийн төрөл • Эерэг, сөрөг сэтгэлийн хөдөлгөөний үзүүлэх нөлөөлөл • Стрессээс сэргийлэх, бууруулах арга	• Сэтгэлийн хөдөлгөөний хэлбэрүүдийн талаар жишээг унших, эргэцүүлэх, санаа бодлоо илэрхийлэх • Сэтгэлийн хөдөлгөөний хүний эрүүл мэнд, сэтгэл санаа, зан үйлд үзүүлэх нөлөөллийг тайлбарлах • Стресс, үүсгэх хүчин зүйл, илрэх шинж, сөрөг үр дагаврыг тодорхойлох, бичих • Дуу, шүлэг, зохиол дахь дүрийн сэтгэлийн хөдөлгөөнийг тодорхойлох • Сэтгэлийн хөдөлгөөнөө хянах, стрессээс өөрийгөө хамгаалах аргад суралцах	• Сэтгэлийн хөдөлгөөнөө хянах, зохицуулахад туслах зөвлөмж, санамжид анхаарал хандуулан, ижил төстэй нөхцөлд хэрэглэж турших • Тохирох сайн аргаа сонгон стрессээс сэргийлэх, стресст орсон тохиолдолд бууруулах • Өөрийн болон бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох, эерэгээр нөлөөлөх • Аливаа асуудалд амархан эмзэглэхгүй, гуниглахгүй байх • Хэрэгцээт мэдээллээ бусдад түгээх, санал солилцох
Шийдвэр	• Шийдвэр, түүнд нөлөөлөх хүчин зүйлс • Шийдвэр гаргах хэлбэрүүд • Шийдвэр гаргах алхмууд • Шийдвэрийн үр дагавар, давуу ба сул тал • Эрсдэл	• Шийдвэр, түүний хэлбэрүүд, үр дагавар, давуу ба сул талыг ялгах • Шийдвэр гаргах алхмуудын талаар унших, гол зүйлийг тэмдэглэж бичих • Нэг асуудал сонгон, шийдэх боломжийг алхам бүрээр бичих • Сөрөг үр дагавартай ятгалгаас татгалзаж сурах • Сэдэвтэй холбоотой зүйр цэцэн үг, үлгэр, уран зохиол унших, ашиглах	• Аливаа мэдээлэлд өөрийн байр сууринаас шүүмжлэлтэй хандах • Шийдвэр гаргах алхмуудыг баримтлах, асуудалтай холбогдох хууль, дүрэм судлах, хариуцлагатай хандах • Бусдын шийдвэрт хүндэтгэлтэй хандах, өөрийн үзэл бодлыг тулгахгүй байх • Хувийн амьдралын болон орон нутгийн асуудлыг шийдэхэд идэвхтэй оролцох
Харилцаа	• Мэндлэх, хүндлэх, талархах ёс • Харилцаа, түүний төрөл • Харилцаанаас үүсэх үр дагавар • Хэлний харилцаанд эерэг, сөргөөр нөлөөлөх хүчин зүйлс	• Бусдад таалагдах, эс таалагдахын учрыг мэдэх, тайлбарлах • Бусдыг өөрөөсөө түлхэхээс урьдчилан сэргийлэх аргад суралцах • Бусдыг хүлээцтэй сонсох, харилцагчаа ойлгох, эелдгээр татгалзах • Буруу харилцаанаас гарч болох сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх • Эх хэлээрээ зөв боловсон харилцах, уламжлалт мэндчилгээ, ёслол хүндэтгэлийн үг хэллэгээс суралцах	• Хүмүүстэй зөв боловсон мэндлэх, харилцах • Сургалтын явцад эзэмшсэн мэдлэг чадвараа амьдралдаа хэрэгжүүлэх • Хүндэтгэл, ерөөлийн үгийг хэрэглэж, этгээд, бүдүүлэг, албархаг, харь, сул үг зэргийг хэрэглэхгүй байх

Төлөвлөлт	• Цаглабар (календарь) • Өдрийн дэглэм • Цаг ашиглалт • Хувийн зохион байгуулалт • Ойрын ба ирээдүйн төлөвлөгөө	• Цаг хугацааны хэмжүүр, цаглабар ашиглах • Төлөвлөлтийн жишээ, баримт судлах, дүн шинжилгээ хийх • Төлөвлөх болон төлөвлөхгүй байхын давуу ба сул талыг ялгах • Өдөр тутмын ба ирээдүйн төлөвлөгөөний ялгааг гаргах • Цагаа зохицуулж, ирээдүйгээ төлөвлөж сурах • Сэдэвтэй холбоотой зүйр цэцэн үгсийн утгыг тайлбарлах	• Цагийн үнэ цэнийг мэдрэх, цагийг үр дүнтэй өнгөрөөх, хэрэгцээт зүйл, бичиг үсэг сурахад цаг гаргах • Өдөр тутмын ажлаа төлөвлөх, хугацаанд нь биелүүлэх • Ирээдүйн төлөвлөгөөгөө гаргах, түүнд хүрэхэд тулгарах бэрхшээлийг тодорхойлох, давах арга замыг эрэлхийлэх, шантралгүй хэрэгжүүлэх • Хэрэгцээт мэдээллээ бусадтай хуваалцах
Бүтээлч сэтгэлгээ	• Бүтээлч ба хэвшмэл сэтгэлгээний онцлог, ялгаатай тал • Бүтээлч чадвараа дээшлүүлэх арга	• Бүтээлч ба хэвшмэл сэтгэлгээний онцлог, давуу талыг ялгах, тайлбарлах • Амьдралд тохиолдож байсан жишээнд үндэслэн санаа бодлоо солилцох • Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх аргад суралцах, амьдрал ахуйдаа турших • Сэтгэлгээгээ хөгжүүлэх дасгал ажиллах, өөртөө дүгнэлт хийх	• Өөрийгөө болон хүүхэд, дүү, найз нараа хөгжүүлэхийг эрмэлзэх • Амласнаа биелүүлдэг, тэвчээр зориг гаргадаг байх • Хүсэл зорилгоо биелүүлэхийн тулд бусдаас тусламж авах • Хувийн болон олон нийтийн ажилд идэвх санаачлагатай оролцох

Үнэлгээ

Үнэлгээ нь нэг талаас суралцагчдын чадвар эзэмшилт, ахиц, нөгөө талаас сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг харуулах үзүүлэлт юм. Сургалтын эхэнд, явцад, төгсгөлд суралцагчдын мэдлэг, чадварын түвшинг тогтоох нь багш, суралцагчдын аль алины хувьд сургалтын үйл ажиллагааг чиглүүлэх удирдамж болно.

Суралцагчдын өөрийн үнэлгээ, стандарт бус үнэлгээний хэлбэрийг сургалтын явцад ашиглах нь илүү тохиромжтой. Өөрийн үнэлгээ нь суралцагчийг идэвхжүүлэх нэг хөшүүрэг бөгөөд тэднийг сурах үйл ажиллагаагаа хянах, улам сайжруулах эрмэлзэлтэй болгоно. Суралцагчдын өөртөө өгсөн үнэлгээг багш нар заавал тооцож байх нь чухал.

Сургалтын явцын үнэлгээ хийхдээ сургалтын үйл явцыг хянах, багш, суралцагч, гэр бүлийн гишүүд, бусад хүмүүсийг үнэлгээний ажилд татан оролцуулж:

- ажиглалт хийх
- тэмдэглэл хөтлөх
- суралцагчидтай ярилцах
- гэр бүлийн гишүүдтэй ярилцах
- сургах-сурах үйл ажиллагааны үр дүнг хянах
- суралцагчдын түвшинг тогтоох
- суралцагчдын бүтээлийн сан бий болгох
- суралцагчдын өдөр тутмын амьдралд гарч байгаа өөрчлөлт, ахицыг ажиглалтын аргаар дүгнэж үнэлгээ өгөх зэрэг хэлбэрийг ашиглаж болно.

Сургалтын үр дүнг дээшлүүлэх зорилгоор а) сургалтын явц, б) суралцагчдын чадвар эзэмшилтийн байдлыг ажиглан дараах загвараар тэмдэглэлийг хөтөлнө.

а) Сургалтын явцыг ажиглан тэмдэглэл хөтлөх загвар

БАГШИЙН ТЭМДЭГЛЭЛ

Сэдвийн нэр: ...Аж төрөх ухаан...

№	Дэд сэдэв	Сар/өдөр	Үндсэн үйл ажиллагаа	Тэмдэглэл
1	Өөртөө итгэх итгэл	X/11	“Өөртөө итгэх итгэл” сорилоор суралцагчид өөрсдийгөө тодорхойлов. Суралцагчдыг багт хуваарилан ялгаатай номны агуулга, даалгавар ажиллуулав.	Баг бүр өөр даалгавар хийж, үр дүнг ярилцсан нь бага хугацаанд их мэдээлэл солилцох боломж олгов.
2	Сэтгэлийн хөдөлгөөн	X/12		

б) Суралцагчдын чадвар эзэмшилтийн байдлыг тэмдэглэх загвар

Дэд сэдвийн нэр, эзэмших чадвар Суралцагчийн нэр	Өөртөө итгэх итгэл					Сэтгэлийн хөдөлгөөн					
	Жишээг уншин санаа бодлоо илэрхийлэх	Өөртөө итгэлтэй ба итгэлгүй зангийн онцлог, давуу ба сул талыг ялгах	Өөрийн онцлог, давуу талаа илэрхийлэн хэлэх	Итгэлтэй харилцааны арга барилд суралцах	Зүйр цэцэн үгийн утгыг тайлбарлах, цээжлэх						
Ариунболд	X/3	X/5	X/10	+	+	+	+	+	+	+	
Анхцэцэг	+	+	+	+	+	+	+	X/5	X/20		
...											
Энх-Оргил	+	X/4	+	X/15	+	X/5	+	+	X/20	+	

Тайлбар: Суралцагч тухайн чадварыг хугацаандаа эзэмшсэн бол хүснэгтэд үүнийг “+”-ээр, хугацаа хоцорч эзэмшсэн бол хугацааг нь бичиж тэмдэглэнэ.

Тэмдэглэлээ чанартай, бодитой хөтлөх нь багш арга зүйгээ шинэчлэн хөгжүүлэх, суралцагчдад зөвлөгөө өгөх, чиглүүлэх, улмаар сургалтын хөтөлбөрөө сайжруулах үндэслэл судалгаа болно.

Тухайлбал, суралцагч Ариунболд эхэндээ чадвараа хугацаа хоцорч эзэмшиж байснаа дараагийн дэд сэдвээс эхлэн хугацаандаа эзэмшиж байгаа нь тухайн суралцагч ахиж байгааг харуулна. Харин Анхцэцэгийн хувьд эхний дэд сэдвийн чадварыг хугацаандаа эзэмшсэн бол дараагийн дэд сэдвээс хоцорч буй нь ажиглагдаж байна.

Түүнчлэн хүснэгтээ баганын дагуу ажиглаж, аль сэдвийн ямар чадварыг суралцагчдын хэдэн хувь нь эзэмшсэн байгааг тодорхойлж, сургалтын хөтөлбөр, сэдвийн боловсруулалт, хэрэгжилтийн талаар үнэлгээ дүгнэлт өгч, үүнд тулгуурлан хөтөлбөрөө сайжруулах нь зүйтэй.

Бүх суралцагчийн чадвар эзэмшилтийг нэг цагийн хичээл дээр илрүүлэх амаргүй. Иймд багш хичээл бүр дээр чадварыг илрүүлэх боломжит үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулж, сургалтын явцад суралцагчдын хийж байгаа үйл, үйлдэл, хийсэн бүтээлээрээ илэрхийлсэн санаа, санал бодлоо үгээр, үйл хөдлөлөөр илэрхийлж байгаа байдал, аливаа юманд хандаж байгаа хандлага зэргийг маш гярхай, мэдрэмжтэй ажиглах хэрэгтэй. Тухайн чадварыг

эзэмшсэн нь тодорхой суралцагчийг хувьд тэмдэглэлдээ "+"-ийг бичнэ. Ажиглах явцад нэмэлт дэмжлэг шаардлагатай суралцагчдад багш тусалж зөвлөнө.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг дээрх загвараар үнэлснээр дараагийн сэдвийг судлах боломжтой эсэхийг тодорхойлно.

Суралцагчдын эзэмшсэн мэдлэг, чадварыг илрүүлэх даалгаврын жишээ:

Багш сургалтын хөтөлбөрөө боловсруулахдаа суралцагчдын эзэмшсэн чадварыг илрүүлэх даалгаврын жишээг урьдчилан боловсруулсан байна. Тэгээд сургалтын эхний үйл ажиллагаанаас эхлээд л багш суралцагчдыг ажиглан тэмдэглэл хөтөлнө.

Суралцагчдын эзэмшсэн мэдлэг, чадварыг илрүүлэх шалгуур, түүнд харгалзах даалгаврын жишээг “Өөртөө итгэх итгэл” дэд сэдвээр жишээлэн үзүүлээ. Энэхүү сэдвийн хүрээнд эзэмших чадварыг хөтөлбөр болон дээрх б) хүснэгтэд тодорхойлсноор авсан бөгөөд даалгаврын жишээг боловсруулахдаа Амьдрах ухаан сургалтын хөтөлбөр (2008, хуудас 5-15)-ийг ашиглав.

Эзэмших чадвар	Шалгуур (илрүүлэгч)	Даалгаврын жишээ
Жишээг уншин, санаа бодлоо илэрхийлэх	Өгсөн эхийг уншиж буй байдал	8 дугаар хуудасны “Би чамайг хамгаална” эхийг уншаарай. (Багш эхийн 1-3 өгүүлбэрийг суралцагчид ээлж дараалан уншихаар зохицуулж болно.)
	Асуултад хариулж, санаа бодлоо илэрхийлж буй байдал	“Би чамайг хамгаална” эх дэх дүрийн талаар дараах асуултад хариулаарай. • Сугар яагаад ийм хэрэг үйлдэх болсон бэ? • Сугар, Төрөө 2 ямар зантай хүүхдүүд вэ? • Ямар үед найзууд бие биенийхээ үгэнд орох ёстой вэ? • Төрөө өөртөө итгэлтэй хүн мөн үү? Яагаад? • Таны таних хүмүүс дотор Сугар, Төрөө шиг зантай хүн бий юу? • Энэ эхээс ямар сургамж авч болох вэ? Саналаа хэлнэ үү.
Өөртөө итгэлтэй ба итгэлгүй зангийн онцлогийг харьцуулан давуу ба сул талыг ялгах	Өөртөө итгэлтэй ба итгэлгүй зангийн онцлогийг харьцуулан уншиж, давуу ба сул талыг нэрлэж буй байдал	Өөртөө итгэлтэй ба итгэлгүй зангийн онцлогийн талаар товч мэдээлэл (хуудас 9)-ийг уншиж 8 төрлийн онцлог бүрээр давуу ба сул талыг хэлнэ үү.
	Эх дэх дүрүүдийг дээрх онцлогуудаар шинжиж, өөртөө итгэлтэй эсэхийг тогтоож буй байдал	“Батаа хүү яагаад ганцаардсан бэ?”, “Би чамайг хамгаална” эх дэх Батаа, Сугар нарыг дээрх онцлогуудаар шинжиж, өөртөө итгэлтэй эсэхийг нь тогтооно уу.
Өөрийн онцлог, давуу талаа илэрхийлэх	Өөрийн онцлог, давуу талаа тодорхойлон бичиж буй байдал	Загварыг ажиглан өгүүлбэрийг гүйцээж бичнэ үү (хуудас 12). • Миний амжилт ба үйл ажиллагаа • Миний итгэл үнэмшил, зорилго • Миний итгэл ба эрх мэдэл • Миний шийдвэр ба хариуцлага • Миний харилцаа, байр суурь • Миний хосгүй талууд • Миний орчин ба би • Миний орон зай
	Өөрийн онцлог, давуу талаа илэрхийлэн хэлж буй байдал	Дээрх даалгавар дахь өгүүлбэрийг гүйцээж бичсэнээ дэлгэрүүлэн ярина уу.

Итгэлтэй харилцааны арга барилд суралцах	Санаа бодлоо төвлөрүүлэн үгээ бодож хэлж байгаа эсэх	Сонгосон сэдвээр ярилцах, үйл гүйцэтгэх явцад, сургалтын бус цагаар суралцагчид хос хосоороо, суралцагч багштай, эсвэл суралцагч танил боловч дотно биш хүнтэй, эсвэл суралцагч танихгүй хүнтэй харилцах явцыг багш ажиглан өгсөн шалгуураар тухайн суралцагч итгэлтэй харилцааны арга барилд суралцаж буй эсэхийг илрүүлж болно.
	Цэх сууж буй эсэх	
	Ярилцагчаа өөртөө хандуулж буй байдал	
	Ярилцагчийнхаа өөдөөс харж байгаа эсэх	
	Үгээ сонсогдохоор тод хэлж буй эсэх	
Зүйр цэцэн үг олж, утгыг тайлбарлах, цээжлэх	Зүйр цэцэн үгсийг олж, утгыг тайлбарлаж буй байдал	- Дараах зүйр цэцэн үг, хэлц үгсийн утгыг тайлбарлана уу. Бусдын эрхээр жаргаснаас өөрийн эрхээр зовсон нь дээр. Эзэн хичээвэл заяа хичээнэ. Зорилгогүй хүн элсэнд шингэсэн устай адил. Өөртөө эзэн байх Бусдад толгойгоо мэдүүлэх - Эдгээрээс гадна сэдэвтэй холбоотой ямар зүйр цэцэн үгийг мэдэх вэ? Бичиж, утгыг тайлбарлана уу.
	Зүйр цэцэн үгийг цээжлэн хэрэглэх байдал	- Цээжилсэн зүйр цэцэн үгсээ бичнэ үү. - Батаа хүүгийн амжилтад хэлц болон зүйр цэцэн үгсээс аль нь тохирох вэ? Сугарын хувьд аль нь тохирох вэ?

Арга зүй

Сургалтыг тухайн сумын АББ-ын багш хариуцан зохион байгуулах бөгөөд сургалтын явцад тухайн сэдвийг мэдэх мэргэжлийн хүмүүс, энэ чиглэлээр мэргэшсэн, туршлагажсан орон нутгийн иргэд, ЕБС-ийн багштай хамтарч болно. Сургалтад:

- Багшлах онол, арга зүйг хослон хэрэглэх
- Танхимын болон танхимын бус сургалтын арга, хэлбэрүүдийг ашиглах
- Танхимын бус сургалтын үед сургалтын агуулгыг бие даан эзэмшүүлэхэд багш анхаарч, явцад нь хяналт тавьж ажиллах
- Зүйр цэцэн үг, хэлц хэллэг, оньсого таавар, үлгэр, тууль, сургаал үгүүдийг сэдэв, агуулга бүрт тусган ашиглах
- Өгөгдсөн сэдвүүдтэй холбоотой жишээ, баримт танилцуулах
- Насанд хүрэгчдийн амьдралын туршлага, үгийн нөөцийг аль болох сайн ашиглаж, өдөр тутмын амьдрал, зан үйлтэй нь холбох арга хэрэглэх
- Ялангуяа амьдрах ухаантай холбоотой мэдлэг нь суралцагчдын бодит амьдралтай хэрхэн уялдаж байгаа талаар тэднээр яриулах, эх бичүүлэх
- Суралцагчдын бодол санааг сонсох, оролцоог дэмжих (сэдэл үүсгэх)
- Оролцогчийг танин мэдэх (сонирхол, чадамжийг тодорхойлох)
- Хөдөлгөөнт тоглоомын аргууд хэрэглэх
- Эрэн хайх, цуглуулах (судалгааны арга)
- Суралцагчаар дамжуулан гэр бүлийн бусад гишүүд, иргэдэд сурсан мэдлэгээ хуваалцах, түгээх, хамтран ажиллаж, туршлага солилцох
- Оновчтой үйлийг төлөвлөх, хэрэгжүүлэх
- Тухайн сэдэв, агуулгатай холбоотой орон нутгийн ардын зан үйл, уламжлалаас сургалтандаа шигтгэж, хэрэглэх

зэрэг үйл ажиллагаануудыг төлөвлөн хийх нь үр дүнд хүргэнэ.

Суралцагчдын мэдлэг, боловсролын түвшин, нас, хэрэгцээ шаардлагаас хамааран тухайн сэдвийг судлах цагийн хуваарилалт уян хатан байна.

Суралцагчдад хийж бүтээх хэрэгцээ, сонирхлыг төрүүлэхүйц байдлаар сургалтын үйл ажиллагааг төлөвлөн, хэрэглэгдэхүүнийг бэлтгэх, саналыг нь харгалзан баг, бүлгүүдэд хувааж хамтран ажиллах арга, эв дүйд сургах, зорилго чиглэлтэйгээр хичээлийг зохион байгуулж, суралцагчдад бүтээлч үйлийн сэдэл төрүүлж, сэтгэлзүйн таатай орчин бүрдүүлэх, ялангуяа орон нутгийн нөөц боломжинд тулгуурлан тухайн судалж буй сэдэв, агуулгатай холбоотой материаллаг орчин бүрдүүлэх, нутгийн иргэдийн бодит амьдралтай холбох, сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах зэрэг бүхий л арга замаар сургалтыг эрчимжүүлнэ.

Багш Та тодорхой шатны сургалтаар орон нутгийн болон суралцагчийн хэрэгцээг үндэслэн заасан бүлэг сэдвүүдээс 2-оос багагүйг сонгон дээрх цагт багтаан судлах сургалтын хөтөлбөрөө боловсруулна. Ингэхдээ сонгосон бүлэг сэдвийн агуулгыг хэрэгжүүлэх цагийн хуваарилалтыг уян хатан төлөвлөж болно.

Бичиг үсгийн дунд шатны сургалтын явцад “Амьдрах, аж төрөх ухаан” сэдвийг судлах хөтөлбөрийг боловсруулахад багш танд баримжаа болгох үүднээс дэд сэдвийг судлах цаг, хэрэгжүүлж болох үйл ажиллагааны нэгэн хувилбарыг орууллаа. Үүнийг багш заавал мөрдөх албагүй, харин өөрийн туршлага, ур чадвар, суралцагчдын сурах чадварыг харгалзан бүлэг сэдэв, судлах цагаа зохицуулах боломж нээлттэй.

Сэдэв	Цаг		Хэрэгжүүлж болох үйл ажиллагаа	Үнэлгээ
	Ц	БД		
Дунд шат (Цугларалтаар 12, бие даан судлах 16 цаг)				
Өөртөө итгэх итгэл	2	2	- Багш сургалтад шаардлагатай хэрэглэгдэхүүнийг урьдчилан бэлтгэх - Амьдрах ухааны цуврал №2: Өөртөө итгэх итгэл (2003, 2007), Та өөртөө итгэдэг үү? (2010) номонд буй “Өөртөө итгэх итгэл” асуулгад хариулж суралцагчид өөрсдийгөө тодорхойлох - Амьдрах ухааны сургалтын хөтөлбөр (2008)-ийн 5-13 дугаар хуудас, Та өөртөө итгэдэг үү? Гарын авлагаас багшийн зөвлөн сонгосны дагуу суралцагчид агуулгыг судлаж, үйл гүйцэтгэн, хоорондоо мэдээллээ солилцох - Сэдэвтэй холбоотой зүйр цэцэн үг олж цээжлэх, утгыг тайлбарлах - Өөртөө итгэх итгэлийг сайжруулах дасгал хийхдээ мэдэрсэн зүйлийн талаар 80-100 үгтэй эсээ бичих	- Амьдрах ухааны сургалтын хөтөлбөр (2008)-ийн 14-15 дугаар хуудсанд буй сорилоор сургалтын эхэн болон төгсгөлд суралцагчид өөрсдийгөө үнэлнэ. - Суралцагчдын чадвар эзэмшилтийн байдлыг багш ажиглаж тэмдэглэл хөтөлнө, шалгана.
Сэтгэлийн хөдөлгөөн	2	4	- Амьдрах ухааны сургалтын хөтөлбөр (2008)-ийн 50-74 дүгээр хуудас, Зовох цагт... (2009), Сэтгэлийн хөдөлгөөнөө жолоодохуй (2010) гарын авлагын агуулгыг суралцагчид багшийн зөвлөснөөр сонгон судлах, холбогдох үйл ажиллагаа, тоглоом, даалгаврыг гүйцэтгэх - Сэдэвтэй холбоотой зүйр цэцэн, хэлц үг, сургаал үгсийн утгыг тайлбарлах, цээжлэх - Сэтгэлийн хөдөлгөөнөө хянах, стрессээс сэргийлдэг аргынхаа талаар эсээ бичих	- Амьдрах ухааны сургалтын хөтөлбөр (2008)-ийн 62, 73 дугаар хуудсанд буй сорилоор үнэлнэ. - Суралцагчдын чадвар эзэмшилтийг багш ажиглаж тэмдэглэнэ.
Шийдвэр	2	2	- Ахуй амьдралд тулгамддаг асуудал, гаргадаг шийдвэрийн талаар эргэцүүлэн бодох, ярилцах - Амьдрах ухааны сургалтын хөтөлбөр (2008)-ийн 38-48 дугаар хуудас, Долоо хэмжиж нэг	Амьдрах ухааны сургалтын хөтөлбөр (2008)-ийн 49 дүгээр хуудас, Долоо хэмжиж нэг огтол (2009) номын 24

			огтол (2009) гарын авлагыг суралцагчид судлан, үйл ажиллагааг сонгон гүйцэтгэх Амьдралдаа, эсвэл орон нутагт тулгамдаж буй асуудлыг шийдэхэд хувь хүний оруулах хувь нэмрийн талаар эсээ бичих	дүгээр хуудсан дахь сорилоор үнэлнэ. Суралцагчдын чадвар эзэмшилтийг багш ажиглаж тэмдэглэнэ.
Харилцаа	2	4	- Уламжлалт мэндлэх, хүндлэх ёсны талаар суралцагчидтай ярилцах - Сэдэвтэй холбоотой жишээг анхааралтай уншиж, эргэцүүлэх, жишээнд тохирох зүйр цэцэн үгсийг олж бичих, утгыг тайлбарлах, цээжлэх - Амьдрах ухааны сургалтын хөтөлбөр (2008)-ийн 16-35 дугаар хуудас, Хамгийн чухал зүйлийн тухай ярилцах уу (2008), Харилцааны саятан (2008), Аавын хүү арван янз (2010) гарын авлагын агуулгаас суралцагчид багшийн зөвлөснөөр сонгон судлаж, зааврын дагуу ажиллах, мэдээллээ харилцан солилцох - Судлах явцад суралцагчид өөрийгөө тодорхойлж, өөртөө дүгнэлт хийх - Олж авсан мэдлэг, чадвар нь тэдний амьдралтай хэрхэн уялдаж, ямар бэрхшээл тулгарч байгаа талаар ярилцах	- Амьдрах ухааны сургалтын хөтөлбөр (2008)-ийн 35 дугаар хуудсан дахь сорилоор үнэлнэ. - Суралцагчдын чадвар эзэмшилтийг багш ажиглаж тэмдэглэнэ.
Төлөвлөлт	2	2	- Амьдрах ухааны сургалтын хөтөлбөр (2008), Өчигдөр, өнөөдөр, маргааш (2009) гарын авлага дахь “Та хэр сайн төлөвлөгч вэ?” сорилыг суралцагч гүйцэтгэн өөрийгөө тодорхойлох - Амьдрах ухааны сургалтын хөтөлбөр (2008)-ийн 75-86 дугаар хуудас, Өчигдөр, өнөөдөр, маргааш (2009) гарын авлагын агуулгыг сонгон судлах, заасан үйл ажиллагаа, тооцох даалгаврыг хийх - Сэдэвтэй холбоотой зүйр цэцэн үгсийг олж бичих, утгыг тайлбарлах, цээжлэх - Хүсэл зорилгоо тодорхойлж, ойрын ба ирээдүйн төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга замаа бичих	Өдөр, долоо хоногийн үйл ажиллагааны төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж буй байдлыг багш ажиглаж тэмдэглэл хөтөлнө.
Бүтээлч сэтгэлгээ	2	2	- Амьдрах ухааны сургалтын хөтөлбөр (2008)-ийн 89-95 дугаар хуудас, Амьдралд хөл тавих нэгэн гүүр буюу таны оюуны чадамж (2008), Ердийнх үү, ер бусынх уу? (2010) гарын авлагаас багшийн хуваарилснаар агуулгыг сонгон судлах, холбогдох үйл ажиллагааг гүйцэтгэх - Хүсэл зорилгоо, түүнд хүрэхийн тулд авах арга хэмжээг тодорхойлж, найз нөхөд орон нутгаас дэмжлэг авах хүсэлт, өргөдөл бичих дадлага хийх	- Амьдрах ухааны сургалтын хөтөлбөр (2008)-ийн 96 дугаар хуудсан дахь сорилоор үнэлнэ. - Багш тэмдэглэл хөтөлнө.

Тайлбар: Ц - цугларалтаар, БД - бие даан

Сургалтын явцад сэдэвтэй холбоотой агуулга бүхий бусад гарын авлагыг ашиглаж болно.

Дунд шатны сургалтад сэдвээ заахдаа өгсөн загвараар ажиллах, бие даан ажиллах, тайлбарлах, санаа бодлоо илэрхийлэх зэрэг үйлийг дараалан хийлгэж суралцагчдыг сурах арга барилд сургахад багш анхаарна. Жишээлбэл, Амьдрах ухаан сургалтын хөтөлбөр (2008)-өөр “Өөртөө итгэх итгэл” дэд сэдвийг заахдаа (хуудас7-15) эхний эргэцүүлэх жишээг

суралцагчид уншин, багшийн чиглүүлснээр асуултад хамтран хариулж ярилцсаны дараа хоёр дахь жишээг бие даан гүйцэтгэх байдлаар ажиллаж болно.

АББ-ын Гэгээрэл төвийн сургалтад хамрагдаж байгаа хүмүүс санаа бодлоо илэрхийлэх, хүмүүстэй чөлөөтэй харилцахдаа тааруу, биеэ барих, эмээх, ичих, дуу цөөтэй байх явдал ажиглагддаг тул сургалтын явцад суралцагчдаар аль болох яриулах, санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх үйл ажиллагааг эхлээд суралцагчдын дунд, дараа нь хөндлөнгийн хүмүүсийг байлцуулах байдлаар зохион байгуулах нь тэдний хэл яриаг хөгжүүлж, нээлттэй болгоход ач холбогдолтой. Санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх чадвар эзэмших нь цаашид тэд амьдралдаа тулгамдсан асуудлаа шийдэхэд нь ч хэрэгтэй билээ.

Хэрэглэгдэхүүн

- Амьдрах ухааны цуврал гарын авлага №1-11, АББЗСҮТ, УБ., 2003, 2007
- Зайны сургалтын гарын авлага /цувралууд/, АББЗСҮТ, УБ., 2005, 2006, 2007, 2008
- Д.Гүндэгмаа, О.Чулуунцэцэг, Билгийн нүд-2, АББЗСҮТ, УБ., 2006
- Д.Гүндэгмаа, О.Чулуунцэцэг нар, Билгийн нүд-3, АББЗСҮТ, УБ., 2007
- Амьдрах ухааны сургалтын хөтөлбөр, АББЗСҮТ, ЮНИСЕФ, УБ., 2008
- ЮНЕСКО “Сурч амьдаръя” төсөл. /цуврал гарын авлагууд/, УБ., 2000
- ЮНЕСКО “Говийн малчин эмэгтэйчүүд төсөл”. / Цуврал гарын авлагууд/, УБ., 1996
- Ч.Аръяасүрэн, Х.Нямбуу, Монгол ёс заншлын их тайлбар толь, УБ., 1992
- О.Мягмар, Харилцааны саятан, Амьдрах ухааны сургалтын гарын авлага №1, АББЗСҮТ, УБ., 2008
- З.Тогтохмаа, Хамгийн чухал зүйлийн тухай ярилцах уу, Амьдрах ухааны сургалтын гарын авлага №2, АББЗСҮТ, УБ., 2008
- О.Мягмар, Амьдралд хөл тавих нэгэн гүүр буюу таны оюуны чадамж, Амьдрах ухааны сургалтын гарын авлага №3, АББЗСҮТ, УБ., 2008
- З.Тогтохмаа, Долоо хэмжиж нэг огтол, Амьдрах ухааны сургалтын гарын авлага №4, АББЗСҮТ, УБ., 2009
- С.Ундрал, Зовох цагт . . . , Амьдрах ухааны сургалтын гарын авлага#5, АББЗСҮТ, УБ., 2009
- З.Тогтохмаа, Өчигдөр, өнөөдөр, маргааш, Амьдрах ухааны сургалтын гарын авлага №6, АББЗСҮТ, УБ., 2009
- Та өөртөө итгэдэг үү, АББЗСҮТ, УБ., 2010
- Сэтгэлийн хөдөлгөөнөө жолоодохуй, АББЗСҮТ, УБ., 2010
- Аавын хүү арван янз, АББЗСҮТ, УБ., 2010
- Ердийнх үү, ер бусынх уу, АББЗСҮТ, УБ., 2010

2.3. ИРГЭНИЙ УХАМСАР

Хүлээгдэж буй үр дүн

- Өөрийгөө болон бусдыг хүндэтгэх ухамсар, соёл, ёс зүйн талаар мэдлэгтэй болно
- Хувь хүний зүгээс гэр бүл, нийгмийн амьдралд оролцох оролцоо, холбогдох хууль хийгээд ёс зүйн дүрмүүдийг хэрэгжүүлэх чадвартай болно
- Өөрийгөө хөгжүүлдэг, гэр бүл, өвгөд хөгшдөө энэрэн хамгаалдаг, амьдралаа авч явах чадвартай болно
- Гэр бүл, хамт олон, нийгэмдээ үлгэр жишээ үзүүлдэг, нутаг орны хөгжилд хувь нэмэр оруулахаар бусадтай хамтран ажилладаг иргэн төлөвшинө

Дэд сэдэв	Агуулга		
	Мэдлэг	Чадвар	Хэрэглээ
Хувь хүний ухамсар	- Зөв, цэвэр хувцаслалт - Дөрвөн улирлын онцлог ба хувцаслалт	- Зөв, цэвэр хувцаслахтай холбоотой мэдээллийг бусдаас ялгах - Улирлын онцлогт тохируулан зөв, цэвэр хувцаслах ёстойг ойлгох	- Зөв, цэвэр хувцаслалттай холбогдох мэдээллийн төрөл бүрийн эх сурвалжаас цуглуулж, хайчилбар хийх - Хувцас цэвэрлэх зааврыг унших

	- Хувцасны материал - Хувцасны загвар - Олон нийтийн газар, гудамж талбайд биеэ зөв авч явах соёл - Өөрийн өмнө хүлээх үүрэг хариуцлага	- Хувцасны материал хүний эрүүл мэндэд эерэг ба сөрөг нөлөө үзүүлдэг болохыг таних - Хувцасны загварын талаар ойлголттой болох, өөрт тохирох хувцасны хийц, өнгийг мэдэх - Гудамж, олон нийтийн газарт хог, шүлсээ хаяхгүй байх - Ямар нэгэн үйлчилгээ хүртэхдээ дугаарлах ёстойг ухамсарлах - Замын хөдөлгөөний дүрмийг сахих - Өөрийгөө бусдаас ялгаатай давтагдашгүй хүн гэдгийг мэдэх - Өөрийгөө ойлгож мэдэх, давуу, сул тал, зорилгоо таних - Өөрийгөө хөгжүүлэх	- Улирлын онцлогт тохируулан зөв хувцаслах тухай мэдээлэл унших, хэрэгцээт хэсгийг тэмдэглэх - Хувцасны материалын хүний биед ямар нөлөөтэйг уншиж судлах - Хувцасны орчин үеийн загвар, хандлагын талаар сонин сэтгүүл, интернетээс мэдээлэл цуглуулж унших, хэрэгцээтэй хэсгээ тэмдэглэх - Гудамж, талбайд буй хүмүүст зориулсан мэдээллийг унших - Хог хаях, бие засах газрыг заасан дүрс бүхий тэмдэглэгээг унших - Хувь хүний зан чанарын онцлогийг эргэн тойрны хүмүүсийн жишээн дээр эргэцүүлэн бодох - Давуу, сул талаа тодорхойлж бичих - Зорилгоо тодорхойлж бичих - Ирээдүйдээ итгэлтэй, зорилготой амьдрахын тулд өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулж тэмдэглэх
Гэр бүлийн ухамсар	- Гэр бүлийн гишүүдийн сурах эрх - Хүүхдийн хүмүүжил - Гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлага - Гэр бүлийн үнэ цэнэ - Өвгөд хөгшдөө дээдлэн асрах ёс	- Гэр бүлийн сургуулийн насны хүмүүсийг сургуульд хамруулах, завсардуулахгүй байх ёстойг ойлгох - Сурлага, хөдөлмөрт анхаарал тавьж байх ёстойг ухамсарлах - Үр хүүхэд, дүү нараа зөв хүмүүжүүлэх ёстойг ойлгох - Гэр бүлийн гишүүдийн гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг ойлгож мэдэх - Гэр бүлээ хайрлан хамгаалж, бат бэх авч явах - Өвгөд хөгшдөө асарч энэрэх, хүн ёсоор хандах	- Сурч боловсрох эрхийн талаар унших - Сургуульд суралцах хүүхдийн хувцас, хичээлийн хэрэглэлд зарцуулах мөнгийг тооцох - Хүүхэд, дүү нартаа сургамжтай үлгэр уншиж өгөх, зүйр цэцэн үг, сургаал үг цээжлүүлэх - Хүүхдийг хүмүүжүүлж ирсэн эцэг өвгөдийн аргуудыг цуглуулж унших, хэрэгцээтэйг нь тэмдэглэх - Хүүхдийг хүмүүжүүлэх орчин үеийн аргын талаар бүх төрлийн эх сурвалжаас мэдээлэл цуглуулах - Гэр бүлийн үнэт зүйлийн талаар ярилцаж, гишүүдийн гүйцэтгэх үүргийг тайлбарлах - Дуу, шүлэг, захидал болон өдөр тутмынхаа харилцаагаар дамжуулан гэр бүлийнхэндээ хайртайгаа илэрхийлэх - Бат бэх гэр бүлийн мэдээлэл цуглуулж ангилан, хүүхэд, залууст ярих - Өвгөд хөгшдийг асарч дээдэлж ирсэн сургаал, домог цуглуулж унших - Өвгөд хөгшдөө энэрч асрах талаар хүүхэд, залуус, хойч үедээ хэлж сургах

Нийгмийн ухамсар	- Ажил хөдөлмөрийн үнэ цэнэ - Байгууллага, хамт олон - Нийтийн чанартай ажил, түүнд оролцох нь	- Ажил хөдөлмөр эрхэлж амьдрах ёстойг ойлгох - Шударга хөдөлмөрлөж байгууллага, хамт олны үлгэр дуурайл болох, тэднийг манлайлах, дагуулах - Түймэр, бүх нийтийн цэвэрлэгээ зэрэг ажилд идэвхитэй, сайн дураар оролцох ёстойг ухамсарлах, бусдаас шаардах	- Ажилд орох өргөдөл, намтраа бичих - Ажил хөдөлмөрийн үнэ цэнийн талаар хүүхэд, залууст ухуулан ярих - Ажилдаа амжилт гаргасан хүмүүсийн жишээ баримтыг цуглуулан бяцхан ном хийх - Иргэн хүний нийгэмд хүлээх үүрэг, хариуцлагын талаар унших, уншсанаа бусдад тайлбарлах - Бүх нийтийн ажилд сайн дураараа оролцдог болон оролцдоггүй хүний ялгааг тодорхойлж бичих - Бусдын төлөө ажиллаж байгаад амь насаа алдсан хүмүүсийн талаар төрөл бүрийн эх сурвалжаас мэдээлэл цуглуулж, хүүхэд, залууст үлгэр дуурайл болгон ярих. Жишээ нь, Сэлэнгэ аймгийн Мандал суманд гал унтраахаар явсан Онцгой байдлын ерөнхий газрын аврагч 12 залуу амиа алдсан гэх мэт
---	--	---	--

Үнэлгээ

- Хувцас, эд хэрэглэлийг цэвэрлэх зааврыг уншиж, тэмдэглэгээ хийсэн эсэх
- Гудамж, олон нийтийн газарт биеэ хэрхэн зөв авч явах талаар хүүхэд, залууст зориулан сургамжтай зохион бичлэг бичсэн эсэх
- Гэр бүлийн гишүүдийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагаа биелүүлдэг эсэхэд дүгнэлт хийж, тэмдэглэл хөтөлсөн эсэх
- Өргөдөл, намтраа загварын дагуу бичиж, бусдад тайлбарлаж ярьсан эсэх
- Ажиллаж хөдөлмөрлөхийн үнэ цэнийн талаар залууст сургамж бүхий уриалга бичиж, ухуулан сурталчилсан эсэх
- Бүх нийтийн ажилд идэвхтэй оролцох болон оролцохгүй байхын ялгааг тодорхойлон бичиж, залууст ойлгуулсан эсэх

Аргазүй

Хүн амын бичиг үсгийн чадварыг дээшлүүлэх замаар иргэний ухамсрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн энэхүү дэд хэсгийг судлахдаа СУРАЛЦАГЧ та дараах зүйлийг анхаараарай:

1. Суралцагч та өөрийгөө ухамсартай иргэн мөн эсэх талаар эргэцүүлэн бодоорой. Иргэний ухамсар гэж юу болох, яагаад хүн бүр өөрийн болон гэр бүл, нийгмийн өмнө үүрэг хариуцлага хүлээж амьдардаг болохын учрыг олохыг хичээгээрэй. Үүний тулд та АББ-ын Гэгээрлийн төвөөс дараах гарын авлагыг авч судлаарай:
 - Айлаас эрэхээр авдраа удал
 - Та өөртөө хуульч
 - Оюун тэлэхүй
 - АББ-ын Гэгээрлийн төвийн багшийн зөвлөсөн бусад материал

Эдгээр номыг судлах явцдаа та бичиг үсгийн мэдлэг чадвараа улам сайжруулах болно.


2. “Иргэний ухамсар” хэсгийг судлах явцдаа холбогдох материалыг хаанаас олж, хэрхэн ашиглах талаар АББ-ын Гэгээрлийн төвийн багшаас зөвлөгөө авч болно.
3. Хамаатан садан, гэр бүл, найз нөхөддөө захидал бичих, тэмдэглэл хөтлөх зэргээр бичгийн ур чадвараа дээшлүүлэхийг хичээгээрэй.
4. Уншиж судалсан, тэмдэглэсэн зүйлээ зөвхөн өөртөө хадгалах бус гэр бүл, найз нөхөд, хөрш, нэн ялангуяа хүүхэд, залууст тайлбарлан ярихад анхаараарай. Ингэснээр таны үг яриа, бусадтай харилцах чадварууд хөгжихөөс гадна эргээд та иргэн хүний үүднээс хойч үеийг хүмүүжүүлэн төлөвшүүлэх ажилд хувь нэмрээ оруулж буй ухамсартай хувь хүн болно гэсэн үг.

Суралцагчдыг чиглүүлэх БАГШ та дараах зүйлийг анхаараарай:

1. Сургалтын агуулгыг бие даан эзэмшүүлэх талаас нь багш анхаарна. Тухайлбал, шаардлагатай гарын авлагуудаар хангаж, тэдгээрийг хэрхэн ашиглах талаар зөвлөгөө өгөх, хэрэгцээтэй сургалтын материал, агуулгын эх сурвалжийг нь зааж өгөх зэргээр ажиллана.

Бие даан суралцахад нь суралцагчдыг сэдэлжүүлэх нь хамгийн чухал. Өөрөөр хэлбэл, энэ чиглэлийг судалснаар суралцагчийн амьдралд хэр зэрэг ач холбогдол, нөлөө үзүүлэх, өөрчлөлт гарах ёстойг тайлбарлана гэсэн үг. Бие даан суралцах сэдлийг төрүүлэхийн тулд дараах аргаар ажиллаж болно:

- Суралцагчдыг цуглуулан уг хөтөлбөрийн “Иргэний ухамсар” гэсэн хэсгийг яагаад судлах ёстойг тайлбарлан ярина. Ингэхдээ иргэний ухамсар гэж юу болох, яагаад иргэн хүн өөрийн болон гэр бүл, нийгмийн өмнө хариуцлага хүлээдэг талаар жишээ баримтанд тулгуурлаж ухуулан ярина.
 - Холбогдох мэдээ, унших материалыг гэрээр түгээх, санал бодлыг нь сонсох, өөрийнхөө бодлыг хуваалцах, ямар арга зам, аргачлалаар цаашид бие даан судлахыг нь чиглүүлэх зэргээр ажиллана. Шаардлагатай бол бусад мэргэжлийн хүмүүстэй холбож, тэдний дэмжлэг, зөвлөгөөгөөр хангана.
2. Агуулгыг амьдрал, хэрэглээтэй нь холбох, цугларалт, хэлэлцүүлэг, жүжигчилсэн тоглолт зохион байгуулах, бодит жишээн дээр асуудал шийдэх зэрэг бүтээлч байдлаар сургалтыг явуулна.
 3. Иргэдийн хэрэгцээ шаардлага, ажил хөдөлмөрийн онцлог, суралцах чадвартай холбон сургалтын цагийг төлөвлөнө.
 4. Суралцагчдын мэдлэгийн түвшинд тохирсон сургалтын материалыг олон чиглэлээр сонгох эсвэл хялбарчилж ашиглана. Сургалтын явцад бичиг үсгийн дараах шатны багц материал (Оюун тэлэхүй, Та өөртөө хуульч, Айлаас эрэхээр авдраа удал гэх мэт)-уудыг ашиглах нь зүйтэй.



Хэрэглэгдэхүүн

- Алтангэрэл.М, “Иргэн ба хууль”, УБ., 1999
- Баярсайхан.Д, “Хүний эрх ба нутгийн өөрөө удирдах ёс”, УБ., 1999
- Урнаа.Б. нар, “Та өөртөө хуульч”, УБ., 2005
- Тринидад.В, “Хүүхэд таны эрх-1”, УБ., 2002
- Түвшинтөгс.Ц, “Хүүхэд таны эрх-2”, УБ., 2002
- Сурталчилгааны хялбаршуулсан материал

- Сургалтын агуулга тус бүрт шаардагдах тусгай хэрэглэгдэхүүн (цаас, үзэг гэх мэт)

2.4. БАЙГАЛЬ ОРЧИН

Хүлээгдэж буй үр дүн

- Байгаль орчны холбогдолтой бичмэл эх сурвалжыг чөлөөтэй унших ба уншсан зүйлээ ойлгодог болно
- Уншсан, сонссон зүйлийнхээ талаар тэмдэглэл хөтлөх, товчлол хийх, бодол санаагаа илэрхийлж бичнэ
- Сонирхсон зүйлээ хүнээс асуух, хүний яриа, асуулт, тайлбарыг анхааралтай сонсоод зөв хариулах, уншиж мэдсэн зүйлээ бусдад ойлгомжтой ярихад суралцана
- Байгаль орчноо ажиглах, жиших, харьцуулах, шийдвэр, дүгнэлт гаргаж чаддаг болно
- Байгаль орчны талаар сайн мэддэг, хайрлан хамгаалах ухамсар, чадвартай иргэн хүн болж төлөвшинө

Дэд сэдэв	Агуулга		
	Мэдлэг	Чадвар	Хэрэглээ
Хүрээлэн буй орчин	• Хүрээлэн буй орчин дахь юмс үзэгдэл • Хүрээлэн буй орчноо хайрлан хамгаалах уламжлал, зан заншил • Хүрээлэн буй орчноо хайрлан хамгаалах тухай дуу, шүлэг, үлгэр оньсого	• Өрхийн аж ахуй эрхлэхэд хамгийн их нөлөөлдөг үзэгдлийг ажиглах, харьцуулах • Хүрээлэн буй орчинд хамрагдах зүйлийг мэддэг болох • Хүрээлэн буй орчноо хайрлан хамгаалах уламжлал, зан заншлыг мэдэж, хэрэгжүүлэх ёстойг ухамсарлах • Хүрээлэн буй орчинтой холбоотой мэдээлэл, бичвэрийг чөлөөтэй уншиж ойлгодог болох	• Телевиз, радиогийн мэдээ сонсож, товч тэмдэглэл хийж ашиглах • Хүрээлэн буй орчны талаар гэр бүл, найз нөхөд, үр хүүхэддээ ярих • Хүрээлэн буй орчноо хайрлан хамгаалах талаар хүүхэд, залууст зориулсан ярилцлага хийх • Хүрээлэн буй орчноо хайрлан хамгаалахтай холбоотой зан заншлыг үр хүүхэд, хойч үедээ зааж сургах • Төрөл бүрийн эх сурвалжаас хүрээлэн буй орчинтой холбоотой сургаал, зүйр цэцэн үг, хэлц хэллэгийг эмхэтгэн бичих • Нүүж, суухдаа гэрийн буурь, орчин тойрноо цэвэрлэдэг болох
Агаарын бохирдол, түүнийг багасгах арга зам	• Агаар • Агаарын найрлага • Түүнд үзүүлэх нөлөө • Бохир агаар	• Агаарын тухай ерөнхий ойлголт эзэмших • Цаг агаарын мэдээ унших, ашиглах • Цаг агаарын байдлыг тэмдэглэдэг таних тэмдгийг ялгаж сурах	• Агаар хүнд ямар ач холбогдолтой болох тухай бусдад таниулах • Ногоон ургамал, цэцэг тарих, мод ургуулах • Угаартсан хүнд анхны тусламж үзүүлэх • Байгаль орчинд элдэв төрлийн химийн гаралтай бодисыг шатаалгахгүй байх

Усны бохирдол, түүнийг багасгах арга зам	- Усны бохирдол - Усыг бохирдуулагч гол эх үүсвэрүүд - Усны бохирдлоос үүсэх хор уршиг - Усны бохирдлыг бууруулах, түүнээс сэргийлэх арга зам - Уламжлалт аргууд	- Усны бохирдлын талаар ерөнхий ойлголт эзэмших - Усыг бохирдуулагч гол эх үүсвэрүүдийг мэдэж авах - Сэргийлэх арга зам, уламжлалт аргуудыг мэдэж авах	“Ус бол чандмань эрдэнэ” хэлэлцүүлэг явуулах - Гол горхи, булаг шандыг хамгаалалтад авах - Усны бохирдлоос үүсэх хор уршигийг бусдад тайлбарлах - Усны бохирдлыг бууруулах, түүнээс сэргийлэх уламжлалт арга замуудыг хэрэглэх
Хөрс, газрын доройтол	- Хөрс - Хөрсний төрөл - Хөрс бохирдох шалтгаан - Хөрсний элэгдэл	- Хөрсний тухай ойлголт эзэмших - Хөрсний төрлийг тодорхойлж сурах - Хөрсний бохирдлоос сэргийлэх талаар унших, хэрэгцээт мэдээллээ бичиж тэмдэглэх - Хөрсний элэгдэл, бохирдлоос үүсэх өвчлөлт түүнээс сэргийлэх талаар анхааралтай унших, товчлон бичиж тэмдэглэх - Хөрс, газар нутагтай холбоотой ерөөл, магтаал, зүйр цэцэн үг, ардын аман зохиолыг олж унших, цээжлэх, хэрэглэх	- Хөрсийг ариг гамтай зөв ашиглах, арчлах - Хөрсний бохирдол, элэгдлийн талаар бусдад таниулах - Газрыг зөв ашиглахад ухамсартай хандах - Хүнсний ногоо тариалахад үржил шимтэй хөрсийг сонгох - Хөрсний төрлийг мэдэхэд бусдаас тусламж авах, зааж сургасныг нь бичиж тэмдэглэх - Телевиз, радио, сонин бусад мэдээллийн хэрэгслээс шинэ мэдээлэл олох, ашиглах, бусдад түгээх - Газрын доройтлоос сэргийлэх зорилгоор зам тавих, зүлэг ургуулах
Ургамал	- Ургамал - Ургамлын төрөл - Эмийн ургамал - Хүнсний ногоо - Жимс, жимсгэнэ	- Эмийн ургамал, хүнсний ногоо, жимс жимсгэнэ түүх, хадгалах аргад суралцах - Ургамал, хүнсний ногоо, жимс жимсгэний бут тариалах, арчилах, услах, хураах, хадгалах тухай мэдээлэл цуглуулан, хэрэгцээт хэсгийг тэмдэглэж бичих - Ургамалтай холбоотой ерөөл, магтаал, зүйр цэцэн үг, ардын аман зохиолыг олж унших, цээжлэх, хэрэглэх	- Ургамлын төрлүүд, тэдгээрийг амьдрал ахуйдаа ашиглах - Эмийн ургамал, хүнсний ногоо, жимс жимсгэнэ түүх, хадгалах - Хэрэгцээт хүнсний ногоо, жимс жимсгэнээс сонгон тариалж, ахуй амьдралдаа хэрэглэх - Ургамлын холбогдолтой шүлэг, дуу, билэг дэмбэрэл, ерөөлийг хүүхдэд цээжлүүлэх - Гэр бүлийн хэрэгцээнд зориулан тарьсан хүнсний ногоо, жимс жимсгэнээ бусаддаа сурталчлах, арга туршлагаа солилцох
Хог хаягдал	- Хог хаягдал - Хог хаягдлын төрөл - Хаягдлыг ашиглах	- Хог хаягдлын төрлийг мэдэж авах - Устаж үгүй болдоггүй хог хаягдлын талаар уншин, гол зүйлийг тэмдэглэж авах - Сэдэвтэй холбоотой зүйр цэцэн үг олж	- Хог хаягдал тарьж буй этгээдэд шаардлага тавих - Орчиндоо хог хаягдалгүй хэвшилтэй болох - Хог хаягдал ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бусдад суртчилах

		цээжлэх, яриандаа хэрэглэх Бусдад зориулан хаягдал ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэх талаар бяцхан ном хийх	- Сонирхож, сурахыг хүсч буй зүйлийнхээ талаар мэдээлэл цуглуулах, ангилах, хэрэглэх - Хэрэгцээт мэдээллээ бусадтай хуваалцах, хамтран ажиллах - Хортой болон хоргүй хог хаягдлын талаар бусадтай санал, бодлоо солилцох
Нийтийн тээвэр, олон нийтийн газар	- Цэвэр орчин - Нийтийн тээвэр - Олон нийтийн газар - Сургууль	- Цэвэр орчинд аж төрөхийн ач холбогдлыг ухаарах - Цэвэр орчинд хэрхэн биеэ авч явах талаар суралцах - Цэвэр орчны анхааруулсан тэмдгийг танин мэдэх	- Нийтийн ёс журмыг сахих - Энэ сэдвээр олж авсан мэдлэг, чадвар нь тэдний бодит амьдралтай хэрхэн уялдаж байгаа талаар суралцагчдаар яриулах - Суралцагчид мэдлэг чадвараа амьдралдаа хэрэгжүүлсэн байдал, энэ нь тэдний амьдралд тодорхой нөлөө үзүүлсэн эсэх, ямар бэрхшээлтэй учирсан тухай ярилцах
Экологийн цэвэр хоол хүнс	- Байгалын гаралтай хоол хүнс - Химийн гаралтай хоол хүнс - Тэдгээрийн ялгаа	- Экологийн цэвэр хоол хүнсний ялгааг таних - Хоол хүнсний сав, баглаа боодол дээрх хадгалалтын болон үйлдвэрлэсэн хугацааг таньж мэдэх	- Удаан хадгалагддаг болон лаазалсан бүтээгдэхүүнийг хэрэглэх - Химийн бордоо хэрэглэхийн хор холбогдол болон эрүүл мэндэд хортой элементүүдийг бусдад таниж мэдүүлэх, зөвлөгөө өгөх
Өдөр тутмын амьдралд хэрэгтэй зүйл	- Өргөн хэрэглээний эм - Эмэн бүтээгдэхүүн - Эмийн төрлүүд - Эмийн найрлага дах химийн бодис	- Эмийн хэрэглээний талаар ерөнхий ойлголттой болох - Эмийн бүтээгдэхүүн дээрх зааварчилгааг уншиж, ойлгох - Шавьж, амьтан устгах хорны төрлийг танин ялгах	- Эмийг зөв хэрэглэх, хадгалах - Эм болон хоронд хордсон хүнд анхны тусламж үзүүлэх - Шавьж, амьтан устгах хорны хүний биед үзүүлэх нөлөө, хэрэглэх зааврыг бусдад уншиж таниулах - Эмийн буруу хэрэглээнд хяналт тавих, бусдад анхааруулах

Үнэлгээ

Өөрийн үнэлгээний хэлбэр голлоно. Сургалтын явцад анхаараал, ой тогтоолт, унших, бичих чадвараа хэрхэн хөгжүүлж байгаа, эрүүл аж төрөх дадал хэвшилтэй болж байгаа эсэх, байгаль орчноо танин мэдэх хүсэл тэмүүлэл, байгалиа хайрлан хамгаалах үзэл хэрхэн төлөвшиж, түүнтэй хэрхэн харьцаж, байгалийн нөөц баялагийг хэрхэн ашиглаж буйгаар үнэлнэ. Сэдвийн явц болон төгсгөлд суралцагчдын өөрийн үнэлгээ, багшийн баталгаажуулах үнэлгээг сорилго, жишиг даалгавар, бүтээлээр үнэлэх аргаар хийнэ.

Өөрийгөө үнэлэх сорилгын жишээ:

№	Асуулт	Сайн (2 оноо)	Дунд зэрэг (1 оноо)	Тааруу (0 оноо)
1	Хүрээлэн буй орчныг бүрдүүлэх зүйл, тэдгээрийг хайрлан хамгаалах талаар сургамж бэлтгэн, ярьж чадна			

2	Хүрээлэн буй орчныг хайрлан хамгаалах уламжлал, зан заншлын талаар хойч үедээ тайлбарлан ярьж чадна			
3	Байгалийн үзэгдэл юмс, тэдгээрийн харилцан хамаарлыг хүүхэд, залууст тайлбарлан ярьж чадна			
4	Байгаль, цаг агаарыг урьдчилан тааварлах талаар тэмдэглэл хөтөлж, хүүхэд, залууст сургаж чадна			
5	Байгалийн гамшигт үзэгдлүүд, тэдгээрээс хэрхэн хамгаалах аргачлал бүхий бяцхан ном хийж чадна			
6	Байгалийн баялагтай зүй зохистой харьцах, ашиглах талаар сургамж бичиж чадна			
7	Орон нутагт ургадаг ургамал, амьдардаг ан амьтны тухай мэдээлэл бэлтгэж, хүүхэд, залууст түгээж чадна			
8	Байгаль орчинд хорт нөлөө үзүүлдэг хүний буруутай үйл ажиллагааны талаар бусдад ухуулан ярьж чадна			
9	Байгальд харш үйл ажиллагаа явуулдаг хувь, байгууллагад хандсан уриалга бичиж чадна			
10	Байгаль хамгаалах баг, нөхөрлөл байгуулах төлөвлөгөө гаргаж, үйл ажиллагааг нь тодорхойлж чадна			

15-20 оноо – зорилгоо сайн биелүүлсэн, багшаараа баталгаажуулах үнэлгээ хийлгэхэд бэлэн болсон

9-14 оноо – зорилгоо дунд зэрэг биелүүлсэн, зарим зүйлийг дахин давтах

8–аас доош оноо – дахин ажиллах шаардлагатай

Багш суралцагчийн өөрийн үнэлгээтэй танилцаад, баталгаажуулах үнэлгээ хийнэ.

Сэдвийн явц болон төгсгөлд суралцагчийг доорх жишээгээр үнэлж болно.

- Байгаль орчноо хайрлан хамгаалахын ач холбогдолыг мэдэж, ойлгосноор бусдад цэгцтэй ярьж тайлбарлах, байгалын бохирдлоос урьдчилан сэргийлэх аргыг хэлэх. Энэ талаар гарсан гарын авлага, ном, хэвлэмэл материалыг унших
- Байгалийн гамшигт үзэгдлээс сэрэмжлэх, бусдад сануулах
- Хүрээлэн буй орчин дахь юмс үзэгдэлтэй сонин хэвлэлээс уншиж танилцах
- Эмийн заавар уншиж, зааврын дагуу хэрэглэх
- Эмийн заавар уншаад, хүчинтэй хугацааг харах
- Бохир агаарын өвчин юунаас үүсдэг, хэрхэн урьдчилан сэргийлэх, туссан үед авах арга хэмжээний талаар ярих
- Хөрсний элэгдэл, бохирдолоос үүсэх халдварт болон халдварт бус өвчнүүдийг нэрлэх, илрэх шинж тэмдгүүдийг, авах арга хэмжээг хэлэх
- Угаартсан үед анхны тусламж үзүүлэх аргуудаас хэлэх
- Гэр орны нөхцөлд хортон шавьж устгах энгийн аргаас нэрлэх
- Жимс жимсгэнэ түүх, хадгалах аргыг мэдээлэх
- Хортой ба хоргүй хаягдал, дахин ашиглаж болох хог хаягдлын ялгааг тайлбарлах
- Цэвэр орчны анхааруулсан тэмдгийн учир холбогдлыг ойлгосон байх
- Хоол хүнсний сав баглаа боодол дээрх хадгалалтын болон үйлдвэрлэсэн хугацааг таньж мэдэх
- Эрүүл мэндэд хортой элементүүдийг нэрлүүлэх
- Шавьж амьтан устгах хорны хүний биед үзүүлэх нөлөө, хорыг хэрэглэх зааварчилгаа унших
- Хүрээлэн буй орчны талаар бусдад эмх цэгцтэй мэдээлэл хүргэж байгаа эсэх
- Хүрээлэн буй орчныг хайрлаж хамгаалах талаарх уламжлал, зан заншлуудыг тайлбарлан ярих
- Хүрээлэн буй орчинтой холбоотой сургаал, зүйр цэцэн үг, хэлц хэллэг бүхий бүтээлийн дэвтэр хийсэн эсэх

Арга зүй

Байгаль орчны боловсролыг олгох хөтөлбөрийн хүрээнд ашиглаж болох ном, сурах бичиг, гарын авлагыг хэрэглэн суралцагч бие даан суралцана. Түүнчлэн сургалтыг хүртээмжтэй, үр дүнтэй болгоход орон нутгийн нөөц, боломжийг сайн ашиглаж, иргэд олон нийтийн байгууллагыг өргөнөөр оролцуулж хамтран ажиллана.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багшлах арга зүйг олон янзын аргад тулгуурлаж, суралцагчийн оюун ухааныг тэлэх нь чухал юм. Үүнтэй холбогдон сургалтад хэсэг, бүлгийн зохион байгуулалтыг гэхэд л олон янзаар хувирган ашиглаж болно. Оролцогчдын тоо, тэдний оролцооны чадамжаас хамааруулж, мөн тоглоомын арга хэрэглэн хэсэг, бүлэгт хуваах нь илүү оновчтой. Тухайн сургалтын агуулга, цаг хугацаанаас хамаарч хэсэг, бүлгийг шууд хуваарилах, эсвэл хэсэг, бүлгүүдэд туршлагатай, чадвартай суралцагчдыг тэгш хуваах ингэхдээ хэсэг, бүлгээ янз бүрийн түвшний хүмүүсийн хослолоор бүрдүүлэх нь хэсэг, бүлгийн ажлыг өгөөжтэй болгож, илүү хөгжилтэй, нээлттэй орчныг бүрдүүлж өгдөг.

Сургалтыг явуулахдаа дараах зүйлийг анхаарна:

- Үндэстэн/ угсаатны зан үйл, уламжлалд тулгуурлан зохион байгуулах
- Зүйр цэцэн үг, оньсого таавар, үлгэр, тууль, сургаал үгсийг сэдэв, агуулга бүрт тусган ашиглах
- Насанд хүрэгчдийн амьдралын туршлага, өдөр тутмын амьдрал, зан үйлтэй нь холбох
- Суралцагчдын хэрэгцээ, шаардлагыг судлах, сургалтыг түүнд чиглүүлэх

Жишээ хувилбар : ЗУРАГТ ХУУДАС



**Байгалийн
гамшиг**



**Ус
чандмань**

Товч агуулга

Оновчтой асуудал хэлэлцэх энэхүү арга нь уран сэтгэмж бий болгох, суралцагчид үзэл бодлоо солилцох, товчхон мэдээлэх хийх, түүнчлэн тухайн сэдвийн талаар мэдрэмж, ойлгоцоо тодорхой дүрслэлийн болон бичгийн хэлбэрээр илэрхийлж сурахад нь тусалдаг.

Заавар:

1. Суралцагч бүр сургалтын ерөнхий сэдэвтэй холбоотой сэдэв сонгоно
2. Сэдвийн талаар өөрийн үзэл санааг бэлтгэнэ. *(Энэхүү зурагт үзүүлэнгийн утга санаа нь ажиглагчдад ямар ч нэмэлт аман тайлбар, урт бичвэргүйгээр ойлгогдохоор байх ёстой)*
3. Сэдвийн талаах тайлбараа өрөөний эргэн тойронд харагдахуйцаар байрлуулж хэлэлцүүлнэ.
4. Сургалтын нэг хэсэг дуусахаас 15 минутын өмнө бүх оролцогчдыг цуглуулж, энэ үйл ажиллагаанаас ямар хэрэгтэй зүйл олж авав гэдгийг ярилцана.
5. Сэдвийн цар хүрээ хязгаартай бол хүн бүр бие даасан даалгавар авахын оронд 2, 3 - аараа нэг баг болж болох юм.
6. Хэлэлцүүлгээр хананд байрлуулсан зурагт хуудаснуудаас ашиглаж болно.

Хэрэглэгдэхүүн

- Албан бус боловсролын сургалтын материал/Амьдрах ухаан/, УБ.,2004
- АББЗСҮТ "Малчин хүүхдийн боловсрол төсөл"Газрын шимийг хүртье. УБ.,1999
- Байгаль орчны шинжилгээний төв лаборатори. Хүчиллэг тунадас – Агаарын бохирдол. УБ.,2003
- Дэлхийн зөн"Хамтын эзэмшлийн ойн төсөл". Миний нутгийн байгаль – экологи. УБ.,2001
- Албан бус боловсролын сургалтын материал/Гялгар уут хаягдал мөг үү/, УБ.,2007
- Монгол Улсын Засгийн Газар. "Бүх нийтийн экологийн боловсролын үндэсний хөтөлбөр". УБ.,1998
- Албан бус боловсролын сургалтын материал/Ёс ёмбогор/, УБ.,2006
- ЮНЕСКО "Сурч амьдаръя" төсөл. Байгалийн шимийг хүртэж сурцгаая. УБ.,2000
- ЮНЕСКО "Сурч амьдаръя" төсөл. Ой бидний амьдрал. УБ., 2000
- ЮНЕСКО "Сурч амьдаръя" төсөл. Мал эзнээсээ. УБ., 1999
- ЮНЕСКО "Сурч амьдаръя" төсөл. Ус ба хэрэглээ. УБ., 2001
- ЮНЕСКО "Говийн малчин эмэгтэйчүүд төсөл". Байгаль орчин. УБ.,1996

2.5. МАЛ, МАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН

Хүлээгдэж буй үр дүн

- Мал маллах арга ухаан, түүний ашиг шимийг үр өгөөжтэй хүртэх сэтгэлгээ, аргуудыг хэрэглэн холбогдох мэдээллийг боловсруулах чадвартай болж, мал болон малчин хүний өмнө тулгамдаж буй аливаа асуудалд идэвхтэй оролцож учир шалтгааныг үндэслэлтэй тайлбарлан үзэл бодлоо хамгаалах, зөвшилцөх чадвартай болно.
- Мал маллах, түүний ашиг шимийг хүртэх арга ухаанд суралцаж, тулгарч буй бодит асуудалд үндэслэлтэй хандах, зүй тогтлыг танин мэдэх, аливаа өөрчлөлтийн талаар таамаглал дэвшүүлж үндэслэлтэй хандах чадвартай болно.
- Шинжлэх ухааны ололт, загвар, бусдын туршлага, арга ухаан, технологийг ашиглан мал маллах арга ухаандаа бүтээлчээр хандах, хэрэгцээт мэдээллийг боловсруулж ашиглах чадвартай болно.
- Танин мэдэхүйн болон хөдөлмөрийн үнэ цэнийг ойлгох, хамтын ажиллагааны давуу талыг мэдрэх, өөрийгөө хөгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй болохоос гадна бусдад нөлөөлөх, танин мэдэх хандлага төлөвшсөн байна.

Дэд сэдэв	Агуулга		
	Мэдлэг	Чадвар	Хэрэглээ
Мал маллах арга ухаан	- Өвчтэй болон эрүүл малын ялгаа - Малын өвчний үед гарах зардлын тооцоо хийх - Мал оторлон таргалуулах арга - Боом, шүлхий өвчний шинж тэмдэг - Малын эмчилгээ - Төл бүрийг мал болгодог туршлага - Зуд, гантай үед олноор үхсэн малын сэг зэмийн хор хөнөөл, үр дагавар	- Малын шинж тэмдгийг эрхтэн тогтолцоогоор нь ангилж бичих - Бод, бог малын өвчний тухай материал уншиж ашиглах - Малд нэн тэргүүн хэрэглэгдэх эмийн нэрийг уншиж ашиглах - Дөрвөн улирлын мал маллагаанд анхаарах зүйлсийн ялгааг нэрлэх, тайлбарлах - Отор нүүдлийн ёс заншил, дэг горимын талаар эх зохиох - Отор нүүдэл хийхдээ байгаль орчноо хамгаалах талаар уламжилж ирсэн аргуудыг нэрлэх	- Малын хэвийн халуун, судасны цохилт, амьсгалын тоог малын төрөл бүрээр нь мэдэж хэрэглэх - Халууны шилийг хэрэглэх дарааллыг зааврын дагуу уншаад бичих - Бод малыг хоньчилж хариулахын ач тусыг бичих - Малын өвчин эмгэгийг таних чадвартай болох, бусадтай туршлага солилцох - Малын зүсийг нэрлэж бичих

		- Төл бүрийг мал болгох - Үхсэн малын сэг, зэмийг зайлуулах хялбар, эдийн засгийн хэмнэлтэй аргуудыг нэрлэх	- Төл бүрийг мал болгох арга туршлагатай болсон байх - Малын сэг, зэмийг зайлуулах арга, туршлагатай болсон байх
Малын хишиг буян	- Малын гаралтай бүтээгдэхүүний зах зээл - Малын гаралтай бүтээгдэхүүн-эрүүл хүнс - Малын тоног хэрэгсэл	- Зах зээл дэх малын түүхий эдийн ханшийн мэдээллийг ашиглан өрхийн тооцоо гаргах - Хүнд хэрэгтэй аминдэмүүдийг агуулсан малын эрхтэнг ялгах, хүүхэддээ тайлбарлах - Дайвар бүтээгдэхүүнийг хэрэглэх, түүний эрүүл мэнд, эдийн засгийн ач холбогдлыг тайлбарлах - Цагаан идээг байгалийн гаралтай бүтээгдэхүүнтэй хольж хүнс бэлтгэх - Мал аж ахуйн тоног хэрэгсэл, түүний ангиллыг нэрлэх	- Орон нутгийн зах зээл дэх малын гаралтай бүтээгдэхүүний үнэ ханш, түүний өсөлт бууралтыг тайлбарлах, уг мэдээллээ амьдралдаа ашиглах - Малын тоног төхөөрөмж хийдэг уламжлалт болон дэвшилтэт аргыг бусаддаа заах, туршлага солилцох (чөдөр, ногт, хазаар, эмээл г.м.) - Сүүгээр хийж болох бүтээгдэхүүнүүдийн талаар бичих - Аминдэм, эрдэс бодисын ач холбогдлыг тайлбарласан эх зохиох - Ясны сийрэгжих өвчинд малын гаралтай ямар бүтээгдэхүүн тустай байдгийг тайлбарлах, бичих

Үнэлгээ

Мэдлэг эзэмших ба ойлгох нь суралцагчийн өмнөх мэдлэгээс ихээхэн шалтгаалдаг үйл явц учраас сургалтын явцад багш байнга ажиглалт хийж, ахиц дэвшлийн талаар тэмдэглэл хөтлөх хэрэгтэй. Суралцагчийг үнэлэх олон хэлбэрээс (сорил, ярилцлага, асуулга, бүтээл, тэмдэглэл гэх мэт) сонгохоос гадна өөрийн үнэлгээг голлоно. Сургалтын өмнө түвшин тогтоох сорил болон бусад аргаар тэдний туршлага, мэдлэг, чадварыг илрүүлэх нь зүйтэй.

Хөтөлбөрийн дагуу сургалтыг зохион байгуулахдаа интеграцчилж суралцагчийн хандлага, үзэл хэрхэн өөрчлөгдөж буйгаар үнэлнэ.

Мөн кейс, жишээ тараан өгч тайлбарлуулан асуудал дэвшүүлсэн ярилцлага зохион байгуулж гарцыг хайж, амьдралаа дээшлүүлэх боломжуудыг хэрхэн судалсан байдлаар нь дүгнэх нь зөв. Жишээ нь:

1. Малчин М-ийн амьдардаг нутаг боом өвчний дэгдэлттэй боловч сүүлийн хоёр жил энэ өвчин гараагүй байна. Малын эмч Д түүний суурийн 75 үхэрт боом өвчнөөс сэргийлэх вакцин тарихаар ирсэн боловч малчин М-ийн эсэргүүцэлтэй тулгарснаар уг айлын үхрийг вакцинжуулалтанд хамруулж чадаагүй байна. Намар 9 дүгээр сард малчин М-ийн хотонд үхрийн боом өвчин гарч 14 үхэр үхсэн бөгөөд хэрвээ бүх үхэртээ вакцин тариулсан бол энэ хохирлоос урьдчилан сэргийлж чадах байсан юм. Учир нь боом өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинийг тарьснаас хойш 14 хоногийн дотор малд дархлаа тогтож бүтэн жилийн турш уг өвчнөөс найдвартай хамгаалдаг байна.

Даалгавар:

- Малын эмчийн үүргийг жагсаан бич

- Малчны үүргийг жагсаан бич
- Танай орон нутагт малын эмч, малчин хүмүүс нийгмийн өмнө хэрхэн үүргээ биелүүлдэг тухай жишээ авч тайлбарла

2. Хүн бруцеллёзоор өвдөхгүй байхын тулд юуг анхаарах вэ? Жагсаан бичнэ үү? гэх мэт...

Дээрх байдлаар кейс, жишээнд тулгуурласан даалгавар өгөх нь суралцагчдын мэдлэг чадварыг илрүүлэх ач холбогдолтой.

3. Малын өвчний төрлүүдийг жишээгээр тайлбарлах

Жишээ нь:

Дараах өвчнүүдийг ангилан бичнэ үү.

Боом, гуур, хувалз, бруцеллёз, дуут хавдар, шүлхий, хонины цэцэг өвчин, адууны савхан хорхой, галзуу, догол, хамуу,

Халдвартай	Халдваргүй

4.Өвчтэй малд хялбар сувилгаа хийх аргуудаас нэрлүүлж бичүүлэх

Жишээ нь:

Уралдааны замд бахардаж унасан моринд анхан шатны ямар тусламж үзүүлэх вэ? жагсаан бичнэ үү гэх мэт..

5.Бэлчээрийг цаг улиралд зохицуулан хэрхэн хуваарилж ашиглах

Жишээ нь:

Отор нүүдлийн нутгийг сонгохдоо харгалзан үзэх хүчин зүйлүүдийг /бод, бог малын бэлчээрийн ялгаа/ нэрлэж бичүүлэх.

Мөн ямааг хэт өсгөснөөс бэлчээрийн даацад нөлөөлж буй хүчин зүйлүүдийн талаар товч эх зохиолгож санааг илэрхийлүүлэх.

5.Малын өвчний үед гарах зардлыг тооцох (малын төрөл, өвчний шинж тэмдгийг сонгон авч зардлыг тооцох, жишээ татах)

Жишээ нь:

Үхэрт боом өвчин халдсанаас үүдэн:

-Эдийн засгийн болон сэтгэл зүйн ямар ямар дарамтанд орох жижиг тооцоолол гаргуулж түүнээс урьдчилан сэргийлэх арга замуудыг бичүүлэх гэх мэт.

7.50 эм хониноос жилийн турш авах ашиг шимийг тооцоолох

Үүний тулд нэг хониноос авах ашиг шимийг эхэлж тооцоолуулах. Жишээ нь:

1 эм хониноос авах ашиг шим. Үүнд, мах, сүү, ноос, төл малаас хүртэх ашиг шим, мөн хариулгад шаардагдах зардал гэх мэт.

8.Малын гаралтай хүнс бүхэн эрүүл хүнсэнд орох эсэх талаар тайлбарлах

Жишээ нь:

Сүүний эрүүл ахуйн шаардлагыг доош цувуулан бичүүлж шаардлага хангахад анхаарах зүйлийг ард нь харгалзуулан бичих.

9.Тоног хэрэгслийн хэрэглээ, бүтцийг тайлбарлан ярих

Жишээ нь:

Ноог хийх дараалал, бүтэц, материалын талаар тайлбарлуулах.

10.Малын гаралтай бүтээгдэхүүнээр аливаа өвчнийг анагаадаг уламжлалт аргуудаас нэрлэж бичих

Жишээ нь:

Тэмээний өөх бронхит өвчинд сайн бол, цус багадалтыг эмчлэхэд малын гаралтай ямар бүтээгдэхүүн ашигладаг талаар өөрсдийн мэдэх уламжлалт аргаас бичих гэх мэт

Арга зүй

Арга зүйн үндэс нь:

- мэдлэг бүтээх хэрэгцээ бий болгох,
- мэдлэг бүтээх үйл ажиллагааг хамтаар үзэх,
- харах,
- ярилцах,
- бичих,
- зурах,
- унших ба хийж бүтээх гэх мэт үйлийн харилцааг тусгаж насанд хүрэгчдийн сэтгэлгээ, амьдралын туршлага гэх мэт онцлог зүйлийг анхааран арга зүйгээ багш сонгох хэрэгтэй.

Энэхүү дэд хэсгийг судлахдаа СУРАЛЦАГЧ, БАГШ та бүхэн дараах зүйлийг анхаараарай. СУРАЛЦАГЧ:

1. Суралцагч та мал маллагааны уламжлалт арга ухаан болон өөрийн мал маллагааны арга, туршлагаас харьцуулан эргэцүүлэл хийгээрэй. Мал маллахуй болон малын хишиг буян хүртэх арга туршлага, өв уламжлалын талаар нөхдөөсөө туршлага судлахын хамт ХЭРЭГЛЭГДЭХҮҮН хэсэгт буй гарын авлагуудыг авч судлаарай. Эдгээр номыг судлах явцдаа та бичиг үсгийн мэдлэг чадвараа улам сайжруулах болно.
2. Хөтөлбөрийг судлах явцдаа холбогдох материалыг хаанаас олж, хэрхэн ашиглах талаар АББ-ын Гэгээрлийн төвийн багшаас зөвлөгөө авч болно.

БАГШ:

1. Сургалтын агуулгыг бие даан эзэмшүүлэх арга зүйн талаас нь багш анхаарна. Тухайлбал, шаардлагатай гарын авлагуудаар хангаж, тэдгээрийг хэрхэн ашиглах талаар зөвлөгөө өгөх, хэрэгцээтэй сургалтын материал, агуулгын эх сурвалжийг нь зааж өгөх зэргээр ажиллана.
2. Агуулгыг заахдаа амьдрал, хэрэглээтэй холбох, орон нутгийн онцлогийг харгалзах, үүнээс гадна үндэстэн, угсаатны ёс заншлаас шингээж өгвөл илүү ач холбогдолтой болно.
3. Иргэдийн хэрэгцээ шаардлага, ажил хөдөлмөрийн онцлог, суралцах чадвартай холбон сургалтын цагийг төлөвлөнө.

Хэрэглэгдэхүүн

- “Билгийн нүд-1”. АББЗСҮТ. УБ, 2008.
- “Билгийн нүд-2”. АББЗСҮТ, УБ, 2006.
- “Билгийн нүд-3”. АББЗСҮТ, УБ, 2008.
- Д.Баттогтох “Таван эрдэнийн тэгш сүрэг мину” УБ, 2009
- Д.Ганбаатар. “Эзэн сайтын мал эрүүл” УБ, 2005.
- “Мал аж ахуйн үндэс”. Сурах бичиг. УБ, 1988.
- Ж.Самбуу “Мал аж ахуй дээр яаж ажиллах тухай ардад өгөх
- сануулга, сургааль” /1946/,
- Ж.Самбуу “Малчдад өгөх зөвлөгөө” /1958/,
- Ж.Самбуу “Малчдын амьдрал, ахуй, хэв заншлаас” /1971/

3.1. ЭРҮҮЛ МЭНД

Хүлээгдэж буй үр дүн

- Өөрийн болон бусдын эрүүл орчинд амьдрах нөхцлийг хангах
- Өөрийн болон бусдын эрүүл мэндийг сахин хамгаалах

Дэд сэдэв	Агуулга		
	Мэдлэг	Чадвар	Хэрэглээ
	Бэлгийн амьдрал ба нөхөн үржихүйн эрүүл мэнд:		
	- Бэлгийн зан үйл ба үр дагавар - Гэр бүл төлөвлөлт - Үр тогтолт ба жирэмслэлт - Жирэмсэн үеийн хяналт, халамж асаргаа - Ургийн хөгжил, түүнд нөлөөлөх хүчин зүйлс - Үр хөндөлт ба үргүйдэлт - Жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслүүд - Аюулгүй бэлгийн харилцаа	- Жирэмслэх, үр удмаа үлдээхийн давуу талыг тайлбарлах - Жирэмсний болон төрсний дараах үед зөв хооллох, хувцаслах, дасгал хөдөлгөөн хийхийн ач холбогдлыг тайлбарлах - Жирэмсэн хүмүүст халамж үзүүлэх - Үр хөндөлтийн сөрөг үр дагаврыг тайлбарлах - Үргүйдэлд хүргэдэг шалтгаан, сэргийлэх арга замыг тайлбарлах - Жирэмснээс сэргийлэх арга хэрэгслийг зөв сонгож хэрэглэх	- Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд нь хүн болгоны асуудал гэдгийг хүлээн зөвшөөрдөг байх - Төрөлт болон жирэмслэлтийг төлөвлөхийг мэддэг байх - Жирэмсэн үед эмчийн хяналтад эрт орохыг дэмждэг байх - Аюулгүй бэлгийн харилцааг эрхэмлэдэг байх - Жирэмсэн үед анхаарах зүйлийг мэддэг байх - Хүсээгүй жирэмслэлтэд хүрэх алхамыг хийдэггүй байх - Бэлгийн амьдралтай холбоотой асуудлаар эмч, сэтгэл зүйчээс зөвлөгөө авдаг байх
	Халдварт ба халдварт бус өвчин:		
	- Халдварт ба халдварт бус өвчний тухай ерөнхий ойлголт - Халдварт өвчний үүсгэгч, дамжих зам - Халдварт ба халдварт бус өвчний шинж тэмдэг - Халдварт ба халдварт бус өвчнөөс сэргийлэх арга зам	- Халдварт ба халдварт бус өвчний ялгааг тайлбарлах - Халдварт ба халдварт бус өвчнөөс сэргийлэх арга замыг эзэмших - Өвчнөө эмчлүүлээгүйгээс гарч болох сөрөг үр дагавруудыг бусдад тайлбарлах - Өвчний үед эмчид хандах, эмийг зохистой хэрэглэх	- Халдварт ба халдварт бус өвчнөөс өөрийгөө болон бусдыг урьдчилан сэргийлдэг байх - Зарим халдварт өвчнөөс сэргийлэх вакцинжуулалтад хамрагддаг байх - Өвчин туссан нөхцөлд өвчнөө нуулгүй эмнэлэгт хандаж оношлуулдаг, эмчлүүлдэг байх - Дур мэдэн эмчилгээ хийдэггүй байх
	Хорт зуршил:		
	- Архи, согтууруулах ундаа, түүний хувь хүн, гэр бүл, нийгэмд үзүүлэх сөрөг үр дагавар - Тамхи, түүний хувь хүн, гэр бүл, нийгэмд үзүүлэх сөрөг үр дагавар - Дам тамхидалт, түүний үр дагавар	- Хорт зуршил хэрэглэхээс зайлсхийх арга замыг эзэмших - Архи, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын хор холбогдлыг тайлбарлах - Дам тамхидалтын хор нөлөөг тайлбарлах - Архи, тамхи хэрэглэснээс гарах	- Хорт зуршлын хэрэглээний талаар өөртөө болон бусдад шүүмжлэлтэй ханддаг байх - Хорт зуршлаас тууштай татгалздаг байх - Архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэх буруу зуршлаас гарахад нь бусдыг

	- Мансууруулах бодис, түүний хувь хүн, гэр бүл, нийгэмд үзүүлэх сөрөг үр дагавар - Хорт зуршил хэрэглэхээс зайлсхийх арга зам	хохирлын эдийн засгийн тооцоог хийх	уриалдаг, тусалдаг, үлгэрлэдэг байх - Мансууруулах бодистой холбоотой эрсдлээс өөрийгөө хамгаалдаг байх
	- Гэрийн гаднах орчны ариун цэвэр - Ахуйн хог хаягдал - Малын хашаа, хорооны цэвэрлэгээ - Моджуулалт, цэцэрлэгжүүлэлт - Хүүхдийн тоглоомын талбай - Бие засах газар	- Амьдарч буй газраа эрүүл орчинг бүрдүүлэх аргад суралцах - Ахуйн хог хаягдлыг ашиглах, хаях, устгах арга эзэмших - Малын хашаа, хороог цэвэрлэх арга барилд суралцах - Орчноо моджуулах, зүлэг ногоо, цэцэг тарих арга эзэмших - Хүүхдийгээ нас, хүйс онцлогт тохирсон тоглоомын талбайг байгуулах аргад суралцах - Амьдарч, нүүдэллэж буй орчиндоо зөв, боловсон бие засах газар байгуулах арга эзэмших	- Орчны ариун цэврийг сахиж, цэвэрлэгээ хийж байх - Хог хаягдлаа төрөлжүүлж хаях, ил задгай асгадаггүй байх - Малын хашаа, хороог тогтмол цэвэрлэх - Орчноо моджуулж, цэцэгжүүлэх - Амралт, тоглоомын тайлбай байгуулах - Амьдарч, нүүдэллэж буй орчиндоо зөв, боловсон бие засах газар байгуулж, ашиглах

Үнэлгээ

- Эмчийн заавар, зөвлөгөө болон бусад гарын авлага, материалыг унших
- Эмэгтэйчүүд хуанли хөтлөх
- Бусдад мэдсэн зүйлээ цэгцтэй ярьж өгөх
- Эрэгтэй, эмэгтэй бэлгэвчийн заавар унших
- Нийтлэг тохиолдох халдварт өвчнүүдийг нэрлэх, тэдгээрээс сэргийлэх аргыг тайлбарлах
- Өвчний талаарх мэдээллийг унших, бусдад ярих, тайлбарлах
- Хорт зуршилд автагдахаас зайлсхийх арга замыг бусдад тайлбарлах
- Архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэх буруу зуршлын талаар байгаа материалыг унших, бусдад ярих
- Дам тамхидалтыг жишээгээр тайлбарлах
- Архи, тамхинд зарцуулдаг мөнгөөр ямар хэрэгцээтэй хүнс, хувцас авч болохыг тооцох
- Орчны ариун цэвэр хүний эрүүл мэндэд эерэгээр болон сөргөөр нөлөөлдөг талаар жишээ татан ярих
- Хог хаягдалын асуудлыг тухайн айл өрх хэрхэн шийдвэрлэдэг талаар бичих
- Ахуйн ямар хог хаягдалыг юунд, яаж ашигладаг болон ашиглаж болох талаар ярих
- Амралт, тоглоомын талбайн зураглал хийх
- Нүүдлийн, цэвэрхэн, тохилог, хялбархан бие засах газар байгуулах зураглал хийх, тайлбарлан ярих
- Ярилцлага, кейс анализ, өөрийн үнэлгээ, дүрийн тоглолт, төсөлт ажил, эсээ бичлэг, тест зэрэг үнэлгээний аргуудыг хэрэглэж болно.
- Сургалтын үеэр багш оролцооны аргыг түлхүү ашиглаж, хичээлд татан оролцуулах, суралцагчид бие биенээ хүндэлж, бусдын яриа, сэтгэгдэл, саналыг хүндэтгэн сонсож, бусдын итгэл, хариуцлага хүлээж чаддаг болгох зэрэг үр дүнтэй аргуудаас сонгох хэрэгтэй. Үнэлэхдээ хандлагын өөрчлөлт, жишээ тайлбарлах чадвар, бусдын зовлон, өвчинг ойлгох чадвар зэрэг мэдлэгээс илүүтэй хэрэглээг голлосон үнэлгээг хийж, өөрөөр нь болон хамт олноор нь үнэлүүлэх зэргээр явцын үнэлгээг хийх хэрэгтэй.

- Суралцагч өөрийн эрүүл мэндийн талаар зөв ойлголттой болж, эрүүл орчин өөртөө бүрдүүлж, эрүүл хүнс хэрэглэн, эрүүл амьдрах хэвшилтэй болж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвдсөн нөхцөлд эмнэлгийн үйлчилгээг зөв хүртэж чаддаг болоход нь чиглүүлэх. Тухайн суралцагч сургалтын явцаас эхлэн өөрийн амьдралд сурсан зүйлээ өдөр тутам хэрэгжүүлж, эрүүл орчинд эрүүл амьдарч чадаж буй эсэхээр сургалтын үр дүнг тооцно.

Арга зүй

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд танхимын бус хэлбэр зонхилох тул танхимын буюу зайны сургалтын төрөл бүрийн хэлбэрүүдийг ашиглаж болохоос гадна суралцагчид бие даан судлах, гэр орны гишүүд, ойр дотныхонтойгоо хамтран ажиллах бүтээлч аргуудыг сонгож хэрэглэх нь зүйтэй. Сургалт эхлэхийн өмнө багш суралцагчийн эрүүл мэндийн талаарх мэдлэгийн түвшинг тогтоож, мэдээлэл авах хэрэгцээний судалгааг гаргасан байна. Эрүүл мэндийн сургалтыг бичиг үсгийн боловсрол олгох анхан, дунд, гүнзгийрүүлсэн шатны үед янз бүрийн хэлбэрээр давхар явуулж болно. Тухайлбал, уншиж сурч буй хүн тус бүрт шаардлагатай мэдээллийг нь текст хэлбэрээр уншуулах, түүнийг хуулж бичүүлэх, тухайн сэдвээр ярилцлага зохион байгуулж хэл яриаг хөгжүүлэх, тооцоолон бодох боломжтой сэдвүүд дээр тоо бодуулах. Жишээлбэл, өгөгдсөн эрүүл мэндийн сэдэвтэй текстийг зааврын дагуу унших, хурдан унших, утгат хэсгээр унших, гол түлхүүр үгийн доогуур зурах, хосоор унших г.м. аргуудыг хэрэглэж болох юм. Сургалтын явцад уншихаас гадна эхтэй ажиллах арга барилыг хөгжүүлэх нь маш чухал. Жишээлбэл, эхийг уншаад ахуйн нөхцөлд бохиоос үүсэх халдварт болон халдварт бус өвчний талаар тэмдэглэл хийж бичээрэй, халдварт өвчний үед илрэх шинж тэмдэгүүдийг жагсаан бичээрэй. Тухайн өвчний шинж тэмдэг илэрсэн үед та хэнд хандах вэ? г.м. цааш нь ажиллаж болно. Иймээс сургалт зохион байгуулахдаа сургалтын төрөл бүрийн идэвхтэй аргуудыг өргөн хэрэглэж суралцагчдын оролцоонд тулгуурлан явуулбал илүү үр дүнтэй болно. Жишээ, тохиолдлыг суралцагчдаар гаргуулан хамтран ярилцаж, гарц хайж, үр дүнд хүрсэн байдлаар зохион байгуулна. Эрүүл мэндийн сургалтыг бичиг үсгийн боловсрол олгох явцад зохион байгуулахдаа анги доторх нөхцөл байдлыг зөв тооцоолж, багш хэлэх үг, өгүүлбэр ээ бодож, бодлогогүй авсан жишээ хэн нэгэн суралцагчийг эвгүй байдалд оруулахгүй байх талаар нарийн тооцох нь зүйтэй. Эрүүл мэндийн сургалт явуулахад суралцагчдын дунд бие биенээ хүндэтгэх, итгэх дулаан уур амьсгалыг бүрдүүлэх нь чухал байдаг.

Хэрэглэгдэхүүн

- “Амьдрах ухааны сургалтын хөтөлбөр” УБ хот. 2008 он. АББЗСҮТ
- “Амьдрах ухаанд суурилсан эрүүл мэндийн боловсрол” (сургалтын хөтөлбөр, багшийн гарын авлагын хамт) УБ хот. 2007 он. АББЗСҮТ
- “Амьдрах ухааны цуврал ном”. УБ хот. 2003 он. АББЗСҮТ
- Д.Алтанцэцэг, Д.Алтанчимэг. “Бэлгийн боловсрол-1, 2”
- Д.Алтанцэцэг, Д.Алтанчимэг, Ч.Байгалмаа, О.Баяр “Хүний бэлгийн амьдрал” УБ хот. 2005 он
- Д.Алтанцэцэг, Д.Ганганоров. “Хорт зуршлаас холхон амьдаръя” АББ-ын гарын авлага 2, УБ. 2006 он
- Д.Алтанцэцэг, Ш.Оюунцэцэг нар “Эрүүл мэндийн боловсролын чанарыг сайжруулахад таны оролцоо”. УБ. 2005 он
- Ч.Байгалмаа, “БЗДХ, ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх нь”, АББ-ын гарын авлага 3. УБ хот. 2006 он
- Б.Баярмаа “Ухаалаг амьдрахын учир” УБ хот. 2003 он
- З.Тогтохмаа “Долоо хэмжиж нэг огтол” УБ хот. 2009 он
- С.Тунгалаг, Т.Хантулга “Зөв хооллолт” сургалтын модуль УБ хот. 2007 он.
- С.Ундрал “Уур биеийг...” УБ хот. 2006 он
- С.Ундрал “Зовох цагт...” УБ хот. 2009 он
- Т.Хантулга “Эрүүл хүнс эмнээс чухал” УБ хот. 2006 он
- Г.Цэрэнжигмэд, Д.Мөнхжаргал “Биеэ засаад гэрээ зас” гарын авлага. УБ хот. 2006 он

- Л.Эрдэнэбаяр “Архи амьдралын дэнс” УБ хот. 1999 он
- Д.Гүндэгмаа нар “Билгийн нүд 1” (2005 он), “Билгийн нүд 2” (2006 он), “Билгийн нүд 3” (2007 он) УБ хот.
- Б.Эрдэнэчимэг нар “Албан бус боловсролын эрүүл мэндийн сургалтын хөтөлбөр” УБ хот. 2009 он

3.2. АМЬДРАХ, АЖ ТӨРӨХ УХААН

Хүлээгдэж буй үр дүн

- Амьдрал ахуйгаа дээшлүүлэх, өрхийн орлогоо нэмэгдүүлэх төсөв, тооцоо гаргаж, уламжлалт болон орчин үеийн арга технологийн дагуу хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй болно.

Дэд сэдэв	Агуулга		
	Мэдлэг	Чадвар	Хэрэглээ
Амьдралын хэрэгцээ	• Өрхийн орлого, зарлагын тооцоо • Ахуйн цахилгаан хэрэгсэл • Аюулгүй ажиллагааны заавар • Замын хөдөлгөөний дүрэм • Талх, нарийн боов	• Өрхийн орлого, зарлагаа тооцоолох • Ахуйн хэрэгсэл, тоног төхөөрөмж (угаалгын машин, зурагт, антенн, хөргөгч гэх мэт)-ийн зааврыг унших, зааврын дагуу ашиглах • Ахуйн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн үнийг харьцуулан судлах, өрхийн орлого, зарлагад үндэслэн ахуйн хэрэгсэл худалдан авах боломж (хямдрал, урамшуулал, хөнгөлөлт, хуримтлал, зээл, лизинг гэх мэт)-ийг тооцох • Мэдээллийн технологийг ахуйд болон асуудал шийдвэрлэхэд ашиглах (электрон захидал илгээх, хүлээж авах, интернетээс мэдээлэл хайх, ашиглах) • Замын хөдөлгөөний дүрмийн анхан шатны мэдлэгтэй болох	• Өрхийн орлого, зарлагад үндэслэн хэрэглээндээ хяналт тавих, өдөр тутам хэрэглэдэг нөөц (гэрэл, дулаан, цахилгаан, илчлэг, температур гэх мэт)-д хэмнэлттэй хандах • Эд хөрөнгөө ариг гамтай зөв ашиглах, арчлах • Аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлах, бусдад сануулах • Ахуйн хэрэгсэл худалдаж авах тооцоо хийх зээл, лизингийг судлах, эргэн төлөх боломжоо тооцох • Бусдаас тусламж авах, зааж сургасныг нь бичиж тэмдэглэх • Телевиз, радио, сонин бусад мэдээллийн хэрэгслээс шинэ мэдээлэл олох, ашиглах, бусдад түгээх • Замын хөдөлгөөний дүрмийг баримтлах
	• Өрхийн үйлдвэрлэл, фермерийн аж ахуй • Хөршийн холбоо • Төсөл бичих арга • Орон нутгийн онцлогт тохирсон жижиг үйлдвэрлэл эрхлэх боломж	• Төсөл, түүний бүтэц, бүрэлдэхүүн хэсгүүдтэй танилцах, боловсруулах, ашиг, орлого, татварын хэмжээг тооцох • Бүтээгдэхүүний ур хийц, өнгө, үзэмжийг улам боловсронгуй болгох, уламжлалт болон орчин үеийн технологи бүхий аргаас суралцах • Монголын уламжлалт хөдөлмөртэй холбоотой зүйр цэцэн үг, үлгэр, уран зохиол унших, хэрэглэх • Багаар ажиллах, хариуцлага хүлээх, мэдээлэл солилцох	• Шинэ технологи, техник хэрэгслийг амьдрал ахуйдаа нэвтрүүлэх, энэ талаар мэдээлэл авах хүсэл эрмэлзлэлтэй болох • Өрхийн болон орон нутгийн онцлогтой жижиг үйлдвэрлэл эрхлэх бизнес төсөл, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлж эхлэх • Ашгийн татвар төлөх, нийгмийн баялагт хувь нэмэр оруулах
Эсгий	• Эсгий, түүний төрөл • Эсгий, эсгий эдлэл хийх дараалал	• Ноосны төрөл, онцлог шинж чанарыг харьцуулах, ангилан ялгах • Эсгий, эсгий эдлэл хийх уламжлалт ба орчин үеийн	• Ширдэг, эсгий наадгай, гоёл зэрэг бүтээгдэхүүнээс сонгон хийх • Бүтээгдэхүүний ур хийц, өнгө, үзэмжийг улам боловсронгуй болгох

			аргын талаар унших, хэрэгцээт мэдээллээ бичиж тэмдэглэх, хийж турших - Тодорхой бүтээгдэхүүнийг хийхэд шаардлагатай түүхий эдийн орц хэмжээг уншиж ойлгох, тооцох, борлуулах, өртгийг тооцоолох - Уламжлалт ажил хөдөлмөр, урлалтай холбоотой ерөөл, магтаал, зүйр цэцэн үг, ардын аман зохиолыг олж унших, цээжлэх, хэрэглэх	- Хүнд хийж буй зүйлд нь тохирсон билэг дэмбэрэл, ерөөлийн үг хэлэх, хүүхдэд цээжлүүлэх - Гэр бүлийн хэрэгцээнд хийж бүтээсэн зүйлээ бусаддаа сурталчлах, туршлага солилцох
	Зүймэл эдлэл	Зүймэл эдлэл хийх дараалал	- Зүймэл эдлэл хийх эдийг сонгоход анхаарах зүйлийг баримтлах - Зүймэл эдлэлийг эсгэх, хээ зураг гаргах, оёх дарааллыг анхааралтай унших, товчлон бичиж тэмдэглэх	- Тодорхой загвар сонгон хэрэгцээт зүймэл эдлэл (ширээний бүтээлэг, дэрний уут, орны аравч, цүнх г.м) хийх - Бүтээгдэхүүний ур хийц, өнгө, үзэмжийг улам боловсронгуй болгох - Гэр бүлийн хэрэгцээнд хийж бүтээсэн зүйлээ бусаддаа сурталчлах, туршлага солилцох
	Хүнсний ногоо, жимс	- Хүнсний ногоо, жимс жимсгэний тариалалт, хадгалалт - Хүнсний ногоо, жимс жимсгэнийг боловсруулах арга	- Хүнсний ногоо, жимс жимсгэний бут тариалах, арчлах, услах, хураах, хадгалах тухай мэдээлэл цуглуулан, хэрэгцээт хэсгийг тэмдэглэж бичих - Бүтээгдэхүүн хийх, ногоо, жимсний бут тарих багаж хэрэгслийг зөв ашиглах	- Хэрэгцээт хүнсний ногоо, жимс жимсгэнээс сонгон тариалж, ахуй амьдралдаа хэрэглэх - Гэр бүлийн хэрэгцээнд хийж бүтээсэн зүйлээ бусаддаа сурталчлах, туршлага солилцох
	Үндэсний хувцас	Үндэсний хувцас, эдлэл, хийх аргачлал	- Сурч буй зүйлийг гүйцэтгэх дараалал, орц хэмжээг уншиж ойлгох, бичиж тэмдэглэх - Орц хэмжээг, зардлыг тооцоолох, тайлбарлах - Үндэсний хувцас, эдлэл хийх - Бүтээгдэхүүний ур хийц, өнгө, үзэмжийг улам боловсронгуй болгох, уламжлалт болон орчин үеийн технологи бүхий аргаас суралцах	- Уламжлалт хувцас хийж хэрэглэх, тэдгээрийн эрүүл мэндийн болон ахуйн ач холбогдлыг ойлгох, бахархах - Гэр бүлийн хэрэгцээний эдлэл, хүнс үйлдвэрлэх, орон нутгийнхандаа сурталчлах, захиалга авч, үйлчлэх, үйлчилгээний хөлсийг тооцох

Үнэлгээ

Сургалтын явцад суралцагчдын чадвар эзэмшилтийн байдлыг ажиглаж, тэмдэглэл хөтлөх тухай дунд шатны сургалтын “Амьдрах, аж төрөх ухаан” үнэлгээний хэсгээс харна уу.

Гүнзгий шатны сургалтын явцад үнэлгээ хийхдээ багш суралцагчдын үйл хийх явцыг хянах, суралцагч, гэр бүлийн гишүүд, бусад хүмүүсийг үнэлгээний ажилд татан оролцуулж:

- ажиглалт хийх
- тэмдэглэл хөтлөх
- суралцагчидтай ярилцах
- гэр бүлийн гишүүдтэй ярилцах
- суралцагчдын бүтээлийн сан бий болгох
- суралцагчдын сонгосон чиглэлээр өрхийн үйлдвэрлэл эрхлэх бизнес тооцоог гаргах

- ахуйн хэрэгслийг зааврыг унших, тайлбарлах
- өгсөн нөхцөлийн дагуу тооцоо хийх
- суралцагчдын өдөр тутмын амьдралд гарч байгаа өөрчлөлт, ахицыг ажиглалтын аргаар дүгнэж үнэлгээ өгөх зэрэг хэлбэрийг ашиглаж болно.

Суралцагчдын эзэмшсэн чадварыг илрүүлэх гол хэрэгсэл нь тэдний бүтээл, түүнээ хийхэд ашигласан арга техник болно.

Арга зүй, хэрэглэгдэхүүн

Сургалтыг тухайн сумын АББ-ын багш хариуцан зохион байгуулах бөгөөд тодорхой мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн мэргэжлийн хүмүүс, амьдрах, аж төрөх ухаанаар амьдралын туршлагатай иргэд, ЕБС-ийн багштай хамтарч болно.

Сургалтад:

- Танхимын болон танхимын бус сургалтын арга, хэлбэрүүдийг ашиглах
- Танхимын бус сургалтын үед бие даан ажиллах үйлийг гүйцэтгүүлэх
- Өгөгдсөн сэдвүүдтэй холбоотой жишээ, баримт танилцуулах
- Насанд хүрэгчдийн амьдралын туршлага, үгийн нөөцийг аль болох сайн ашиглаж, өдөр тутмын амьдрал, зан үйлтэй нь холбох арга хэрэглэх
- Ялангуяа амьдрах ухаантай холбоотой мэдлэг нь суралцагчдын бодит амьдралтай хэрхэн уялдаж байгаа талаар тэднээр яриулах, эх бичүүлэх
- Суралцагчдын бодол санааг сонсох, оролцоог дэмжих (сэдэл үүсгэх)
- Эрэн хайх, цуглуулах (судалгааны арга)
- Суралцагчаар дамжуулан гэр бүлийн бусад гишүүд, иргэдэд сурсан мэдлэгээ хуваалцах, түгээх
- Хамтран ажиллаж, туршлага солилцох
- Оновчтой үйлийг төлөвлөх, хэрэгжүүлэх
- Тухайн сэдэв, агуулгатай холбоотой орон нутгийн ардын зан үйл, уламжлалаас сургалтадаа шигтгэж, хэрэглэх

зэрэг үйл ажиллагаануудыг төлөвлөн хийх нь үр дүнд хүргэнэ.

Аль сэдвийг сонгон суралцах талаар суралцагчидтай хамтран ярилцсаны дараа тэдний мэдлэг, боловсролын түвшин, нас, хэрэгцээ шаардлагаас хамааран тухайн судлах цагийг төлөвлөж болно. Багш сургалтад шаардлагатай материал, түүхий эд, ажиллах зааварчилгаа, аюулгүй ажиллагааны дүрмийн талаар санамжийг урьдчилан бэлтгэнэ.

Суралцагчдын сонгосон сэдвээс хамаарч судлах ном, гарын авлага, зааварчилгааг судлах эх үүсвэрийг орон нутгийнхаа нөөц боломжийг тооцон багш зааж, зөвлөгөө өгнө.

Бичиг үсгийн гүнзгий шатны сургалтын явцад “Амьдрах, аж төрөх ухаан” сэдвийг судлах хөтөлбөрийг боловсруулахад багш танд баримжаа болгох үүднээс дэд сэдвийг судлах цаг, ашиглах материал, хэрэгжүүлж болох үйл ажиллагааны нэгэн хувилбарыг орууллаа. Үүнийг багш заавал мөрдөх албагүй, харин өөрийн туршлага, ур чадвар, суралцагчдын сурах чадварыг харгалзан бүлэг сэдэв, судлах цагаа зохицуулах боломж нээлттэй.

Сэдэв	Цаг		Хэрэгжүүлж болох үйл ажиллагаа	Үнэлгээ
	Ц	БД		
Гүнзгий шат (Цугларалтаар 10-12, бие даан судлах 10-12 цаг)				
Дараах дэд сэдвүүдээс 2-оос багагүйг сонгон судална.				
Ахуйн тооцоо, хэрэглээ	4	4	• Өрхийн орлого, зарлага сэдвийн хүрээнд “Амьдралын хэрэгцээ” (2006) гарын авлагын I бүлэг (хуудас 5-18), Билгийн нүд 2 (2006)-ын I бүлэг (хуудас 20-24, 30-31), Билгийн нүд 3 (2007)-ын Y бүлэг (хуудас109-116)-ээс багш, суралцагч хамтран агуулгыг сонгон судлах	• Суралцагчдын техник хэрэгслийн ашиглалт, чадвар эзэмшилтийн байдлыг илрүүлэх даалгавар ажиллуулж, явцад нь багш ажиглаж тэмдэглэл хөтөлнө.

			- Мэдээллийн технологи (гар утас, цахим шуудан бичих)-ийн чиглэлээр Билгийн нүд 3 (2007)-ын YII бүлэг (156-168 дугаар хуудас)-ийг судлах - Талх, нарийн боов хийх (2010) гарын авлага - Бусад сэдвийн хувьд багш, суралцагч бие даан судлах материалаа олж судалж, мэдээллээ солилцон ярилцах	
Эсгий эдлэл	6	6	Ноосоор урлахуй (2007), Ноос-цагаан алт (2007), Ноосон утас (2010) гарын авлага, сургалтын видео (Ноосоор урлахуй, Ажил хийвэл ам тосдоно-2010), Хонины ноос боловсруулах, бүтээгдэхүүн хийх (2010) радио хичээл	Суралцагч гэрийн нөхцөлд өрхийн хэрэгцээндээ гар аргаар ноос, ноосон бүтээгдэхүүн хийх
Зүймэл эдлэл	6	6	Зүймэл эдлэл (2007), Арьсны өөдөс амилуулах ухаан (2010), Үйл бүтэг (2010), Ширдэг олбог, тохом, тохош хийх аргачлал (2010)	Суралцагч гэрийн нөхцөлд өрхийн хэрэгцээндээ гар аргаар бүтээгдэхүүн хийх
Хүнсний ногоо, жимс, жимсгэнэ	6	6	Жимс, жимсний мод тариалах сургалтын видео (2010), Хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалах, хураах, хадгалах гарын авлага (2010), Хүнсний ногоо даршлах аргачлал видео (2010), Байцааны кимчи хийх видео (2010),	Суралцагч өрхийн хэрэгцээндээ тохирсон газар тариалан эрхлэх, гэрийн нөхцөлд хүнсний ногоо, жимс жимсгэнэ хадгалах, даршлах
Үндэсний хувцас	6	6	Үндэсний хувцас видео (2010), Монгол дээл оёх арга видео (2010), Монгол үндэсний хувцас (2010) гарын авлага	Суралцагч өрхийн хэрэгцээндээ гар аргаар дээл хувцас хийх
Өрхийн үйлдвэрлэл	6	6	Жижиг бизнес эрхэлцгээе (2010), Төсөл бичих аргачлал (2010) гарын авлага, Тахиа шувуу ашигтай даа () гарын авлага, видео	Суралцагчид сонгосон чиглэлээрээ өрхийн үйлдвэрлэл эрхлэх төсөл бичих

Сургалтын явцад сэдэвтэй холбоотой агуулга бүхий бусад гарын авлага, ном, аудио, видео материалыг ашиглаж болно.

Гүнзгий шатны сургалтад суралцагчдаар өгсөн загвар, заавраар ажиллах, бие даан ажиллах, бүтээлээ тайлбарлах, бусдын туршлагаас суралцах, санаа бодлоо илэрхийлэх зэрэг үйлийг хийлгэх нь ач холбогдолтой.

3.3. ИРГЭНИЙ УХАМСАР

Хүлээгдэж буй үр дүн

- Эрх эдэлж, үүргээ биелүүлдэг, гэр бүлээ хайрлан хамгаалдаг хувь хүн төлөвшинө.
- Эдлэх, эрх, хүлээх үүргийг хуулийн болон ёс зүйн хэмжээнд даган мөрдөх чадвартай болно.
- Эрх, үүргээ амьдралдаа хэрэгжүүлэх чадвар бүхий иргэн төлөвшинө.
- Нийгмийн амьдралд идэвхтэй байр сууринаас ханддаг, эх оронч иргэн хүн төлөвшинө.

Дэд сэдэв	Агуулга		
	Мэдлэг	Чадвар	Хэрэглээ
Гүнзгий шатны сургалт			

Хувь хүний ухамсар	- Амьд явах, эрүүл мэндээ хамгаалуулах, сурч боловсрох зэрэг хүний үндсэн эрх - Эрхээ эдлэх нь - Хөдөлмөрлөх, байгаль орчноо хамгаалах, хууль дээдлэх, сахих, хуулиар ногдуулсан албан татвар төлөх зэрэг үүрэг - Үүргээ биелүүлэх нь	- Амьд явах, эрүүл мэндээ хамгаалуулах, сурч боловсрох зэрэг үндсэн эрхээ эдлэх ёстойг ухамсарлах - Хөдөлмөрлөх, байгаль орчноо хамгаалах, хууль дээдлэх, сахих, хуулиар ногдуулсан албан татвар төлөх зэрэг үүргээ биелүүлэх - Эрхээ зөв эдэлж, бусдын эрх, эрх чөлөөг хүндэтгэх	- Хуулиар заасан эдлэх эрхээ жагсаан бичих, эрхээ бүрэн эдэлдэг талаар эргэцүүлэн бодох - Бусдын эрхийг зөрчихгүйгээр эрхээ эдлэх талаар санаа бодлоо эмх цэгцтэй илэрхийлэх - Эрх нь зөрчигдсөн тохиолдолд хамгаалуулах талаар холбогдох газарт гаргах өргөдөл бичих, холбогдох хууль, тогтоомжийг уншиж, хэрэгцээтэйг нь тэмдэглэх - Хуулиар хүлээдэг үүргээ жагсаан бичих, тэдгээрийг хэрхэн хэрэгжүүлдэг чаддаг эсэхээ эргэцүүлэх - Хүлээсэн үүргээ биелүүлдэг болон биелүүлдэггүй хүний ялгааг тодорхойлон бичих - Үүргээ нэр төртэйгээр биелүүлэх талаар хүүхэд, залууст хандсан ухуулга сурталчилгаа бичих - Үүргээ биелүүлдэггүй хүнд ногдуулах торгууль, шийтгэлийн талаар мэдээлэл цуглуулж, бичиж эмхэтгэх
Гэр бүлийн ухамсар	- Гэр бүлийн гишүүдийн үлгэр дуурайлал - Гэр бүлийн хүчирхийлэл	- Гэр бүлийнхэндээ найрсаг, дотно хандах - Гэр бүлдээ итгэлтэй уур амьсгал бүрдүүлэх - Үр хүүхэддээ үлгэрлэн дуурайх хүн нь байх - Эрхээ зөв эдэлж, үүргээ биелүүлэх ёстойг гэр бүлийн гишүүдэд тайлбарлах, ойлгуулах - Гэр бүлийн орчинд бие биенээ хүчирхийлэхгүй байх	- Гэр бүлийн гишүүддээ найрсаг дотно хандаж, тэдний итгэлийг хэрхэн хүлээх тухай сэтгэл зүйн зөвлөгөө заавар унших, тэмдэглэх - Үр хүүхэд, гэр бүлдээ сайнаар нөлөөлөхийн тулд дутагдлаа засах зөвлөгөө, зааврыг интернет болон бусад эх сурвалжаас олж унших - Гэр бүлийн гишүүн бүрт гүйцэтгэх үүргийг нь тайлбарлах, ойлгуулах - Үүргээ биелүүлэхэд нь туслах зорилгоор сургамжтай зохиол, өгүүллийг цуглуулж уншуулах, ярьж өгөх - Гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдээллийг судалж найз нөхөд, хамаатан садан, хөршдөө ухуулан ярих - Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй хүмүүсийг хэрхэн хамгаалах талаар сэтгэл зүйн зөвлөгөөг цуглуулах, судлах - Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүний эрхийг

			хамгаалах талаар холбогдох байгууллагад гаргах өргөдөл бичих, холбогдох хууль, тогтоомжийг судлах - Хүчирхийлэлд өртсөн гэр бүлийн гишүүнд сэтгэл санааны тусламж үзүүлэн энгийн зөвлөгөөг унших, тэмдэглэх
Нийгмийн ухамсар	- Нийгмийн амьдрал дахь хувь хүний оролцоо - Эх орноо хайрлан дээдлэх ёс	- Нийгмийн амьдралд идэвхтэй байр сууринаас хандах - Орон нутгийн нутгийн удирдлагын үйл ажиллагааг дүгнэх - Орон нутгийн хөгжил нь иргэдийн оролцооноос хамаарахыг ухаарах - Орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах ёстойг ойлгох - Орон нутгийн хөгжлийн чиг хандлагын талаар эргэцүүлэх - Эх орноо хайрлах, хамгаалах - Эх оронч үзлийн талаар ойлгох	- Орон нутгийн асуудлыг шийдвэрлэхэд иргэдийн оролцоог тодорхойлсон журам зааврыг олж унших - Орон нутгийн удирдлагад хүргүүлэх хөгжлийн талаарх санал бодлоо бичих - Орон нутгийн хөгжилд иргэдийн оруулах хувь нэмрийн талаар санал бодлоо хурал, цуглаан дээр илэрхийлэх - Орон нутгийн удирдлагын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгсөн мэдээлэл бэлтгэх - Ахмад настан, хүүхэд, залуус, эмэгтэйчүүд зэрэг нийгмийн бүлэгт туслах санал санаачлага бүхий уриалга бичих - Тэднийг нийгмийн амьдралд татан оролцуулах чиглэлээр ямар ажил явуулж болох талаар орон нутгийн удирдлагад хүргүүлэх саналаа бичих - Хойч үеэ эх оронч үзлээр хүмүүжүүлэхийн ач холбогдлыг түүхийн үүднээс тайлбарлаж ойлгуулах - Үе үеийн эх орончдын баатарлаг үйлсийг уншиж тэмдэглэн, хүүхэд багачуудад сургамж болгон ярих - Эх орноо хайрлан хамгаалахад иргэн бүр хэрхэн оролцох ёстой тухай эсээ бичих

Үнэлгээ

- Хүний эрхийн модыг бүтээх (Модны мөчир болгонд хүний эрхийг бичих)
- Хүний эдлэх эрх, хүлээх үүргийн талаар уншиж мэдсэн эсэх
- Эрхээ эдлэх, үүргээ биелүүлэхийн мөн чанарын талаар бодол саналаа бичсэн эсэх
- Бүтээлийн дэвтэртээ гэр бүлийн гишүүдэд сайнаар нөлөөлж чадсан эсэх талаар тэмдэглэл хөтөлсөн байх
- Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн гишүүдэд ямар дэмжлэг, туслалцаа үзүүлж болох талаар мэдээлэл цуглуулж, тайлбарлах
- Нийгмийн амьдралд хувь хүний зүгээс оролцох боломжийг дэвтэртээ тодорхойлон бичих

- Бусдад нийгмийн амьдралд идэвхтэй оролцохыг уриалсан ухуулга бичих, хүүхэд, залууст үлгэр дуурайлал үзүүлэх чиглэлээр үе тэнгийнхээ хүмүүстэй хамтран ярилцлага зохион байгуулсан эсэх
- Эх орноо хайрлан дээдлэх талаар сургамжит эсээ бичсэн эсэх
- Эх орноо хамгаалж явсан эрэлхэг баатруудын талаар мэдээлэл цуглуулж, бяцхан ном хийсэн эсэх

Арга зүй

СУРАЛЦАГЧ та дараах зүйлийг анхаараарай:



1. Хууль, дүрэм, журам, өргөдөл зэрэг албан баримтын үг, найруулгыг анзаарч тэмдэглэж аваарай. Ингэхдээ бусад ном, гарын авлагын үг, найруулгаас ямар ялгаатай байна гэх мэтчилэнгээр бүтээлчээр хандах нь чухал. Түүнчлэн дээр дурдсан албан баримтуудыг гаргадаг эрх бүхий байгууллагыг олж тэмдэглэн авах нь таны мэдлэгийн санг арвижуулна. Жишээ нь, хуулийг Улсын Их Хурал баталж гаргадаг гэх мэт.
2. “Хэрэглээ” гэсэн баганад дурдсан зүйлийг хэрэглэдэг болохын тулд уншиж судлах, уншсанаа эргэцүүлэн бодох, бодсоноо тэмдэглэх, тэмдэглэснээ бусдад тайлбарлах зэргээр ажиллаарай. Ингэх нь таны өөрт хэрэгцээтэй зүйлийг эрж олох, ангилан ялгах, хэрэгцээтэйг тэмдэглэн авах, өөрийгөө илэрхийлэх, бусдад туслах зэргээр таны бичиг үсгийн болон хувь хүний чадварууд хөгжих болно.
3. Харьяалагдах баг, сумын удирдлагадаа өргөдөл гаргах, тусламж хүсэх, орон нутгаа хөгжүүлэх санал хүргүүлэх зэргээр албан бичгийн соёлд суралцаарай. Эдгээрийг хэрхэн бичих зөвлөгөө зааврыг та багш болон бусад хүмүүсээс асууж, тэмдэглэж аваарай.
4. Гүнзгийрүүлэн суралцахыг хүсвэл сум, орон нутагт буй бүхий л хүнээс тусламж авч болно. Жишээ нь, ахмад буурал, ухаантай ажилсаг, олны хүндлэл хүлээсэн хүмүүс, багш, бусад мэргэжлийн хүмүүсээс та асууж сурч болно. Учир таны эргэн тойрны болон өдөр тутмын амьдралаас урган гардаг асуудлуудыг энэхүү хэсэгт авч үзсэн болно.
5. АББ-ын Гэгээрлийн төв гэх мэт байгууллагатай хамтран сум орноо цэвэрлэх, тохижуулах, зүлэг, мод тарих зэрэг бүх нийтийн чанартай компанит ажлыг явуулаарай. Ингэхдээ компанит ажлын зорилго, төлөвлөгөө, хөтөлбөрийг хамтран боловсруулах гэх мэтээр бичиг үсгийн мэдлэг, чадвараа дээшлүүлэхэд анхаарахаа мартуузай.
6. Хөтөлбөрийн “Иргэний ухамсар” хэсгийг судалж дуусаад суралцагч та доорх сорилоор өөрийгөө үнэлээрэй.

№	Асуулт	Сайн (2 оноо)	Дунд зэрэг (1 оноо)	Тааруу (0 оноо)
1	Би олон нийтийн газар, гудамж талбайд биеэ хэрхэн зөв авч явах талаар мэдээлэл цуглуулж, түүнийгээ уншин бусаддаа ярьж чадна			
2	Иргэн хүний эдлэх үндсэн эрх, хүлээх үндсэн ба журамт үүргийг уншиж цээжлэн, бусдад ухуулан ярьж чадна			
3	Миний болон ойр дотны хүмүүсийн эрх зөрчигдсөн үед шийдвэрлүүлэх талаар өргөдөл бичиж, холбогдох газарт нь хандаж чадна			

4	Гэр бүлийн гишүүдийн өмнө хүлээсэн үүрэг, түүнийгээ хэрхэн биелүүлж байгаа талаар дүгнэн бичиж чадна			
5	Гэр бүлийн гишүүддээ үлгэр дууриалал үзүүлэх талаар холбогдох мэдээ материал цуглуулах, ангилан ялгах, судлах замаар бяцхан гарын авлага эмхэтгэн гаргаж чадна			
6	Орон нутгийн байгууллагатай хамтран ажиллах талаар мэдээлэл цуглуулан уншиж судлан, бусдад ухуулж чадна			
7	Нийтийг хамарсан аливаа ажилд сайн дураар оролцох үүргээ биелүүлэх талаар хүүхэд, залууст хандсан уриалга бичиж чадна			
8	Нийгмийн амьдралд идэвхтэй оролцохын ач холбогдлын талаар мэдээлэл цуглуулан, түүнийгээ үр хүүхэд, гэр бүлийн гишүүддээ ярьж чадна			
9	Иргэн хүний орон нутгийн хөгжилд оруулж болох хувь нэмрийн талаар саналаа боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлж чадна			
10	Иргэн хүний хувьд нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх тал дээр санаачлагатай ажиллах талаар хүүхэд, залуус, хойч үедээ хандсан сургамжит эссэ бичиж чадна			

15-20 оноо – зорилгоо сайн биелүүлсэн, багшаараа баталгаажуулах үнэлгээ хийлгэхэд бэлэн

9-14 оноо – зорилгоо дунд зэрэг биелүүлсэн, зарим зүйлийг дахин үзэх хэрэгтэй

8–аас доош оноо – дахин ажиллах шаардлагатай

7. Эцэст нь та энэ хэсгийг судалснаар өөрт ямар өөрчлөлт гарсан, ямар ач холбогдолтой болсныг бодож эргэцүүлээд бичиж тэмдэглэн Гэгээрлийн төвд хандивлаарай. Таны бүтээлийг өөр бусад хүн үзээд хөтөлбөрийг сонирхон судлах хүсэл төрж, тань шиг өөрчлөгдөхийг хичээх болно.

Суралцагчдыг чиглүүлэх БАГШ та дараах зүйлийг анхаараарай:

1. Сургалтын агуулгыг бие даан эзэмшүүлэх талаас нь багш анхаарч, явцад нь хяналт тавьж ажиллана. Жишээ нь, холбогдох хууль тогтоомжоос өөрт хэрэгцээтэй хэсгийг олж унших, тэмдэглэгээ хийх, сэдвүүдийн чиглэлээр эргэцүүлэмж гаргах, санал хүсэлтээ илэрхийлэх зэргээр бие даан суралцах боломжийг хангана.

2. Иргэний ухамсрыг дээшлүүлэхэд чиглэсэн практик ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Тухайлбал, түймэр, бүх нийтийн цэвэрлэгээ зэрэг олон нийтийн шинж чанартай асуудалд сайн дураараа идэвхийлэн оролцох ухамсрыг дээшлүүлэхэд чиглэсэн компани ажлуудыг өрнүүлнэ. Ингэхдээ суралцагчдын бичиг үсгийн чадварыг дээшлүүлэх үүднээс уг ажлын зорилго, хөтөлбөр төлөвлөгөө гаргах, санал санаачлагыг бусдад түгээх зэрэг ажлыг тэднээр гүйцэтгүүлэх хэрэгтэй. Дашрамд дурьдахад, орон нутгийн иргэдийг хэрхэн дайчлах, зохион байгуулах талаар мэдлэгээ дээшлүүлээрэй.



3. Сургалтанд ашиглах материалыг олон чиглэлээр бэлтгэнэ. Тухайлбал, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, гарын авлага, сурталчилгааны материал зэрэг байна.

4. Суралцагчийн өөрийн үнэлгээтэй танилцан, баталгаажуулах үнэлгээ хийнэ. Бодит баримт, тест, ярилцлага, ажиглалтын аргуудыг хослуулан үнэлгээ хийх нь зохимжтой.

Хэрэглэгдэхүүн

- Үндсэн хууль, УБ., 1992
- Боловсролын тухай Монгол улсын хууль, УБ., 2003
- Хөтөлбөрийн агуулгатай холбогдох бодлого, хөтөлбөрүүд (Хүүхдийн талаар төрөөс баримтлах бодлого гэх мэт)
- Холбогдох хууль тогтоомж, дүрэм журам
- Бусад гарын авлага
- Сурталчилгааны хялбаршуулсан материал
- Сургалтын агуулга тус бүрт шаардагдах тусгай хэрэглэгдэхүүн (цаас, үзэг гэх мэт)

3.4. БАЙГАЛЬ ОРЧИН

Хүлээгдэж буй үр дүн

- Бүх насны хүн амын экологийн боловсролыг дээшлүүлнэ
- Цэвэр орчинд ая тухтай аж төрөхөд туслана
- Байгаль орчноо хадгалан хамгаалах үзэл бодол, мэдлэг төлөвшүүлнэ
- Байгальтай хэрхэн харьцах, байгалийн нөөцийг хэрхэн ашиглах талаар мэдлэгтэй болно

Дэд сэдэв	Агуулга		
	Мэдлэг	Чадвар	Хэрэглээ
Байгаль орчин ба хүний үйл ажиллагаа	- Байгалийн үзэгдэл - Цаг агаар - Байгалийн гамшиг (үер, ган, зуд, гал түймэр, газар хөдлөлт) - Байгальтай харьцах, байгалийн нөөцийн ашиглалт - Ургамал, амьтны төрөл зүйл	- Бороо, цас гэх мэт байгалийн үзэгдлийг танин мэдэх - Байгаль шинжиж цаг агаарыг урьдчилан тааварлах чадвартай болох - Байгалийн гамшигт ордог үзэгдлийн талаар мэдэх - Гамшгийн үед өөрийгөө болон бусдыг хамгаалах талаар мэдэх - Байгальтай зөв харьцах, байгалийн нөөцийг зөв зохистой хэрэглэх ёстойг ухамсарлах - Орон нутагт ургадаг ургамал, амьдардаг ан амьтны тухай мэдэх, хайрлан хамгаалах ёстойг ухамсарлах	- Байгалийн үзэгдэлд тохируулан хувцаслах, хооллох, ажил хөдөлмөрөө зохицуулах - Байгаль шинжиж цаг агаарыг тааварлан ажил хөдөлмөрөө зохицуулах - Жнь, тэнгэр муухайрахыг жаргаж буй нарны хэлбэр, мал амьтдын ааш, хөдөлгөөнөөр тааварлаж шинжих - Гамшгийн үед өөрийгөө болон бусдыг хамгаалах заавар, аргачлалыг бичих, бусдад таниулан ярих - Жимс жисмгэнэ гэх мэт байгалийн баялгийг зөв түүх, ашиглах талаар хүүхэд, залууст ухуулан сурталчлах - Байгалийн баялаг ашиглаж өрхийн орлого бүрдүүлэх аргыг судлах, тэмдэглэх - Ургамал, ан амьтныг хайрлах, хүн төрөлхтний амьдралын нэг хэсэг болох талаар хүүхэд, залууст ухуулан ярих,

			энэ талаар жишээ баримт цуглуулан бүтээлийн дэвтрээ баяжуулах
	• Тогтвортой хөгжлийн боловсрол • Өнгөрсөн болон өнөөдөр гаргаж буй шийдвэрүүд нь ирээдүй үеийнхэнд нөлөөлөх нөлөөлөл • Гэр бүлийн гишүүдийн байгаль орчноо хайрлах, хамгаалах мэдлэг, туршлага • Мод, цэцэг тарьж, арчлах арга ухаан • Байгаль орчноо тохижуулах бүх нийтийн ажилд гэр бүлээрээ оролцох, оролцооны явцад хүүхдийг хүмүүжүүлдэг монгол уламжлал • Ажил хөдөлмөр, аливч хямгач зан чанарын тухай дуу, шүлэг, уран зохиол, оньсого, зүйр цэцэн үг • Байгаль эх орны сэдэвтэй дуу, шүлэг, магтаал	• Оюуны бие даах, харилцан бие биенээсээ суралцах, багаар ажиллах, өөртөө итгэлтэй байх чадвар, дадал эзэмшүүлнэ. • Суралцагч ойр орчноосоо асуудлыг олж харах, өөрөө эргэцүүлэн бодох, өөрөө суралцах, мэдлэгээ хэрэглэх, сонголт хийх, • Шийдвэр гаргахад суралцагчийн оролцоо • Бие даан төлөвлөх ба үйл ажиллагаа явуулах • Цаг агаарын мэдээлэл өдөр тутам уншиж мэдэх, бусдад мэдээлэх • Аюултай үзэгдлийг бичиж тэмдэглэх • Бусдын туршлагаас суралцах, бусдад зөвлөх, хамтран ажиллах • Байгаль орчноо хайрлах, хамгаалах тухай дуу, шүлэг, уран зохиол, оньсого, зүйр цэцэн үг цуглуулах, хүүхдэдээ уншиж өгөх, цээжлүүлэх • Тогтвортой хөгжлийн боловсролтой холбоотой хууль, тогтоомж, дүрэм журмыг бие даан судлан, тухайн асуудлаар урьдчилсан таамаглал, дүгнэлт гарган, багштайгаа болон хамтран ажиллах • Аав ээж, ах дүүгээ хүндлэх, үг сургаалыг нь дагах • Өтгөс, нялхаст энэрэнгүй хандах, санаа тавих, туслах	• Радио хичээл ашиглан бие даан суралцах • Үр дүнтэй харилцах (бичгээр болон амаар), бусадтай хамтран ажиллах • Зарим үзэгдэл, юмсын ирээдүйн байдлыг урьдчилан харах, таамаглах, цаг агаарыг шинжих ардын мэдлэгийг ашиглах <i>Жнь: Нар улайж мандвал Тэнгэр муухайрах Манан татаж эхэлбэл Үер болох</i> • Нар хүрээлбэл орохын тэмдэг • Сар хүрээлбэл хүйтэрхийн шинж • Гэр бүлээрээ байгаль орчноо хайрлан хамгаалахад хувь нэмрээ оруулах, нийтийн бүтээлч үйл ажиллагаанд дэмжин оролцох • Байгаль хамгаалах уламжлал, бусдын туршлагаас суралцах, амьдралд хэрэгжүүлэх • Байгаль хамгаалах орон нутгийн сайн дурын холбоо, нэгдэлд оролцох, хамтарч ажиллах

Үнэлгээ

Жишиг даалгаврын жишээ:

1. Унших, ярих чадвар

Эхийг уншаад асуултад хариулаарай.

Монголчууд бид онгон тансаг байгальтайгаа үлдсэн үлэмжийн их хувь заяатай ард түмэн билээ. Бидний бишрэх, бахархах, хайрлан хамгаалах юмны нэг нь энэ мөн.

Уламжлалаасаа сурах, түүнийг өвлүүлэх нь хэн хүнд хамаатай үйлс гэдгийг Байгаль орчныг хамгаалах тухай хуульд тусган оруулж, байгаль орчныг хамгаалах үндэсний уламжлал, зан

заншил эзэмшиж хэрэглэх, үр хүүхэддээ экологийн хүмүүжил олгох нь иргэн бүрийн үүрэг мөн гэжээ.

Энэрэл хүндэтгэлийн уламжлал нь гол төлөв газар нутаг, уул ус, ой мод, ан амьтан ургамлыг хайрлан хамгаалж амьдрал ахуйдаа тухайн хэрэглээний шаардлагад тохируулан туйлын ариг гамтай хэрэглэх арга ухааныг сургаж байсан гэж үзэж болно.

Байгаль орчиндоо энэрэл хүндэтгэлтэй хандаж ирсэн ёс заншлуудын дотроос нийтийг хамарсан хамгийн хүндэтгэлтэй зан үйл нь уул тайх ёслол байв.

- Эхэд юуны тухай өгүүлж байна вэ?
- Монголчууд бид ямар хувь заяатай ард түмэн вэ?
- Байгаль хамгаалах иргэний үүргийг та юу гэж ойлгодог вэ?
- Энэрэл хүндэтгэлийн уламжлал гэж юу вэ?

2. Эргэцүүлэмж, бодомж даалгавар

Эхийг уншаад эргэцүүлж, өөрийн хариултыг хэлнэ үү?

Цэцэрлэгч өвгөн хөвгүүдээ цэцэрлэгийн ажилд сургахсан гэж хүсдэг байжээ. Насан өөд болохын цагтаа хөвгүүдээ дуудан ирүүлж:

- Заа хүүхдүүд минь аавыгаа өнгөрсний дараа усан үзмийн цэцэрлэгт нуусан юмыг олж аваарай гэж захижээ. Хүүхдүүд эцгээ өнгөрсний дараа нуусан эрдэнийг нь олох гэж цэцэрлэгийн бүхий л газрыг онгичин ухжээ. Усан үзмийн газрыг дахин дахин ухавч эрдэнэ олдсонгүй.

- 1) Тэд яагаад эрдэнийг олж чадсангүй вэ?
- 2) Эрдэнэ яагаад олдоогүй юм бол.

Сэдвийн явц болон төгсгөлд суралцагчийг доорх жишээгээр үнэлж болно.

- Байгалийн үзэгдлүүдийг ухаарч, түүнд тохируулан амьдрах талаар хүүхэд, залууст тайлбарлан ярих
- Байгаль, цаг агаарыг хэрхэн тааварлан шинжих талаар мэдээлэл цуглуулж бүтээлийн дэвтэрт бичсэн эсэх
- Байгалийн гамшгийн төрөл хэлбэр, тохиолдсон үед хэрхэн хамгаалах талаар мэдээлэл цуглуулж бүтээлийн дэвтэртээ бичсэн эсэх, бусдад тайлбарлан ярих
- Байгалийн баялагтай зөв харьцах, жимс жимсгэнийг хэрхэн зөв түүх, боловсруулах аргачлал бүхий бяцхан ном хийсэн эсэх
- Байгалийн баялаг ашиглан өрхийн орлогоо нэмэгдүүлж болох талаар санаагаа эмх цэгцтэй бичиж тэмдэглэсэн эсэх
- Орон нутгийн ургамал, ан амьтны талаар мэдээлэл цуглуулж тэмдэглэсэн эсэх
- Байгаль орчинд үзүүлдэг хүний сөрөг нөлөөллийг тэмдэглэж, түүнд дүн шинжилгээ хийсэн эсэх
- Байгаль орчныг хамгаалах зорилготой баг, нөхөрлөл байгуулах төлөвлөгөө гаргасан эсэх
- Байгаль орчинд халтай үйл ажиллагаа явуулдаг хувь хүн, байгууллагад хандсан бичиг, уриалга гаргасан эсэх

Арга зүй

Суралцагчдад хийж бүтээх хэрэгцээ, сонирхлыг төрүүлэхүйц байдлаар үйл ажиллагааг төлөвлөн, сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэх, саналыг нь харгалзан баг, хэсгүүдэд хувааж хамтран ажиллах арга, эв дүйд сургах, зорилго чиглэлтэйгээр хичээлийг зохион байгуулж, суралцагчдад бүтээлч үйлийн, сэтгэлзүйн, материаллаг орчин бүрдүүлэх, сургалтын

хэрэглэгдэхүүн боловсруулах, дидактикийн оновчтой шийдэл хийх зэрэг бүхий л арга замаар сургалтыг эрчимжүүлэхдээ МХТ (мэдээлэл, харилцааны технологи)-ийг багш сургалт, үйл ажиллагаандаа байнга хэрэглэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Нэгж хичээлийн хөтөлбөрөө шинэчлэн боловсруулж, сургалтын чанарыг сайжруулахын тулд дараах зөвлөгөөг анхаарна уу:

- Хөтөлбөрийн зорилго, зорилтоо суралцагчдыг байгаль орчныг хайрлан хамгаалдаг, баялгийг зүй зохистой ашигладаг, хариуцлагатай, ёс зүйтэй иргэд болгон төлөвшүүлэхэд чиглүүлэн тодорхойлох;
- Байгалийн үзэгдэл, юмсын уялдаа холбоо, харилцан хамаарал, тоон хэмжээний өсөлт, бууралт (жишээлбэл, хотын хүн ам, айл өрх нэмэгдэхэд хотын агаарын бохирдол төдий хэмжээгээр ихэснэ, мод, бут төдий хэмжээгээр тарихад усны нөөц төдий хэмжээгээр ихсэх, цөлжилт төдий хэмжээгээр багасах, агаар дах хүчилтөрөгчийн хэмжээ нэмэгдэх гэх мэт)-тай холбоотой бодит бичвэр, мэдээлэл, тоон үзүүлэлтүүдийг тооны хичээлийн агуулгад интеграцчилан, бодлого дасгалын хэлбэрт оруулан ашиглах;
- Эзэмшсэн мэдлэг, чадвараа байгаль, нийгмийн харилцаандаа зөв хэрэглэх ур чадвар, дадал, хандлагатай болоход суралцагчдыг чиглүүлэх;
- Үнэлгээг боловсруулахдаа тухайн хичээлийн хүрээн дэх мэдлэг, чадварыг үнэлээд зогсохгүй хүүхэд, залуучуудын төлөвшил, бусадтай болон хүрээлэн буй орчинтой харилцах харилцаа, хандлага зэргийг тооцон үнэлэхэд анхаарах;
- Суралцагчдаар дамжуулан бусдад мэдээлэл өгөх, тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг сурталчлах хэрэгтэй. *Жишээ хувилбар : БИЕ ДААН СУРАЛЦАХ АРГА ЗҮЙ*

Бүлгээр болон багаар хамтарч суралцах нь бие даан суралцах үйл ажиллагаанд дэмжлэг болдог. Оролцогч бие даан суралцах явцдаа аливааг эргэцүүлэн бодож, шүүн тунгааж төлөвлөдөг. Түүнчлэн тэд өөрсдийн сурах үйл ажиллагаанд тодорхой хариуцлага хүлээх боломжтой. Дараах аргуудыг та бүхэн сургалтын явцад болон сургалтаас гадуур ашиглан бие даан суралцаж болно.

Ургуулан бодож, санаандаа төсөөлөх

Товч агуулга

Харааны төсөөллөөрөө суралцагчид нь өөрсдийн төлөвлөгөө, санаа бодлоо хөгжүүлж чаддаг. Энэ арга нь багаараа суралцахад бүтээлчээр үр өгөөжтэй тусалдаг.

Заавар:

1. Сэдвээ танилцуулна. Хичээлийг бүтээлч болгох үүднээс тэдний чармайлт, санаандаа төсөөлөх үйл ажиллагаагаар дэмжинэ гэдгийг тайлбарлана.
2. Суралцагчдыг нүдээ аниад тайван байдлаар болж буй үйл явцыг бодохыг зөвлө. Үр дүнд хүрэхийн тулд бүдэг гэрэл, намуухан хөгжим тавих хэрэгтэй.
3. Дараа нь тэднийг нүдээ аньсан хэвээрээ сарнай цэцгийн цоморлиг, өөрсдийн унтлагын өрөө, гэрлэн дохионы өөрчлөлт, эсвэл борооны дуслын дуу чимээ зэргийг дүрслэн, санаандаа төсөөлөхийг хүс.
4. Тэднийг ийнхүү алжаалаа тайлсны дараа, дараах сэдвүүдээр өөрсдийн төсөөллийг дүрслэн бүтээхийг хүс:
 - *Байгалийн сайхан*
 - *Цэвэр орчин*
 - *Байгалийн гамшигт үзэгдэл*
 - *Хог хаягдал*
5. Эдгээр дүрслэлийг гаргахын тулд суралцагчид өөрсдийн төсөөллийг ашиглах бололцоотой нам гүм орчинг бий болгох хэрэгтэй. Энэ үед бүхий л мэдрэхүйг ашиглах дараах асуултыг тавь. Та юу харсан бэ? Та юу мэдэрч байна?
6. Төсөөлөн дүрсэлж дууссаны дараа багийн гишүүд өөрсдийн дүрслэлээ эргэж санах даалгавар өгөх хэрэгтэй.
7. Суралцагчдыг жижиг бүлэг болгоод хоорондоо дүрслэл бий болгосон туршлагаа солилцохыг хүс.

8. Суралцагчдын туршлага дутагдсан үед дүрслэн бодох төсөөллийн үйл ажиллагааг удирдвал тэдний төсөөлөл амжилттай болно.

Хэрэглэгдэхүүн

- АББЗСҮТ “Эх дэлхий 3”, “Эх дэлхий 4” багц материалууд. УБ., 2009, 2010
- АББЗСҮТ “Байгалийн гамшгаас сэргийлье”. УБ., 2010
- Н.Нэргүй ба бусад, “Тогтвортой хөгжлийн боловсрол”, УБ, 2008.
- Б.Бурмаа ба бусад, “Багш нарт зориулсан гарын авлага”, Тогтвортой хөгжлийн боловсрол I хэсэг, УБ, 2008.
- Албан бус боловсролын сургалтын материал (CD 1) /Хүсвэл хог биш/, УБ., 2004
- Бүх нийтийн экологийн боловсрол –Үндэсний хөтөлбөр
- Ногоон орчин-бидний ирээдүй хөтөлбөр
- Ч.Аръяасүрэн, Х.Нямбуу. “Монгол ёс заншилийн их тайлбар толь” 1992 он.
- Албан бус боловсролын сургалтын материал /Цэвэр орчин –бидний амьдрал/, УБ., 2006
- “Уламжлалт байгаль хамгаалах арга ухаанаас” УБ, 2006 он.

3.5. МАЛ, МАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН

Хүлээгдэж буй үр дүн

- Мал маллах арга ухаан, түүний ашиг шимийг хүртэх сэтгэлгээ, аргуудыг хэрэглэн холбогдох мэдээллийг боловсруулах чадвартай болж, мал болон малчин хүний өмнө тулгамдаж буй аливаа асуудалд идэвхтэй оролцож учир шалтгааныг үндэслэлтэй тайлбарлан үзэл бодлоо хамгаалах, зөвшилцөх чадвартай болно.
- Мал маллах, түүний ашиг шимийг хүртэх арга ухаанд суралцаж, тулгарч буй бодит асуудалд үндэслэлтэй хандах, зүй тогтлыг танин мэдэх, аливаа өөрчлөлтийн талаар таамаглал дэвшүүлж үндэслэлтэй хандах чадвартай болно.
- Шинжлэх ухааны ололт, загвар, бусдын туршлага, арга ухаан, технологийг ашиглан мал маллах арга ухаандаа бүтээлчээр хандах, хэрэгцээт мэдээллийг боловсруулж ашиглах чадвартай болно.
- Танин мэдэхүйн болон хөдөлмөрийн үнэ цэнийг ойлгох, хамтын ажиллагааны давуу талыг мэдрэх, өөрийгөө хөгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй болохоос гадна бусдад нөлөөлөх, танин мэдэх хандлага төлөвшсөн байна.

Дэд сэдэв	Агуулга		
	Мэдлэг	Чадвар	Хэрэглээ
Мал маллах арга ухаан	- Малын халдварт болон халдваргүй өвчин, түүний шалтгаан - Шүлхий, боом, цэцэг, эргүү зэрэг өвчин үүсэх шалтгаан, тэдгээрээс сэргийлэх нь - Вакцины ач холбогдол - Мал үржүүлгийн арга	- Малыг эрүүл байлгахын ач холбогдлыг тайлбарлах - Нутгийн сайн малчны туршлагаас суралцах, дуурайх - Гадна шимэгчийг таних - Малын өвчний ангиллын схемд өвчнүүдийг ялгаж бичих - Байгаль цаг уурын өвөрмөц онцлогийг харгалзан ямар чиглэлийн малыг яаж үржүүлж өсгөх талаар	- Малын зарим халдварт өвчин хүнд халдах аюултайг зургаар илэрхийлснийг ашиглах - Ивомек тарианы ач холбогдол, зөв хэрэглээ - Арчилгаа, эдэлгээний алдаанаас үүсэх өвчнийг эдгээх, урьдчилан сэргийлэх талаар талаар ярилцах - Орон нутаг дахь өндөр ашиг шимтэй үүлдэр угсааны талаар мэдээлэл солилцох, малын захаас өндөр ашиг шимтэй малын шинжийг төрөл бүрээр нь ялган бичих - Бэлчээрийн мал аж ахуйг эрчимжсэн болгохын ач холбогдлыг бичих

		өөрийн санааг бичих, хамгаалах - Үхсэн малын сэг, зэмийг зайлуулах хялбар, эдийн засгийн хэмнэлтэй аргуудыг нэрлэх	- Эцэг малыг шилж сонгон сүрэгт тавих уламжлалт ёс заншлыг судлах, холбогдох билэн дэмбэрлийн болон зүйр цэцэн үгийг цээжлэх - Малын сэг, зэмийг зайлуулах арга, туршлагатай болсон байх
Малын хишиг буян	- Малын гаралтай бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн болгох нь - Малын гаралтай бүтээгдэхүүн-эрүүл хүнс	- Малын гаралтай түүхий эд боловсруулж байсан уламжлалт болон дэвшилтэт аргыг тайлбарлах - Цагаан идээ хийх уламжлалт аргыг номноос унших, гэрийн нөхцөлд ашиглах	- Ямааны ноолуур, хонины ноос, бодын хөөврөөр хийж болох ахуйн эд зүйлийн талаар арга туршлагаа солилцох - Сүү, сүүн бүтээгдэхүүний төрөл, зах зээл дэх ханшийг судлах, 1 өрхийн 1 жилийн хэрэгцээний сүүн бүтээгдэхүүн худалдан авах тооцоо гаргах - Ширдэг хийдэг технологийн талаар туршлага солилцох, ярилцах (нутгийн онцлог ялгааг гаргах) - Сүү сүүн бүтээгдэхүүнийг хэрхэн хийдэг талаар туршлага солилцох, бусаддаа заах

Үнэлгээ

Мэдлэг эзэмших ба ойлгох нь суралцагчийн өмнөх мэдлэгээс ихээхэн шалтгаалдаг үйл явц учраас сургалтын явцад багш байнга ажиглалт хийж, ахиц дэвшлийн талаар тэмдэглэл хөтлөх хэрэгтэй. Суралцагчийг үнэлэх олон хэлбэрээс (сорил, ярилцлага, асуулга, бүтээл, тэмдэглэл гэх мэт) сонгохоос гадна өөрийн үнэлгээг голлоно. Сургалтын өмнө түвшин тогтоох сорил болон бусад аргаар тэдний туршлага, мэдлэг, чадварыг илрүүлэх нь зүйтэй.

Хөтөлбөрийн дагуу сургалтыг зохион байгуулахдаа интеграцчилж суралцагчийн хандлага, үзэл хэрхэн өөрчлөгдөж буйгаар үнэлнэ.

Мөн кейс, жишээ тараан өгч тайлбарлуулан асуудал дэвшүүлсэн ярилцлага зохион байгуулж гарцыг хайж, амьдралаа дээшлүүлэх боломжуудыг хэрхэн судалсан байдлаар нь дүгнэх нь зөв. Жишээ нь:

1. Малын өвчнийг ангилах, схемчлэх

Жишээ нь:

Өвчнүүдийг харгалзах хүснэгтэд байрлуул

Боом, гуур, хувалз, бруцеллёз, дуут хавдар, шүлхий, цэцэг өвчин, савхан хорхой, галзуу, догол, хамуу, туруу сунах, хавчраа, мялзан, хатиар,

Адуу	Тэмээ	Үхэр	Хонь	Ямаа

2. Халдвартай болон халдваргүй өвчтэй малын гадаад шинжийг тодорхойлох

Жишээ нь:

Боом	Туруу сунах

--	--

3. Эрчимжсэн мал аж ахуйн ач холбогдлыг жишээгээр тайлбарлах

Бэлчээрийн үхэр	Фермерийн үхэр

4. Шилмэл, хэрэгцээний, зааз малын ангиллыг тайлбарлах, үр ашгийг тооцох

	Шилмэл мал	Хэрэгцээний мал	Зааз мал
Ангилал шалтгаан			
Үр ашиг			

гэх мэт...

5. Ямааг хэт өсгөснөөс үүссэн хохирлуудыг нэрлэж шалтгааныг тайлбарлан, ярих

	Нөлөөлөх нь	Үүсэх хохирол
Бэлчээрийн даац		
Сүргийн бүтэц		
Мал хариулга		
Эдийн засаг		
.....		

гэх мэт...

6. Малаас ашиглах зүйлсийг жагсаан бичиж тус бүрт нь юунд ямар хэлбэрээр ашигладгийг тайлбарлах

Жишээ нь:

Ашиг шим	Таван хошуу мал				
	Адуу	Тэмээ	Үхэр	Хонь	Ямаа
Ноос					
Мах					
Сүү					
Арьс					
Бусад					
Дүн					

гэх мэт...

Арга зүй

Бага дунд боловсролын дүйцсэн сургалтын хөтөлбөрийн арга зүйн хөгжлийн зарчимд үндэслэх ба агуулгын тогтолцооны хэсэг тус бүрт орон нутгийн онцлогийг тусгана.

Арга зүйн үндэс нь мэдлэг бүтээх хэрэгцээ бий болгох, мэдлэг бүтээх үйл ажиллагааг хамтаар үзэх, харах, ярилцах, бичих, зурах, унших ба хийж бүтээх гэх мэт үйлийн харилцааг тусгаж насанд хүрэгчдийн сэтгэлгээ, амьдралын туршлага гэх мэт онцлог зүйлийг анхааран арга зүйгээ багш сонгох хэрэгтэй.

Хөтөлбөрийн хүрээнд ашиглаж болох ном, сурах бичиг, гарын авлагыг хэрэглэн бие даан суралцана. Жишээ нь:

- Ц.Дамдинсүрэн **“Морь шинжээч Жомбоохүү”** өгүүллэгийг уншаад сургамжит хэсгийг түүж бичнэ үү гэсэн даалгавар өгч бичиг үсгийн сургалттай холбож өгөх, **“Хонио сайжруулья гэвэл хуцнаас нь, хотоо сайжруулья гэвэл бууцнаас нь”**

гэсэн ахмад малчдын үгийг өөрийн мал малладаг арга ухаантай хослуулан тайлбарлах гэх мэт даалгавар өгөөрэй.

- Таван хошуу малын тухайт зүйрлэсэн хэлц үг, зүйр үг, ертөнцийн гурав бичүүлэх. Мөн малтай холбоотой тайлал бүхий оньсого өөрсдөөр нь зохиолгох. Зураглал хийлгэж, үгийн сүлжээ зохиолгож суралцагч хооронд нь таалгах идэвхтэй аргуудаас ашиглах хэрэгтэй. Жишээ нь хэлц үг:

Үхэр шиг зүтгэх/дөргүй сарлаг шиг/ – өөрийн санаагаар муйхарлах

Шаварт унасан шарын эзэн – өөрийн юм өргүй гэх утга

-Зараалын морь – үнэгүй зарах, зарагдах

-Нуруугаа авсан морь – халирч хаширсан

-Тэмээнээс тэмдэгтэй – ил тод, тод томруун, тодорхой

-Гувшаа хурга шиг – идэж уухаас хоцордоггүй хүнийг

-Зуун ямаанд жаран ухна – зохицолгүй

Хэвшмэл хэлц:

Эрдэм багатын омог их

Ишгэн ухны гүйдэл их

Хонины сэлбэг ямаа

Хоолны сэлбэг ногоо

Буруу өссөн хүүхэд

Бухын хүзүүнээс хатуу

Номхон тэмээ

Ноолоход амархан

Ажил хийж хүн болдог

Ар давж хүлэг болдог гэх мэтээр цааш үргэлжлүүлэн зохиолгож, мөн хэлц үгээр эх зохиох даалгавар өгөх хэрэгтэй. Хэлц үгээр эх зохиолгох нь тухайн суралцагчийн сэтгэх, бичих, төсөөлөх гээд олон чадварыг илрүүлдэг сайн талтайг бодох хэрэгтэй.

- Таван хошуу малын тухай үг хэллэгүүдийг хэлүүлж бичүүлэх. Жишээ нь:

№	Хонийг насаар нь нэрлэх	Тайлбар
1	Хурга	Тус жилийн төл
2	Хөгэй	Өвлийн хурга
3	Сэнс	Эртийн хөрвө хурга
4	Төлөг	2 настай
5	Зусаг	2-3 насны эм хүйст хонь
6	Хөрвөө	Хурганы өөр дуудлага
7	Хэнз	Хожуу төрсөн хурга
8	Хавчиг хурга	Эрт гарсан хурга
9	Тахлай хурга	Өвлийн хурга
10	Бабрай хурга	Хөгөөс өмнө гарсан хурга
11	Төлөгний хурга	Хөгийн хугацаанаас хойш гарсан
12	Ихэр хурга	Нэг эхээс хамт гарсан 2 хурга
13	Шүдлэн хонь	2 настай хонь буюу төлөг
14	Хязаалан хонь	3 настай хонь
15	Соёолон	4 настай хонь
16	Ирэг	Хязаалангаас дээш насны зассан эр хонь
17	Бүдүүн хонь	Нас гүйцсэн хонь
18	Амбан ирэг	Сүрэгтээ толгойлсон бүдүүн ирэг

гэх мэтээр 5 хошуу малыг нас шүдээр нь нэрлүүлэн бичүүлж харьцуулах арга хэрэглэх.

- **“Монголчууд хонины ноосыг ноолуураас илүү чанартай, үнэтэй болгож чадвал ямар ямар давуу талууд гарах вэ?, манай нутагт энэ ажлыг зохион байгуулах боломж бий юу”** гэх зэрэг асуудал дэвшүүлсэн асуулт тавьж орон нутгийн онцлогтой холбон ярилцаж, мэтгэлцээн зохиож болно.
- Малын өвчний шинж тэмдэг, үүсгэгчийн талаар зурагт үзүүлэн ашиглах.
- Малын зүсийг онцгой тэмдэг, дүр байдал, зан аашаар нь ялган бичүүлэх. Жишээ нь:

Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
-------	------	------	------	------

-Хавтгай бөхтэй, -Ханан ширээ бөхтэй -Бархираа -Зулардаг -Ороо -Хоргодоо -Жонжоо -Хатуу хамарт -Идэмхий гм.				
--	--	--	--	--

гэх мэтээр цааш нөхүүлэн бичүүлж, харилцан ярилцах.

Хэрэглэгдэхүүн

- “Билгийн нүд-1”. АББЗСҮТ. УБ, 2008.
- “Билгийн нүд-2”. АББЗСҮТ, УБ, 2006.
- “Билгийн нүд-3”. АББЗСҮТ, УБ, 2008.
- Д.Баттогтох “Таван эрдэнийн тэгш сүрэг мину” УБ, 2009
- Д.Ганбаатар. “Эзэн сайтын мал эрүүл” УБ, 2005.
- “Мал аж ахуйн үндэс”. Сурах бичиг. УБ, 1988.
- Ж.Самбуу “Мал аж ахуй дээр яаж ажиллах тухай ардад өгөх
сануулга, сургааль” /1946/,
- Ж.Самбуу “Малчдад өгөх зөвлөгөө” /1958/,
- Ж.Самбуу “Малчдын амьдрал, ахуй, хэв заншлаас” /1971/

НОМ ЗҮЙ

- АББЗСҮТ, ДАНИДА, Хөдөөгийн сургуулийн хөгжил төсөл, “Амьдрах ухаан” Албан бус боловсролын сургалтын хөтөлбөр, УБ, 2004
- АББЗСҮТ, Албан бус боловсролын сургалтын хөтөлбөрүүд, УБ, 2005
- АББЗСҮТ, ЮНЕСКО, “Албан бус болон насанд хүрэгчдийн боловсрол” онол-арга зүй, УБ, 2008
- “Албан бус болон насанд хүрэгчдийн боловсрол” гарын авлага. АББЗСҮТ. УБ, 2009
- АББЗСҮТ, ЮНИСЕФ, “Амьдрах ухааны сургалтын хөтөлбөр”, УБ, 2008
- Алтанцэцэг Д. нар, “Бага, дунд боловсрол – эрүүл мэндийн боловсрол”, УБ, 2004
- Д.Баттогтох “Таван эрдэнийн тэгш сүрэг мину” УБ, 2009
- БСШУЯ, “Эрүүл мэндийн боловсролын стандарт”, УБ, 2005
- Д.Гүндэгмаа нар, Билгийн нүд, бичиг үсгийн цуврал сурах бичиг, УБ., 2003, 2006, 2008
- Монгол улсын Үндсэн хууль, УБ., 1992
- Д.Ганбаатар. “Эзэн сайтын мал эрүүл” 2005 он. УБ хот.
- “Эрүүл хүнс эмнээс чухал”. АББЗСҮТ, УБ, 2006
- “Мал аж ахуйн үндэс”. Сурах бичиг. 1988 он. УБ хот
- Д.Мэнджаргал, З.Батсүх, Ж.Байгалмаа “Малын эрүүл мэнд”. 2001 он. УБ хот
- Малын хишиг буян. I, II 2000 он. УБ хот.
- “Холимог бүлгийн сургалтын арга зүй”. АББЗСҮТ, УБ, 2009
- UNESCO Bangkok, Manual for Developing Literacy and Adult Education Programmes in Minority Language Communities, 2004
- UNESCO Bangkok, Mother Tongue-based Literacy Programme, 2009
- ACCU, New Guidebook for Development and Production of Literacy Materials, 1992
- APPEAL, Training Materials for Literacy Personnel, 1988
- ACCU and others, “Development of Basic Literacy Learning Materials for Minority Peoples in Asia and the Pacific” Final Report of the 2nd Sub-Regional Workshop, 1994.
- APPEAL & UNESCO, Guidebook (1) for the Development of a Literacy Programme Based on ATLP, 2000
- UNESCO Bangkok, First Language First: Community-based Literacy Programmes for Minority Language Contexts in Asia, 2005
- www.agrosoft.bravejournal.com